

Буд Мэндсайхан
Юрий Юлианович Дгебуадзе
Сүрэнхорлоо Пүрэвдорж

МОНГОЛ ОРНЫ ЗАГАСНЫ ЛАВЛАХ

Энэхүү загасны лавлах бичиг нь Монгол орны нуур, голд тархан амьдрах 79 зүйл, дэд зүйлийн загас болон дугариг амтаны ерөнхий шинж, биологийн онцлог, амьдрах орчин, тархац нутаг, хамгааллын статусын талаарх тодорхой мэдээллийг агуулсан бөгөөд их дээд сургуулийн оюутнууд, загас судалдаг, сонирхдог, экологич, биологич, бүх хүмүүст зориулав.

Bud Mendsaikhan
Yury Yulianovich Dgebuadze
Purevdorj Surenkhorloo

GUIDE BOOK TO MONGOLIAN FISHES

This reference book contains information on 79 species and subspecies of fishes and lampreys of Mongolian waters. For each species and subspecies, a brief morphological description, biology, habitats, conservation status and distribution (range within Mongolia) are given. This reference book is intended for a variety of users such as college and university students, ichthyologists, people whose hobby is fish, ecologists and specialists involved in nature conservation.

ДАА 597
ННА 28.6
М- 965

© Зохиогчийн эрх

© Б. Мэндсайхан, ШУА-н Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Усны нөөц, ус ашиглалтын салбар /
B. Mendsaikhan, Department of Water resource and consumption of Institute of Geography-Geoeology, MAS
© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар / World Wide Fund for
Nature (WWF) Mongolia Programme Office

© Зургийн зохиогчийн эрх: фото | зурмал | тархалтын газрын зураг

Фото зураг: Mark H. Sabaj Perez., David A. Neely, М. Эрдэнэбат, Б. Мэндсайхан, А.М. Прокофьев,
Zeb Hogan | Fish photos are credited to: Mark H. Sabaj Perez., David A. Neely, M. Erdenebat, B.
Mendsaikhan, A.M. Prokofiev.

Зурмал зураг: А. Лаврова | Original drawings made by A. Lavrova.

Тархалтын газрын зураг: Монгол орны Загасны улаан данс (2006)-ны газрын зургийн өгөгдлийг
сайжруулан боловсруулсан Б. Мэндсайхан, Ж. Мөнхбат | B. Mendsaikhan and J. Munkhbat
developed fish distribution maps which from the Fish Red List of Mongolia (2006) database.

Хавтасны зураг: Л. Баярсайхан | Cover photo provided by L. Bayarsaikhan

Эх бэлтгэсэн: Х. Балдандорж | Designed by Kh. Baldandorj

Иш татах/citation:

Мэндсайхан, Б., Дгебуадзе, Ю., Ю., Сүрэнхорлоо, П. 2017. Монгол орны загасны лавлах. Дэлхийн
байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар. Улаанбаатар. Адмон. Хх. 203
Mendsaikhan, B., Dgebuadze, Yu., Yu., Surenkhorloo, P. 2017. Guide book to Mongolian fishes. World Wide
Fund for Nature (WWF) Mongolia Programme Office. Ulaanbaatar. Admon. Pp. 203.

ISBN: 978-99978-938-0-2

ГАРЧИГ - CONTENTS

Өмнөх үг - Foreword	6
Удиртгал - Introduction	8
Амьдрах орчин - Habitats	12
Загасны биеийн гадаад бүтэц - Fish morphology	18
Зүйлийн ангилалзүйн нэршил - Fish species and taxonomy	19

PETROMYZONTIDAE - ХОРХОЙ ЗАГАСНЫХАН - LAMPREYS

<i>Lethenteron reissneri</i> (Dybowski, 1869) • Хорхой загас • Far Eastern brook lamprey	24
--	----

ACIPENSERIDAE - ХИЛЭМИЙНХЭН - STURGEONS

<i>Acipenser baerii</i> Brandt, 1869 • Шивэр хилэм • Siberian sturgeon	26
<i>Acipenser schrenckii</i> Brandt, 1869 • Амарын хилэм • Amur sturgeon	28

SALMONIDAE - ХУЛДЫНХАН - SALMONIDS

<i>Brachymystax lenok</i> (Pallas, 1733) • Шөвгөр хоншоорт зэвэг • Sharp-snouted lenok	30
<i>Brachymystax tumensis</i> Mori, 1930 • Мөнхор хоншоорт зэвэг • Blunt-snouted lenok	32
<i>Hucho taimen</i> (Pallas, 1773) • Ердийн тул • Taimen	34

COREGONIDAE - ЦАГААСАГЫНХАН - WHITEFISHES

<i>Coregonus autumnalis</i> (Pallas, 1776) • Байгалийн омуль • Baikal omul	36
<i>Coregonus chadary</i> Dybowski, 1862 • Цагаан хадир • Khadary-whitefish	38
<i>Coregonus lavaretus pidschian</i> (Gmelin, 1788) (= <i>C. pidschian</i>) • Цагаан загас • Arctic whitefish, pidschian	40
<i>Coregonus peled</i> (Gmelin, 1789) • Бух зарам • Peled	42

THYMALLIDAE - ХАДРАНГИЙНХАН - GRAYLINGS

<i>Thymallus arcticus</i> (Pallas, 1776) • Шивэр хадран • Arctic grayling	44
<i>Thymallus brevirostris</i> Kessler, 1879 • Монгол хадран • Mongolian grayling	46
<i>Thymallus grubei</i> Dybowski, 1869 • Амарын хадран • Amur grayling	48
<i>Thymallus nigrescens</i> Dorogostaiskiy 1923 • Хөвсгөл хадран • Khuvsgul grayling	50
<i>Thymallus svetovidovi</i> Knizhin & Weiss, 2009 • Дээд Енисейн хадран • Upper Yenisei grayling	52

ESOCIDAE - ЦУРХАЙНХАН - PIKES

<i>Esox lucius</i> Linnaeus, 1758 • Ердийн цурхай • Northern pike	54
<i>Esox reichertii</i> Dybowski, 1869 • Амарын цурхай • Amur pike	56

CYPRINIDAE - МӨРӨГИЙНХӨН - CYPRINIDS

<i>Abramis brama</i> (Linnaeus, 1758) • Зоодой • Common bream	58
<i>Abbottina rivularis</i> (Basilewsky, 1855) • Хятадын хуурамч гүрц • Chinese false gudgeon	60
<i>Acheilognathus asmussi</i> (Dybowski, 1872) (= <i>Acantorhodeus asmussi</i>) • Хатгуурт харваа загас • Amur spiny bitterling	62

<i>Carassius carassius</i> (Linnaeus, 1758) • Алтлаг хэлтэг • Crucian carp	64
<i>Carassius gibelio</i> (Bloch, 1782) • Мөнгөлөг хэлтэг • Prussian carp	66
<i>Chanodichthys erythropterus</i> (Basilewsky, 1855) (= <i>Erythroculter erythropterus</i>) • Цагаан догтор • Red fin culter	68
<i>Chanodichthys mongolicus</i> (Basilewsky, 1855) (= <i>Erythroculter mongolicus</i>) • Монголын улаан далбаат • Mongolian culter	70
<i>Stenopharyngodon idella</i> (Valenciennes, 1844) • Цагаан амар • Grass carp	72
<i>Culter alburnus</i> Basilewsky, 1855 • Өлгөр цагаан • Topmouth culter	74
<i>Cyprinus carpio haematopterus</i> Temminck et Schlegel, 1846 • Булуу цагаан • Amur carp	76
<i>Gnathopogon strigatus</i> (Regan, 1908) • Сугасан гүрц • Manchurian gudgeon	78
<i>Gobio gobio cynocephalus</i> Dybowski, 1869 • Шивэр гүрц • Dog-faced gudgeon	80
<i>Gobio albipinnatus tenuicarpus</i> Mori, 1934 • Сахалт гүрц • Eastern white fin gudgeon	82
<i>Gobio gobio acutipinnatus</i> Menschikov, 1939 • Ердийн гүрц • Markakul gudgeon	84
<i>Gobio soldatovi tungusicus</i> Borisov, 1928 • Солдаговын гүрц • Soldatov's gudgeon	86
<i>Hemibarbus labeo</i> (Pallas, 1776) • Морин тавхарал • Barbel steed	88
<i>Hemibarbus maculatus</i> Bleeker, 1871 • Толбот морин загас, Морин харвал • Spotted steed	90
<i>Hemiculter leucisculus warpachovskii</i> Nikolskii, 1903 • Амарын хавчигас • Buir sharpbelly	92
<i>Hypophthalmichthys molitrix</i> (Valenciennes, 1844) • Дух давхаа • Silver carp	94
<i>Ladislavia taczanowskii</i> Dybowski, 1869 • Владислав, Тачановын гүрц • Taczanowski's gudgeon	96
<i>Leuciscus leuciscus baicalensis</i> (Dybowski, 1874) • Шивэр сугас • Siberian dace	98
<i>Leuciscus dzungaricus</i> (Koch and Paerke, 1998) • Зүүнгарын сугас • Dzhungarian dace	100
<i>Leuciscus idus</i> (Linnaeus, 1758) • Бух сугас • Ide	102
<i>Leuciscus waleckii</i> (Dybowski, 1869) • Амарын сугас • Amur ide	104
<i>Microphysogobio tungtingensis</i> (Nichols, 1926) (= <i>Rostrogobio amurensis</i>) • Буйрын мөнхор гүрц • Long-nosed gudgeon	106
<i>Oreoleuciscus humilis</i> Warpachowski, 1889 • Алтайн давжаа сугас	
Голын хэлбэр • Altai's Dwarf Osman Dwarf form	108
Нуурын хэлбэр • Altai's Dwarf Osman Lake form	110
<i>Oreoleuciscus potanini</i> (Kessler, 1879) • Потанины Алтайн сугас • Potanin's Altai Osman	
Нохой сугас • Piscivorous form	112
Шар сугас • Herbivorous form	114
Шөвгөр хоншоорт хэлбэр • Sharp-snouted form	116
<i>Oreoleuciscus</i> sp. • Сэлэнгийн Алтайн сугас • Selenga's Altai Osman	118
<i>Phoxinus percnurus</i> (Pallas, 1814) • Нуурын варлан • Lake minnow	120
<i>Phoxinus phoxinus</i> (Linnaeus, 1758) • Ердийн варлан • Eurasian minnow	122
<i>Rhynchocypris czekanowskii</i> Dybowski, 1869 • Чекановын варлан • Czekanowski's minnow	124
<i>Rhynchocypris lagowskii</i> (Pallas, 1814) (= <i>Phoxinus lagowskii</i>) • Лаговын варлан • Lagowskii's minnow	126
<i>Pseudaspius leptcephalus</i> (Pallas, 1776) • Улаан живэрт • Redfin	128
<i>Pseudorasbora parva</i> (Temminck et Schlegel, 1846) • Амарын хөөлөнхэй • Stone moroko	130
<i>Rhodeus sericeus</i> (Pallas, 1776) • Халбаган жараа, Цэнхэр жараахай • Bitterling	132
<i>Rutilus rutilus</i> (Linnaeus, 1758) • Улаан нүдэн • Roach	134
<i>Sarcocheilichthys soldatovi</i> (Berg, 1914) (= <i>Chilogobio czerskii</i>) • Солдаговын уруулт гүрц • Soldatov's thicklip gudgeon	136
<i>Saurogobio dabryi</i> Bleeker, 1871 • Хадаасан гүрц • Chinese lizard gudgeon	138
<i>Squalidus chankaensis</i> (Dybowski, 1872) (= <i>Gnathopogon chankaensis</i>) • Ханхын гүрц • Khanka gudgeon	140
<i>Tinca tinca</i> (Linnaeus, 1758) • Шаргал үхэрдээ • Tench	142

BALITORIDAE - ЭРЭЭЛЖИЙНХЭН - BALITORIDAE

<i>Barbatula</i> (= <i>Orthrias</i>) <i>toni</i> (Dybowski, 1869) • Шивэр сахалт эрээлж • Siberian stone loach	144
<i>Barbatula</i> (= <i>Orthrias</i>) <i>dgebuadzei</i> (Ptokofiev, 2003) • Говийн сахалт эрээлж • Dgebuadzei's stone loach	146

<i>Barbatula</i> (= <i>Orthrias</i>) <i>golubtsovi</i> (Prokofiev, 2003) • Голубцовын сахалт эрээлж • Golubtsovi's stone loach	148
<i>Barbatula</i> (= <i>Orthrias</i>) <i>dsapchynensis</i> Prokofiev, 2016 • Завханы сахалт эрээлж • Dsapchynensis's stone loach	150
<i>Barbatula</i> (= <i>Orthrias</i>) <i>conilobus</i> Prokofiev, 2016 • Конилобусын сахалт эрээлж • Conilobus's stone loach	152
<i>Lefua costata</i> (Kessler, 1876) • Найман сахалт эрээлж • Lefua	154
<i>Triplophysa gundriseri</i> Prokofiev, 2002 (= <i>Nemacheilus dorsalis numilis</i> Gundr., n. <i>strauchi</i> (non Kessler)) • Тэсийн эрээлж • - Gundriseri's spotted thicklip loach	156
<i>Triplophysa gundriseri chandagaitensis</i> • Гундризерийн эрээлж • Chandagaity's spotted thicklip loach	158
<i>Triplophysa arnoldii</i> • Арнолдын трифлориза/эрээлж • Arnoldi's spotted thicklip loach	160

COBITIDAE - ЯРАЛЖИЙНХАН - COBITIDS

<i>Cobitis melanoleuca</i> Nicols, 1925 (= <i>C. taenia</i> & <i>C. taenia sibirica</i>) • Шивэр чимхүүр загас • Siberian spiny loach	162
<i>Cobitis olivai</i> • Оливын чимхүүр загас • Olivai's spiny loach	164
<i>Cobitis lebedevi</i> • Лебедевын чимхүүр загас • Lebedevi's spiny loach	166
<i>Misgurnus mohoity</i> (Dybowski, 1869) • Амарын моголзой • Amur weatherfish	168

SILURIDAE - ЦУЛБУУРТЫНХАН - SHEATFISHES

<i>Parasilurus asotus</i> (Linnaeus, 1758) • Амарын цулбуурт • Amur catfish	170
---	-----

LOTIDAE – ГУТААРИЙНХАН - LOTIDS

<i>Lota lota</i> (Linnaeus, 1758) • Гутаарь • Burbot	172
--	-----

PERCIDAE – АЛГАНЫХАН - PERCIDS

<i>Perca fluviatilis</i> Linnaeus, 1758 • Голын алгана • European perch	174
---	-----

GOBIIDAE – ЗАНТГАР ЗАГАСНЫХАН - GOBIES

<i>Rhinogobius lindbergi</i> Berg, 1933 • Амарын зантгар • Amur goby	176
--	-----

ODONTOBUTIDAE - ЦООХЛОЙХОН - FRESHWATER SLEEPERS

<i>Perccottus glenii</i> Dybowski, 1877 • Тогтмолын цоохлой • Amur sleeper	178
--	-----

COTTIDAE - ЖИВЭРТИЙНХЭН - COTTIDS

<i>Cottus sibiricus</i> Kessler, 1889 • Шивэр эрэн живэрт • Siberian sculpin	180
<i>Cottus szanaga</i> Dybowski, 1869 (= <i>C. poecilopus</i>) • Амарын эрэн живэрт • Siberian bullhead	182
<i>Mesocottus haitej</i> (Dybowski, 1869) • Зантгар загас • Amur sculpin	184
<i>Paracottus</i> (= <i>Leocottus</i>) <i>kesslerii</i> (Dybowski, 1874) • Кесслерийн зантгар • Kessler's sculpin	186

Монгол орны загасны зүйлүүдийн хамгааллын статус - Conservation status for fish species of mongolia	188
Талархал - Acknowledgement	193
Ашигласан материал - Reference	195
Нэрийн хэлхээс - Name index	200

ӨМНӨХ ҮГ

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш өдгөө 25 жилийн нүүрийг үзээд байна. Энэ хугацаанд бидний хэрэгжүүлсэн үйл ажиллагаа маань байгаль хамгааллын тухайд хэрэгжүүлж болох ба болохгүйн хэм хэмжээг буюу байгаль орчны хуулийн орчныг боловсронгуй болгох, нэгэнт тодорхой болсон хэм хэмжээг хэрэгжүүлэх, сахиулах ажилд төр, засгийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай судалгаа шинжилгээг дэмжих, иргэд, төрийн ба төрийн бус байгууллагуудын ажилтан, мэргэжилтэн нарт зориулсан сургалт зохион байгуулах зэрэг төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ирлээ. Эдгээрийн дотроос байгаль хамгааллын мэдээлэл сурталчилгааны ажлууд нэн ялангуяа байгаль орчныг танин мэдэх, хамгаалах ажилд хүүхэд, залуучууд, төр засаг, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах асуудлыг манай байгууллага төрөл бүрээр дэмжсээр ирснийг иргэд болоод эрдэмтэн мэргэд, судлаач нар андахгүй бизээ.

Энэ удаад ч гэсэн “Монгол орны загасны лавлах” бүтээлийг хэвлүүлэн гаргах ажилд дэмжлэг үзүүлж байгаадаа баяртай байна. Үүний зорилго нь их энгийн. Хүн ямарваа нэгэн юмыг хичнээн их мэднэ, төдий хэмжээгээр сонирхоно. Цаашлаад сонирхол нэмэгдэхийн хирээр төдий хэмжээгээр шинжлэх ухаанч байдлаар тухайн асуудалд хандана. Чухам энэ цэг буюу ямарваа нэгэн асуудалд шинжлэх ухаанч байдлаар хандах гэдэг нь бидний зүгээс байгаль орчинд хандах хандлага бөгөөд энэ байдлаар иргэд маань ч байгаль орчны асуудалд хандаж байгаасай гэж хүсдэг.

Иргэд, олон нийт болон энэ чиглэлээр сонирхон ажиллаж байгаа хүмүүст зориулан энэхүү бүтээлийг зохиосон зохиогч нарт талархлаа илэрхийлье.

Байгаль орчноо хайрлан дээдлэх санаа сэтгэл уншигчид бат сууж, зохиогчийн сэтгэл цэлмэх болтугай.

*Д. Батболд,
Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь хөтөлбөрийн газрын захирал*

FOREWORD

It has been spent 25 years since the World Wide Fund for Nature (WWF) launched its first actions in Mongolia. Within this period of time, the WWF-Mongolia has implemented in the country a variety of conservation efforts including providing wide-ranging support in strengthening of legal and regulatory framework of the environmental sector and advancing enforcement of the legislation through promoting governmental and non-governmental organizations in compliance of the legal and regulatory norms and standards in practice, assisting in onsite research and monitoring, organizing necessary refreshment and capacity building trainings for the governmental and non-governmental organizations and local communities. Amongst, communications activities in particular environmental educational and awareness-raising activities for children, youth, governmental institutions, and civil society organizations in the country are a vital part of our continual efforts which has been well recognized by our partners including national researchers, scientists and environmentalists.

At this time, we are pleased to support publication of “Guide book to Mongolian fishes”. An aim of this intention is very simple. The better understanding, the deeper passion. The deeper passion, the more effort in figuring out and approaching in a scientific way. The latest or the scientific approach is our way of working in environmental conservation. We wish that everyone approached in this way to the environmental conservation.

We would like to thank the authors of this publication for the public including those who are specifically interested in it.

May our readers have full of enthusiasm and motivation to protect the nature and environment and the authors of this publication feel at ease.

*D. Batbold
Country Director
WWF-Mongolia*

УДИРТГАЛ

Загасны аймаг нь сээр нуруутан амьтдын дотроос зүйлийн бүрдлээр хамгийн баялаг бөгөөд далай, тэнгис, нуур, цөөрөм, гол, горхи тэр битгий хэл агуйн ус болон гүний худгийн усанд ч тархан амьдардаг.

Загас нь усанд заламгайгаараа амьсгалж, сэлүүрийн тусламжтайгаар сэлж, бие нь ясархаг ялтас буюу хайрсаар хучигдсан хүйтэн цуст амьтад юм.

Загас хэмээх ерөнхий нэршилд эрүүгүй загас болох миксин хэлбэртэн (Muxini), дугариг амтан, миног (Petromyzontia), мөгөөрст загас (Chondrichthyes), яст загас (Osteichthyes) гэсэн хоорондоо ялгаатай дөрвөн бүлэг сээр нуруутан багтдаг. Одоогоос 500 сая жилийн өмнө эртний загас анхдагч эрүүт сээр нуруутнаас үүссэн. Манай гариг дээр 32,000 зүйлийн загас тэмдэглэгдээд байгаагийн 95% нь яст загасанд хамаарагддаг байна.

Загас нь хүнсний уурагт бүтээгдэхүүн болохынхоо хувьд хүн төрөлхтөний амьжиргаанд асар их үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас (FAO) дэлхийн хүн ам 50 жилийн өмнө жилд 80-90 сая тонн загас олборлож байснаа загасны хэрэглээ нь өнөөгийн байдлаар 158 сая тонн болж өсч байгаа энэхүү ханаагүй тосны хүчлийн агууламж ихтэй, А, Д, Е бүлгийн амин дэм, төрөл бүрийн эрдэс бодисоор баялаг, шингэц сайтай байгалийн гаралтай түүхий эдийн эрэлт жилээс жилд ихэсч байгааг харуулж байна.

Монгол орны загасны ангилал зүй, биологи, экологи, паразитолог, генетикийн судалгаанд А. Дашдорж, М.М. Кожов, А.А. Томилов, А. Дулмаа, А. Цэндсүрэн, Я. Цэнд-Аюуш, Г. Баасанжав, П.Я. Тугарина, А.Н. Демин, Ю.Ю. Дгебуадзе, Б. Нансалмаа, В.И. Лапин, В.Я. Ермохин, Н.И. Рябов, Р. Эргенс, К. Пивчинка, Н.М. Пронин, В.Я. Трофименко, Ш. Пэрэнлэйжамц, О.Н. Пугачёва, М. Эрдэнэбат, Ю.В. Слынько нарын эрдэмтэн судлаачид үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан байдаг (Дашдорж, 1974; Дулмаа, Нансалмаа, 1974; Баасанжав бусад 1983; Баасанжав бусад 1985; Дгебуадзе, 1992, 1995; Цэнд-Аюуш, Баасанжав 2001).

Монгол орны нутаг дэвсгэрт 1975 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн Орос-Монголын хамтарсан биологийн иж бүрэн экспедицийн гидробиологи, загас судлалын экспедицийн судалгааны үр дүнд “Рыбы МНР” (1983); “Экология и хозяйственное значение рыб МНР” (1985), “Лимнология и палеолимнология” (1994, 2014), “Редкие животные Монголии (Позвоночные)” (1996), “Водные экосистемы бассейна Селенги” (2009) зэрэг цуврал бүтээлүүдийг гаргасан байна.

Судалгаа шинжилгээний дүн, уур амьсгалын дулаарал, хүний өсөн нэмэгдэх үйл ажиллагааны нөлөөгөөр (загас нутагшуулалт) Монгол орны загасны зүйлийн бүрэлдэхүүн нэмэгдсэнээр өнөөгийн байдлаар 79 зүйл, дэд зүйл тэмдэглэгдээд байна. Эдгээр нь 8 баг, 1 дэд баг, 15 овог, 47 төрөлд хамаарагдаж байна.

“Дорнод Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах ба тогтвортой хөгжлийн арга зам” төслийн хүрээнд үндэсний боловсон хүчнүүд “Монгол орны загас” бүтээлийг 2001 онд, Дэлхийн байгаль хамгаалах холбооноос эмхэтгэн гаргасан ховор зүйлийн шалгууруудыг бүс нутгийн хэмжээнд үнэлэх аргачлалыг ашиглан 64 унаган зүйлд тулгараад байгаа бэрхшээл болон газар зүйн тархалтын талаар бодит мэдээллийг багтаасан “Монгол орны загасны улаан данс”, “Монгол орны загас хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл”-ийг хэвлүүлэн гаргасан нь мэдээллийг түгээх ажилд онцгой ач холбогдол өгсөн.

Энэ номонд Орос-Монголын хамтарсан биологийн иж бүрэн экспедицийн хүрээнд сүүлийн 30 жилд цуглуулсан зарим зүйл загасны дээж материалыг боловсруулан үр дүнг оруулсан.

Энэхүү лавлах номонд Монгол оронд тархан амьдрах 79 зүйл, дэд зүйл загасны ерөнхий шинж, биологийн онцлог, амьдрах орчин, тархац, хамгааллын статусын талаарх сүүлийн үеийн мэдээллийг монгол, англи хэл дээр дурьдан, тархацын тойм зураг, зүйлийн зургийг өнгөтөөр оруулж өгсөн болно.

Энэхүү номыг Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн (ДБХС) Монгол дахь Хөтөлбөрийн Газар санхүүжүүлсэн болно.

Бидний бэлдсэн энэхүү лавлахад алдаа мадаг байхыг үгүйсгэхгүй бөгөөд уншигч авхай та өөрийн мэргэн саналаа bmendee@yahoo.com хаягаар илгээнэ үү.

Зохиогчид

INTRODUCTION

By number of species, fish are the largest group among vertebrates, inhabiting oceans, seas, lakes, ponds, rivers, streams and even cave water bodies.

Fish are cold-blooded aquatic animals which use gills to breathe, swim using fins, and are usually covered with protective scales or bony plates.

Under the general classification of fish two classes may be distinguished: cartilaginous fishes (Chondrichthyes), and bony fishes (Osteichthyes). Traditionally, along with fish, two other classes of lower vertebrates: hagfishes (Myxini), and lampreys (Petromyzontes) are covered. In this Guide book, we have also applied to lamprey. The earliest fishes evolved from primitive jawed vertebrates more than 500 million years ago. On our planet more than 32,000 fish species are described, 95% of which are bony fishes.

Fish are an important component of aquatic ecosystems. In food webs they are consumers of both plant and animal food and often play an important regulatory role.

According to an FAO report, fifty years ago world fisheries provided 80-90 tons of fish annually, and today that number has increased to 158 million tons. This number indicates the increased annual demand for fish consumption, as they are a rich source of easily digested, high-quality proteins containing all essential amino acids, essential fats (e.g. long-chain omega-3 fatty acids), vitamins (A, D and E), and many minerals and microelements. Thus, fishes play a significant role in human livelihood.

Many ichthyologists: A. Dashdorj, M.M. Kojov, A.A. Tomilov, A. Dulmaa, A. Tsendsuren, Ya. Tsend-Ayush, G. Baasanjav, P.Ya. Tugarina, A.N. Demin, Yu. Yu. Dgebuadze, B. Nansalmaa, V.I. Lapin, V.Ya. Yermokhin, N.I. Ryabov, R. Ergens, K. Pivnička, N.M. Pronin, V.Ya. Trophimenko, Zh. Perenleijamts, O.N. Pugacheva, M. Erdenebat and Yu. V. Slynko, have made invaluable contributions to the classification, morphological, ecological, and parasitological studies of the fishes of Mongolia (Dashdorj, 1974; Dulmaa, Nansalmaa, 1974; Baasanjav et al 1983; Baasanjav et al 1985; Dgebuadze, 1992, 1995; Tsend-Ayush, Baasanjav 2001).

An important stage in the study of fish in Mongolia was the establishment in 1975 of an ichthyological and hydrobiological team under the Joint Russian-Mongolian Complex Biological Expedition of the Russian and Mongolian Academies of Sciences (JRMCBE). Among the notable results of the JRMCBE's work was the publication of a number of books: "Fishes of the Mongolian People's Republic" (1983), "Ecology and Economic Potential of the Fishes of the Mongolian People's Republic" (1985),

“Limnology and Paleolimnology of Mongolia” (1994, 2014), “Rare Animals of Mongolia (Vertebrates) (1996), and “Aquatic Ecosystems of the Selenga River Basin” (2009).

As a result of scientific research, spreading due to climate warming and human influence (intentional introductions), the number of fish species in Mongolia has increased, and currently stands at 79 species and sub-species. They include 8 orders, 1 suborder, 15 families, and 47 genera.

Publication of “The Mongolian Red List of Fishes” and “Summary Conservation Action Plans for Mongolian Fishes,” containing the most accurate available information on ranges and significant threat processes for 64 native species which have been assessed using the Guidelines for Application of IUCN Red List Criteria at Regional Levels published by The World Conservation Union, and “Fishes of Mongolia” published in 2001, developed by national experts under the “Biodiversity Conservation and Sustainable Development Action Plan of Eastern Mongolia” project, demonstrate the importance of dissemination of this information.

In this book we have mainly used the results of our studies from the last 30 years based on materials collected in JRM CBE.

This reference book contains recent information (both in Mongolian and English) on the morphology, biological characteristics, habitats, distribution, conservation status, illustrated with color maps of ranges and pictures of 79 species and subspecies of Mongolian fishes.


This book is sponsored by World Wide Fund for Nature (WWF) Mongolia Programme Office.

Comments and notifications of errors or inaccuracies are welcome, and may be e-mailed to bmendee@yahoo.com.

The Authors

АМЬДРАХ ОРЧИН - HABITATS

Ази тивийн усны хагалбар Монгол орныг дайран өнгөрөхдөө тус улсын нутаг дэвсгэр дэх гол горхи, нуур цөөрмийг Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсацгүй гэх гурван том ай савд хуваадаг. Эдгээр 3 ай савын нуур, голуудад тархан амьдрах загасны бүрэлдэхүүн өөр өөр байдаг. Манай оронд тархан амьдрах загас нь загасны газарзүйн мужлалаар Палеарктикийн, Амарын шилжүүр мужид хамаарна (Зураг 1). Палеарктикийн муж нь Циркумполья, уулархаг Азийн гэсэн хоёр дэд мужид хуваагддаг. Төв Азийн гадагш урсгалгүй ай савд тэмдэглэгдсэн Потанины Алтайн сугас (*Oreoleuciscus potanini*) болон Алтайн давжаа сугас нь (*Oreoleuciscus humilis*) цэнгэг болон давстай нуурт тархан амьдрах чадвартай бол бусад загас нь зөвхөн цэнгэг усанд тархан амьдарна.



Зураг 1. Монгол орны загасны газарзүйн мужлалын схем зураг

А. Палеарктикийн мужийн Циркумполья дэд мужийн

А1. Умард мөсөн далайн ай савд багтах:

1. Сэлэнгэ мөрний сав газар,
2. Шишхэд голын сав газар,
3. Булган голын сав газар,

Б. Палеарктикийн мужийн Азийн дэд мужийн

Б1. Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах:

4. Тэс голын сав газар,
5. Их нууруудын хотгор,
6. Говийн хөндийн нуурууд,

В. Амарын шилжүүр мужийн

В1. Номхон далайн ай савд багтах :

7. Онон голын,
8. Хэрлэн голын сав газар,
9. Халх голын сав газар

Монгол орны нууруудад тархан амьдрах загасны зүйлийн бүрдэл нь нуурын гарал үүсэл, тодорхой ай савд тархан амьдрахаас хамааран харилцан адилгүй байдаг. Жишээлбэл, Амар мөрний савд хамаарагдах Буйр нуурт 30 гаруй зүйлийн загас тархсан байдаг бол Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нуурт 2-3 зүйл загас тархан амьдардаг.

Голын гульдралын дагуу загасны тархац харилцан адилгүй байдаг. Голын эх нь шим тэжээлээр ядмаг, урсгал ширүүн, урсгалын хурд ихтэй тул хүчилтөрөгчөөр баялаг байдаг. Монгол орны Хойд мөсөн далайн болон Номхон далайн ай савын голуудад цэнгэг усны индикатор тул, зэвэг, хадран, сахалт эрээлж загас зонхилон тархдаг. Харин доошлох тусам өргөсөн, гүн болж шим тэжээлээр баялаг болох тул түүнийг даган сэлэх хурд багатай, орчны өөрчлөлтийг тэсвэрлэх чадвартай тогтмол усанд амьдрах зохилдлого бүхий загасны бүлгэмдэл зонхилно. Энэ хэсэгт загасны зүйлийн бүрдэл ч ихсэнэ. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын голуудын эхэнд Монгол хадран болон сахалт эрээлж загас зонхилон тархдаг бол голын доод хэсэгт Алтайн сугас загас давамгайлдаг.

The Central Asian hydrographic net within Mongolia is formed by three major basins: Arctic Ocean, Pacific Ocean, and Central Asian Internal Drainage Basin. The fish fauna inhabiting these three water basins vary respectively. Fishes distributed in Mongolia belong to the Palearctic and Amur range in terms of their geographic region (Fig 1). The Palearctic Region is divided into Circumpolar and Asian Mountainous Subregions.

A. Palearctic Region, Circumpolar Subregions

- A1. Arctic Ocean basin:
1. Selenga River Basin
 2. Shishkhed River Basin
 3. Bulgan River Basin

B. Palearctic Region, Asian Mountainous Subregion:

- B1. Central Asian Internal Drainage Basin
4. Tes River Basin
 5. Great Lakes Hollow
 6. Lake Valley

C. Amur Range

- C1. Pacific Ocean Drainage
7. Onon River Basin
 8. Kherlen River Basin
 9. Khalkh River Basin

Potanin's Altai Osman (*Oreoleuciscus potanini*) and Dwarf Altai Osman (*Oreoleuciscus humilis*) are endemic species recorded in the Central Asian Internal Drainage Basin, viable in both fresh and saline lakes, while other fish species are found only in fresh water.

The fish species composition in Mongolian lakes is associated first and foremost with the history of their formation and their inhabiting a particular water basin. Thus, Buir Lake in the Amur Basin numbers about 30 fish species, while some lakes of the Central Asian Internal Drainage Basin are inhabited by only 2-3 species.

Distribution of fishes in water currents varies along the river continuum. The upper reaches are poor in nutrients, with rapidly-moving streams, rich in oxygen due to fast flow. In these habitats of Mongolian rivers which belong to Arctic ocean and Pacific ocean basins indicator fishes such as taimen, lenok, grayling and stone loach predominate. Downstream, rivers become wider, deeper and richer in nutrients; thus, fish communities adapted to still waters increase resiliency in environmental change and swim at lesser speeds. The fish fauna of those places are more diverse. In rivers of Central Asian Internal Drainage basin in upper reaches dwell Mongolian grayling and stone loaches, while in downstream Altai osmans are dominant.

АМЬДРАХ ОРЧИН (гол, нуур, далан, хиймэл нуур) - HABITATS (river, lake, dam, reservoir)



Хөвсгөл аймаг, Сэлэнгэ мөрөн
Khuvsgul aimag, the Selenga River



Хэнтий аймаг, Хэрлэн гол
Khentii aimag, the Kherlen River



Хөвсгөл аймаг, Уйлан гол
Khuvsgul aimag, the Uilgan River




Ховд аймаг, Ховд гол, Сэжигтэйн хавцал
Khovd aimag, the Khovd River, Sejigtein canyon



Дорнод аймаг, Халх гол
Dornod aimag, the Khalkh River



Баянхонгор аймаг, Байдраг гол
Bayankhongor aimag, the Baidrag River



Хөвсгөл аймаг, Хөвсгөл нуур
Khuvsgul aimag, Khuvsgul Lake



Ховд аймаг, Хар нуур
Khovd aimag, Khar Lake



Баянхонгор аймаг, Бөөн Цагаан нуур
Bayankhongor aimag, Buun Tsagaan Lake



Архангай аймаг, Тэрхийн Цагаан нуур
Arkhangai aimag, Terkhiin Tsagaan Lake



Говь-Алтай аймаг, Тайширын УЦС-ын
усан сан буюу Гэгээ нуур
Govi-Altai aimag, Reservoir of the Taishir
Hydropower or Gegee Lake





Дорнод аймаг, Буйр нуур
Dornod aimag, Buir Lake

ЗАГАСНЫ ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ - COMPOSITION OF FISHES

БАГ	ORDERS	ЗҮЙЛ/SPECIES
ДУГАРИГ АМТАН	PETROMYZONTIFORMES	1
ХИЛЭМТЭН	ACIPENSERIFORMES	2
ЯРГАЙТАН	SALMONIFORMES	12
ЦУРХАЙТАН	ESOCIFORMES	2
МӨРӨГТӨН	CYPRINIFORMES	53
САГАМХАЙТАН	GADIFORMES	1
АЛГАНАТАН	PERCIFORMES	3
ЖИВЭРТЭН	SCORPAENIFORMES	4
ЦУЛБУУРТАН	SILURIFORMES	1

ЗАГАСНЫ БИЕЙН ГАДААД БҮТЭЦ -FISH MORPHOLOGY



Зураг/Figure 2. Загасны биеийн гадаад бүтэц-Fish morphology: Атуух (эр) ба атуу (эм)-Male (♂) and Female (♀): 1=Нурууны сэлүүр-Dorsal fin (D) (a-салаалаагүй/spines rays; b – салаалсан/branched soft rays); 2=Цээжний сэлүүр- Pectoral fin (P); 3=Хэвлийн сэлүүр- Pelvin fin (V); 4- Сүвийн сэлүүр- Anal fin (A); 5=Сүүлний сэлүүр-Caudal fin (C); 6=Сүүлний баригул-Caudal peduncle; 7=Хажуугийн шугам-Lateral line; 8=Заламгайн хавхлаг-Operculum; 9=Хамрын сүв-Nostril; 10=Өөхөн сэлүүр-Adipose fin.

ЗҮЙЛИЙН АНГИЛАЛ ЗҮЙН НЭРШИЛ - FISH SPECIES AND TAXONOMY

Scientific name	Mongolian	Common name
АНГИ I. PETROMYZONTES - ЭРҮҮГҮЙТЭН ЗАГАС - Lampreys		
БАГ I. PETROMYZONTIFORMES - ДУГАРИГ АМТАН - LAMPREYS		
Овог. 1. PETROMYZONTIDAE Bonaparte, 1832 - ХОРХОЙ ЗАГАСНЫХАН - LAMPREYS		
Төрөл 1. <i>Lethenteron</i> Creaser et Hubbs, 1922 - Номхон далайн хорхой загас - Lampreys		
1. <i>L. reissneri</i> (Dybowski, 1869)	- Хорхой загас	Far Eastern brook lamprey
PISCES - ЗАГАС		
АНГИ II. OSTEICHTHYES - ЯСТ ЗАГАС - BONY FISH		
ДЭД АНГИ. ACTINOPTERYGII - ДЭВҮҮР СЭЛҮҮРТ ЗАГАС - RAY-FINNED FISHES		
БАГ II. ACIPENSERIFORMES – ХИЛЭМТЭН - STURGEONS		
Овог. 2. ACIPENSERIDAE Bonaparte, 1832 - ХИЛЭМИЙНХЭН - STURGEONS		
Төрөл 2. <i>Acipenser</i> Linnaeus, 1758 - Хилэм - Sturgeons		
2. <i>A. baerii</i> Brandt, 1869	- Шивэр хилэм	- Siberian sturgeon
3. <i>A. schrenckii</i> Brandt, 1869	- Амарын хилэм	- Amur sturgeon
БАГ III. SALMONIFORMES - ЯРГАЙТАН - SALMONIFORMES		
Овог. 3. SALMONIDAE Rafinesque, 1815 - ХҮЛДЫНХАН - SALMONIDS		
Төрөл 3. <i>Brachymystax</i> Gunter, 1866 - Зэвэг - Lenoks		
4. <i>B. lenok</i> (Pallas, 1733)	- Шөвгөр хоншоорт зэвэг	- Sharp-snouted lenok
5. <i>B. tumensis</i> Mori, 1930	- Монхор хоншоорт зэвэг	- Blunt-snouted lenok
Төрөл 4. <i>Hucho</i> Gunter, 1866 - Тул - Taimen		
6. <i>H. taimen</i> (Pallas, 1773)	- Ердийн тул	- Taimen
Овог. 4. COREGONIDAE Core, 1872 - ЦАГААСАГЫНХАН - WHITEFISHES		
Төрөл 5. <i>Coregonus</i> Lacepede, 1804 - Цагаан загас - Whitefishes		
7. <i>C. autumnalis</i> (Pallas, 1776)	- Байгалийн омуль	- Baikal omul
8. <i>C. chadary</i> Dybowski, 1862	- Цагаан хадир	- Khadary-whitefish
9. <i>C. lavaretus pidschian</i> (Gmelin, 1788) (= <i>C. pidschian</i>)	- Цагаан загас	- Arctic whitefish, pidschian
10. <i>C. peled</i> (Gmelin, 1789)	- Бух зарам	- Peled
Овог. 5. THYMALLIDAE Gill, 1884 - ХАДРАНГИЙНХАН - GRAYLINGS		
Төрөл 6. <i>Thymallus</i> Link, 1790 - Хадран - Graylings		
11. <i>Th. arcticus</i> (Pallas, 1776)	- Шивэр хадран	- Arctic grayling

- | | | |
|--|-----------------------|--------------------------|
| 12. <i>Th. brevirostris</i> Kessler, 1879 | - Монгол хадран | - Mongolian grayling |
| 13. <i>Th. grubei</i> Dybowski, 1869 | - Амарын хадран | - Amur grayling |
| 14. <i>Th. nigrescens</i> Dorogostaisky 1923 | - Хөвсгөл хадран | - Khuvsgul grayling |
| 15. <i>Th. svetovidovi</i> Knizhin & Weiss, 2009 | - Дээд Енисейн хадран | - Upper Yenisei grayling |

ДЭД БАГ I. ESOCOIDEI - ЦУРХАЙТАН - PIKES

Овог 6. ESOCIDAE Cuvier, 1816 - ЦУРХАЙНХАН - PIKES

Төрөл 7. *Esox* Linnaeus, 1758 - Цурхай - Pikes

- | | | |
|---|-----------------|-----------------|
| 16. <i>E. lucius</i> Linnaeus, 1758 | - Ердийн цурхай | - Northern pike |
| 17. <i>E. reichertii</i> Dybowski, 1869 | - Амарын цурхай | - Amur pike |

БАГ IV. CYPRINIFORMES - МӨРӨГТӨН - CYPRINIFORMES

Овог 7. CYPRINIDAE Bonaparte, 1832 - МӨРӨГИЙНХӨН - CYPRINIDS

Төрөл 8. *Abbottina* - Хятадын хуурамч гүрц - Abbotina

- | | | |
|--|------------------------|-------------------------|
| 18. <i>A. rivularis</i> (Basilewsky, 1855) | - Хятадын хуурамч гүрц | - Chinese false gudgeon |
|--|------------------------|-------------------------|

Төрөл 9. *Abramis* Cuvier, 1816 - Зоодой - Breams

- | | | |
|--------------------------------------|----------|----------------|
| 19. <i>A. brama</i> (Linnaeus, 1758) | - Зоодой | - Common bream |
|--------------------------------------|----------|----------------|

Төрөл 10. *Acheilognathus* Dybowski, 1872 - Хатгуурт харваа - Amur spiny bitterlings

- | | | |
|---|-------------------------|-------------------------|
| 20. <i>A. asmussi</i> (Dybowski, 1872)
(= <i>Acantorhodeus asmussi</i>) | - Хатгуурт харваа загас | - Amur spiny bitterling |
|---|-------------------------|-------------------------|

Төрөл 11. *Carassius* Jarocki, 1822 - Хэлтэг - Crucian carps

- | | | |
|--|-------------------|-----------------|
| 21. <i>C. carassius</i> (Linnaeus, 1758) | - Алтлаг хэлтэг | - Crucian carp |
| 22. <i>C. gibelio</i> (Bloch, 1782) | - Мөнгөлөг хэлтэг | - Prussian carp |

Төрөл 12. *Chanodichthys* Bleeker, 1859 - Цагаан догтор - Red fin culters

- | | | |
|---|--------------------------|--------------------|
| 23. <i>C. erythropterus</i> (Basilewsky, 1855)
(= <i>Erythroculter erythropterus</i>) | - Цагаан догтор | - Red fin culter |
| 24. <i>C. mongolicus</i> (Basilewsky, 1855)
(= <i>Erythroculter mongolicus</i>) | - Монголын улаан далбаат | - Mongolian culter |

Төрөл 13. *Ctenopharyngodon* Steindachner, 1866 - Цагаан амар - Grass carps

- | | | |
|---|---------------|--------------|
| 25. <i>C. idella</i> (Valenciennes, 1844) | - Цагаан амар | - Grass carp |
|---|---------------|--------------|

Төрөл 14. *Culter* Basilewsky, 1855 - Өлгөр - Culters

- | | | |
|---|----------------|-------------------|
| 26. <i>C. alburnus</i> Basilewsky, 1855 | - Өлгөр цагаан | - Topmouth culter |
|---|----------------|-------------------|

Төрөл 15. *Cyprinus* Linnaeus, 1758 - Мөрөг - Carps

- | | | |
|---|----------------|-------------|
| 27. <i>C. carpio haematopterus</i> Temminck et Schlegel, 1846 | - Булуу цагаан | - Amur carp |
|---|----------------|-------------|

Төрөл 16. *Gnathopodon* Bleeker, 1859 - Сугасан гүрц - Far East gudgeons

- | | | |
|---------------------------------------|----------------|----------------------|
| 28. <i>G. strigatus</i> (Regan, 1908) | - Сугасан гүрц | - Manchurian gudgeon |
|---------------------------------------|----------------|----------------------|

Төрөл 17. *Gobio* Cuvier, 1816 - Гүрц - Gudgeons

- | | | |
|---|--------------|---------------------|
| 29. <i>G. gobio cynocephalus</i> Dybowski, 1869 | - Шивэр гүрц | - Dog-faced gudgeon |
|---|--------------|---------------------|

30. *G. albiginnatus tenuicarpus* Mori, 1934 - Сахалт гүрц - Eastern white fin gudgeon
31. *G. gobio acutipinnatus* Menschikov, 1939 - Ердийн гүрц - Markakul gudgeon
32. *G. soldatovi tungusicus* Borisov, 1928 - Солдатовын гүрц - Soldatov's gudgeon

Төрөл 18. *Hemibarbus* Bleeker, 1859 - **Морин загас** - Steeds

33. *H. labeo* (Pallas, 1776) - Морин тавхарал - Barbel steed
34. *H. maculatus* Bleeker, 1871 - Морин харвал - Spotted steed

Төрөл 19. *Hemiculter* Bleeker, 1859 - **Хавчигас** - Sharpbellies

35. *H. leucisculus warpachovskii* Nikolskii, 1903 - Амарын хавчигас - Buir sharpbelly

Төрөл 20. *Hypophthalmichthys* Bleeker, 1859 - **Давх** - Silver carps

36. *H. molitrix* (Valenciennes, 1844) - Дух давхаа - Silver carp

Төрөл 21. *Ladislavia* Dybowski, 1869 - **Владислав, Тачановын гүрц** - Ladislavias

37. *L. taczanowskii* Dybowski, 1869 - Владислав, Тачановын гүрц - Taczanowski's gudgeon

Төрөл 22. *Leuciscus* Cuvier (ex Klein), 1816 - **Сугас** - Daces

38. *L. leuciscus baicalensis* (Dybowski, 1874) - Шивэр сугас - Siberian dace
39. *L. dzungaricus* (Koch and Paepke, 1998) - Зүүнгарын сугас - Dzhungarian dace
40. *L. idus* (Linnaeus, 1758) - Бух сугас - Ide
41. *L. waleckii* (Dybowski, 1869) - Амарын сугас - Amur ide

Төрөл 23. *Mycrophysogobio* Mori, 1934 - **Мөнхор гүрц** - Long-nosed gudgeons

42. *M. tungtingensis* (Nichols, 1926) (= *Rostrogobio amurensis*) - Буйрын мөнхор гүрц - Long-nosed gudgeon

Төрөл 24. *Oreoleuciscus* Warpachowski, 1889 - **Алтайн сугас** - Altai osmans

43. *O. humilis* Warpachowski, 1889 - Алтайн давжаа сугас - Алтай's Dwarf Osman
Голын хэлбэр - Dwarf form
Нуурын хэлбэр - Lake form
44. *O. potanini* (Kessler, 1879) - Потанины Алтайн сугас - Potanin's Altai Osman
Нохой сугас - Piscivorous form
Шар сугас - Herbivorous form
Шөвгөр хоншоорт хэлбэр - Sharp-snouted form
45. *Oreoleuciscus* sp. - Сэлэнгийн Алтайн сугас - Selenga's Altai Osman

Төрөл 25. *Phoxinus* Rafinesque, 1820 - **Ердийн варлан** - Minnows

46. *P. percnurus* (Pallas, 1814) - Нуурын варлан - Lake minnow
47. *P. phoxinus* (Linnaeus, 1758) - Ердийн варлан - Eurasian minnow

Төрөл 26. *Rhynchocypris* Gunther, 1889 - **Варлан** - Minnows

48. *R. czekanowskii* Dybowski, 1869 - Чекановын варлан - Czekanowski's minnow

49.	<i>R. lagowskii</i> (Pallas, 1814) (= <i>Phoxinus lagowskii</i>)	- Лаговын варлан	- Lagowskii's minnow
Төрөл 27. <i>Pseudaspius</i> Dybowski, 1869 - Улаан живэрт - Redfins			
50.	<i>P. leptocephalus</i> (Pallas, 1776)	- Улаан живэрт	- Redfin
Төрөл 28. <i>Pseudorasbora</i> Bleeker, 1860 - Хөөлөнхэй - Stone morokos			
51.	<i>P. parva</i> (Temminck et Schlegel, 1846)	- Амарын хөөлөнхэй	- Stone moroko
Төрөл 29. <i>Rhodeus</i> Agassiz, 1832 - Халбаган загас - Bitterlings			
52.	<i>R. sericeus</i> (Pallas, 1776)	- Халбаган жараа, Цэнхэр жараахай	- Bitterling
Төрөл 30. <i>Rutilus</i> Rafinesque, 1820 - Улаан нүдэн - Roaches			
53.	<i>R. rutilus</i> (Linnaeus, 1758)	- Улаан нүдэн	- Roach
Төрөл 31. <i>Sarcocheilichthys</i> Bleeker, 1859 - Хар гүрц - Thicklip gudgeons			
54.	<i>S. soldatovi</i> (Berg, 1914) (= <i>Chilogobio czerskii</i>)	- Солдатовын уруулт гүрц	- Soldatov's thicklip gudgeon
Төрөл 32. <i>Saurogobio</i> Bleeker, 1870 - Хадаасан гүрц - Lizard gudgeons			
55.	<i>S. dabryi</i> Bleeker, 1871	- Хадаасан гүрц	- Chinese lizard gudgeon
Төрөл 33. <i>Squalidus</i> Dybowski, 1872 - Ханхын гүрц			
56.	<i>S. chankaensis</i> (Dybowski, 1872) (= <i>Gnathopogon chankaensis</i>)	- Ханхын гүрц	- Khanka gudgeon
Төрөл 34. <i>Tinca</i> Cuvier, 1816 - Үхэрдээ - Tenches			
57.	<i>T. tinca</i> (Linnaeus, 1758)	- Үхэрдээ	- Tench
Овог 8. BALITORIDAE Swainson, 1839 - ЭРЭЭЛЖИЙНХЭН - BALITORIDAE			
Төрөл 35. <i>Barbatula</i> Linck, 1790 (= <i>Orthrias</i>) - Сахалт эрээлж - Stone loaches			
58.	<i>B. (=O.) toni</i> (Dybowski, 1869)	- Шивэр сахалт эрээлж	- Siberian stone loach
59.	<i>B. (=O.) dgebuadzei</i> (Ptokofiev, 2003)	- Говийн сахалт эрээлж	- Dgebuadzei's stone loach
60.	<i>B. (=O.) golubtsovi</i> (Prokofiev, 2003)	- Голубцовын сахалт эрээлж	- Golubtsovi's stone loach
61.	<i>B. (=O.) dsapchynensis</i> Prokofiev, 2016	- Завханы сахалт эрээлж	- Dsapchynensis's stone loach
62.	<i>B. (=O.) conilobus</i> Prokofiev, 2016	- Конилобусын сахалт эрээлж	- Conilobus's stone loach
Төрөл 36. <i>Lefua</i> Herzenstein, 1888 - Наймас эрээлж - Eightbarbel loaches			
63.	<i>L. costata</i> (Kessler, 1876)	- Найман сахалт эрээлж	- Lefua
Төрөл 37. <i>Triplophysa</i> Kessler, 1874 - Эрээлж - Spotted thicklip loaches			
64.	<i>T. gundriseri</i> Prokofiev, 2002 (= <i>Nemacheilus dorsalis numilis</i>)	- Тэсийн эрээлж	- Gundriseri's spotted thicklip loach
65.	Gundr., n. <i>strauchi</i> (non Kessler) <i>T. g. chandagaitensis</i>	- Гундризерийн эрээлж	- Chandagaity's spotted thicklip loach
66.	<i>T. arnoldii</i>	- Арнолдын эрээлж	- Arnoldi's spotted thicklip loach

Овог 9. COBITIDAE Swainson, 1838 - ЯРАЛЖИЙНХАН - COBITIDS

Төрөл 38. *Cobitis* Linnaeus, 1758 - Яралж - Spiny loaches

67. *C. melanoleuca* Nicols, 1925 - Шивэр чимхүүр загас - Siberian spiny loach
(=*C. taenia* & *C. taenia sibirica*)
68. *C. olivai* - Оливын чимхүүр загас - Olivai's spiny loach
69. *C. lebedevi* - Лебедевын чимхүүр загас - Lebedevi's spiny loach

Төрөл 39. *Misgurnus* Lacepede, 1803 - Моголзой - Weatherfishes

70. *M. mohoity* (Dybowski, 1869) - Амарын моголзой - Amur weatherfish

БАГ V. SILURIFORMES - ЦУЛБУУРТАН - CATFISH

Овог 10. SILURIDAE Cuvier, 1816 - ЦУЛБУУРТЫНХАН - SHEATFISHES

Төрөл 40. *Parasilurus* Bleeker, 1862 - Алс дорнодын цулбуурт - Amur catfishes

71. *P. asotus* (Linnaeus, 1758) - Амарын цулбуурт - Amur catfish

БАГ VI. GADIFORMES - САГАМХАЙТАН - CODS

Овог 11. LOTIDAE Jordan et Evermann, - ГУТААРИЙНХАН - LOTIDS

Төрөл 41. *Lota* Oken, 1817 - Гутаарь - Barbots

72. *L. lota* (Linnaeus, 1758) - Гутаарь - Burbot

БАГ VII. PERCIFORMES - АЛГАНАТАН - PERCH-LIKES

Овог 12. PERCIDAE Cuvier, 1816 - АЛГАНЫХАН - PERCIDS

Төрөл 42. *Perca* Linnaeus, 1758 - Цэнгэг усны алгана - Perches

73. *P. fluviatilis* Linnaeus, 1758 - Голын алгана - European perch

Овог 13. GOBIIDAE Cuvier, 1816 - ЗАНТГАР ЗАГАСНЫХАН - GOBIES

Төрөл 43. Genus: *Rhinogobius* T.N. Gill, 1859 - Амарын зантгар - Amur gobies

74. *Rhinogobius lindbergi* Berg, 1933 - Амарын зантгар - Amur goby

Овог 14. ODONTOBUTIDAE Hoese et Gill, 1993 - ЦООХЛОЙХОН - FRESHWATER SLEEPERS

Төрөл 44. *Percottus* Dybowski, 1877 - Тогтмолын цоохлой - Amur sleepers

75. *P. glenii* Dybowski, 1877 - Тогтмолын цоохлой - Amur sleeper

БАГ VIII. SCORPAENIFORMES - ЖИВЭРТЭН - SCORPAENIFORMS

Овог 15. COTTIDAE Bonaparte, 1832 - ЖИВЭРТИЙНХЭН - COTTIDS

Төрөл 45. *Cottus* Linnaeus, 1758 - Эрээн живэрт - Sculpins

76. *C. sibiricus* Kessler, 1889 - Шивэр эрээн живэрт - Siberian sculpin
77. *C. szanaga* Dybowski, 1869 - Амарын эрээн живэрт - Siberian bullhead
(=*C. poecilopus*)

Төрөл 46. *Mesocottus* Gratzianow, 1907 - Зантгар - Amur sculpins

78. *M. haitej* (Dybowski, 1869) - Зантгар загас - Amur sculpin

Төрөл 47. *Paracottus* - Кесслерийн зантгар - Sculpins

79. *P. kesslerii* (Dybowski, 1874) - Кесслерийн зантгар - Kessler's sculpin

ХОРХОЙ ЗАГАС, ДУГАРИГ АМТАН

Lethenteron reissneri Dybowski, 1869

Far Eastern brook lamprey



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу хар бор, хэвлий цайвар, гэдэс цагаан. Бие хорхой хэлбэртэй, цилиндр, хайрсгүй. Нүдний ард хоёр хажуугаараа заламгайн 7 сүвтэй. Хамрын ганц сүв нүдний өмнө оршино. Хос сэлүүрүүд байхгүй. Нурууны сэлүүр хоёр, хоорондоо бага зэрэг тусгаарлагдсан. Эрүүгүй. Дээд ялтсанд 2 шүд, доод ялтсанд 6-11 шүд, хажуугийн хэсгийн шүдний томъёо нь, гол төлөв 2-2-2; урдаа 1-2 эгнээ, урд талын эхний эгнээнд 4-5 шүдтэй, урд талд нийт 38-44 шүд, хэлний хөндлөн ялтсанд 13 шүд, хэлний босоо ялтас тус бүр 7-8 шүдтэй. Дугариг ам нь бумбадан сорох зохилдлоготой. Хажуугийн шугам нөсөөжөөгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Монгол оронд тархан амьдрах дугариг амтаны биеийн урт 23-48 см хүрнэ. Атуух (эр) нь атуугаасаа (эм) арай жижиг. 3 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 5 сарын сүүлч 6 сарын эхээр голын ширүүн урсгал хэсэгт хайрга-элсэрхэг, чулуутай хэсэгт түрсээ шахна. 50-90 мянган түрс гаргана. Түрсний диаметр (голч) 0.46 мм. Органик ялзмаг, замгаар холлоно.



АМЬДРАХ ОРЧИН

Голын амьдралын хэвшилтэй. Голын тогтуун урсгалтай, хайрга чулуу, элсэрхэг ёроол хэсэг мөн эргийн ургамалтай хэсэгт тархан амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Онон, Балжийн голд тархан амьдарна.



DESCRIPTION

Body dark brown on the back, lighter below, and white on belly. Worm-like bodies, cylindrical, without scales. There are seven gill openings on either side behind the eye. Lampreys have a single nostril in front of eyes. No paired fins. Two dorsal fins are more closely linked together. Jawless. Far Eastern brook lamprey has supraoral lamina, 2 unicuspid teeth; infraoral lamina, 6-11 unicuspid teeth; endolateral formula, typically 2-2-2; 1-2 rows of anterials; first row of anterials, 4-5 unicuspid teeth; total number of anterials, 38-44 unicuspid teeth; transverse lingual lamina, 13 unicuspid teeth, longitudinal lingual laminae each with 7-8 unicuspid teeth. Jawless mouth is used as a circular sucking disc. Lateral line unpigmented.

BIOLOGY

The lamprey in Mongolia can reach 23-48 cm. Males is smaller than females. Sexual maturity is attained in 3 years old. Spawning period in Mongolia continues from end of May to early June. Lays eggs in riffles on gravel-sand or stone bottom. The fecundity in Mongolian populations is 50-90 thousands eggs per female. Diameter of eggs is 0.46 mm. Feeds on algae and detritus.

HABITAT

Clear streams with moderate current over gravel or sand and in shore with plant debris.

CONSERVATION STATUS

Not applicable.

DISTRIBUTION

Recorded in Onon and Balj rivers of the Pacific Ocean basin.

ШИВЭР ХИЛЭМ

Acipenser baerii Brandt, 1869
Siberian sturgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн зүс бараан хүрэн, хэвлий цайвар шар. Бие уртавтар, ээрүүл хэлбэртэй, нурууг дагасан нэг эгнээ, биеийн хоёр талаар, хэвлийг дагасан нэг эгнээ, бүгд 5 эгнээ ясжсан товхтой. Товхны тоо нуруунд 12-19, биеийн хоёр хажууд 26-44, хэвлийд 9-15. Товхон эгнээний хооронд жижиг ялтас ба ясжсан будаалгатай. Хошууны доод талд байрласан саран хэлбэрийн амтай. Толгойн доод талд хөндлөн эгнээ болсон 4 сахалтай. Арьс, ялангуяа толгойн хэсэгтээ товхон хайрстай. Нурууны сэлүүр (D) 30-58, хэвлийн сэлүүр (V) 22-32, сүвийн сэлүүр (A) 15-33, цээжний сэлүүр (P) 36-51 салаалсан гуурстай. Заламгайн эхний нуманд 28-45 өргөстэй. Заламгайн өргөс дэвүүр хэлбэртэй. Сүүлний сэлүүр гетероцеркаль, тэгш хэмт бус дээд далбан нь илүү ургасан байх бөгөөд нурууны төгсгөл хэсэг нь тахийн түүн рүү орсон байх ба ганоид хайрстай. Эрүү шүдгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 2 м, жин 201 кг хүрнэ. Монгол оронд тархан амьдрах шивэр хилэм нь 1.5 м, 35 кг хүрнэ. Агуух (эр) 10-12 насандаа 95-108 см урт, 4-6 кг жинтэй, агуу (эм) загас 12-14 насандаа 108-120 см урт, 5-7 кг жин хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. 5 сарын дундаас 6 сарын 15 хүртэл ус 10-15 хэм дулаан байхад хайрга чулуун дээр, чулууны завсар түрсээ шахна. Агуу дунджаар 422 мянган түрс гаргана. Шумуулын авгалдай, цөөн өргөст хорхой, хоовгоны авгалдай зэрэг ёроолын амьтдаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Голын элс, лаг шавартай гүн ёроолд тархан амьдарна.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Дэлхийн хэмжээнд: Эмзэг А2d.
Бүс нутагт: Устаж байгаа, В2ab (iii,v).
Монгол улсын Амьтны тухай хуулинд нэн ховор гэсэн ангилалд бүртгэгдсэн (2000).



ТАРХАЛТ

Үржлийнхээ үед Сэлэнгэ мөрөн, Дэлгэрмөрөн, Идэр, Орхон голыг өгсөн түрсээ шахна. Үржлийнхээ дараа голоо уруудан гол мөрний цүнхээл болон Байгаль нуур луу урууддаг. Заримдаа Сэлэнгэ мөрний гүн цүнхээлд өвөлждөг.



DESCRIPTION

Body color is dark brown and canary on belly. Elongated spindle-shaped body. Body covered with 5 rows of bony scutes (plates): one dorsal, two laterals, and two bottoms. The dorsal row has 12-19 scutes, the two lateral rows have 26-44 each, and the two bottom rows have 9-15 each. The shape of snout varies; the snout is usually short. Mouth lateral, margined by fleshy lips. The lower lip is strongly interrupted. Four smooth barbells anterior to mouth. Rather large granules or small stellate plates are irregularly scattered between the rows. The dorsal fin (D) has 30-58 rays, the pelvic fins (V) have 22-32 rays, and anal fin (A) has 15-33 rays, while the pectoral fins (P) have 36-51 rays. Gill rakers fan-shaped, number of rakers on the first arch is 28-45. Caudal fin asymmetrical, with a larger upper lobe (heterocercal), which is always covered with rhombic scales. Jaws are toothless.

BIOLOGY

Body length can reach 2 m, and weight up to 201 kg. The biggest Siberian sturgeon which was found in Mongolia had a total length of 1.5 m and weights 35 kg. Males usually attain maturity at the age of 10 to 12 years, with a total length 95-108 cm; females at the age of 12 to 14 years, at a total length of 108-120 cm. Spawning period from the mid of May till the middle of June with water temperature 10-15°C. They spawn over bottom on gravel and cobble. Fecundity is 422 thousands eggs per female. Feeds on larvae of chironomids (Chironomidae), black flies (Simuliidae), stoneflies (Plecoptera) and other benthic organisms.

HABITAT

Deep pools of rivers, with sand and muddy bottoms.

CONSERVATION STATUS

Global: VulnerableA2d.

Regional: Critically Endangered, B2ab (iii,v). Listed as very rare under the Mongolian Law on Fauna. (2000).

DISTRIBUTION

When ready to spawn, sturgeon migrates to upper reaches of Selenga, Delgermuren, Ider and Orkhon rivers. When spawning is completed they move downstream to deep water holes and Lake Baikal. Sometimes they overwintered in the deep pools of the Selenga River.

АМАР МӨРНИЙ ХИЛЭМ

Acipenser schrenckii Brandt, 1869
Amur sturgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн гадаад төрхөөрөө шивэр хилэмтэй төстэй. Хошуу ургавтар шөвгөр. Нуруу боровтор буюу бараг хар, хажуугийн товхоос доош хэсэг цайвар, нурууны сэлүүр болон сүүлний сэлүүр нуруу шигээ өнгөтэй, бусад сэлүүрүүд цайвар. Хөндлөн дугуйран зүсэгдсэн амтай. Сүүлний сэлүүр нь Гетероцеркаль хэлбэртэй. Өөрөөр хэлбэл тэгш хэмт бус дээд далбан нь илүү ургасан байх бөгөөд нурууны төгсгөл хэсэг нь тахийн түүн рүү орсон байдаг. Нуруу, биеийн хажуугийн товх хооронд жижиг ялгастай. Нуруунд 11-17, биеийн хажуугаар 32-47, хэвлийд 6-12 товхтой. Хоёр хажуугийн товхоос дээших биеийн хэсгийг жижигхэн будаалгууд бүрхээгүй, байвал маш жижигхэн. Нурууны сэлүүр (D) салаалаагүй 35-53, сүвийн сэлүүр (A) салаалаагүй 20-32 гуурстай. Цээжний сэлүүрийн (P) эхний гуурс маш сайн хөгжсөн. Заламгайн эхний нуманд 36-45 өргөстэй. Заламгайн өргөс дэвүүр хэлбэргүй.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Дэлхийн хэмжээнд: Устаж болзошгүй, A1acd & A2d.
Бүс нутагт: Мэдээлэл дутмаг.
Монгол улсын Амьтны тухай хуулинд нэн ховор гэсэн ангилалд бүртгэгдсэн (2000, 2012).



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Амарын хилэм нь 290 см, жин 200 кг хүрнэ. Ёроолын амьдралын хэвшилтэй. Атуух (эр загас) 8-10 насандаа, атуу (эм загас) 11-14 насандаа биеийн урт 108-120 см, 6-8 кг хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. 4 сарын сүүлчээр усны температур 6-7°C болоход, гол төлөв 5 сарын сүүлчээс 7 сарын дунд хүртэл голын ширүүн урсгалтай 2-3 м гүнтэй хэсгийн хайрга чулуунд түрсээ шахна. Атуу дунджаар 27.6-434 мянган түрс гаргана. Түрсний голч 2.5-3.0 мм. Жараахайн шар уураг бүрэн шимэгдэж дуусахад ёроолын амьдралын хэвшилд шилжинэ. Жараахай 2 см хүрэхэд ёроолын сээрнууруугүйтэн жижиг амьтдаар, гол төлөв жингэнүүр ялааны (хириноид) авгалдайгаар хооллоно. Бие гүйцсэн Амарын хилэм усны ёроолын шавьжийн авгалдай, агнуурын бус жижиг загас болох гүрц, морин загасны жараахай болон зөөлөн биетэнээр хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Амьдралын бүх үе нь цэнгэг устай холбоотой. Голын элс, хайрган ёроол бүхий дөлгөөн урсгалт хэсгээр тархан амьдарна. Жилийн турш идэвхитэй хөдөлгөөнтэй. Жараахай болон өсвөр насны загас өвөл усны гүнд өвөлжөөд мөс хайлсаны дараа нуур, түүний цутгал орчмоор өгсөж нүүдэллэдэг. Бие гүйцсэн хилэм алс хол нүүдэллэдэггүй.



ТАРХАЛТ

Онон голын доод хэсэгт байх магадлалтай хэмээн тэмдэглэгдсэн.



DESCRIPTION

Amur sturgeon is similar in appearance to Siberian sturgeon. Snout conical, pointed. Back is brownish or blackish, below the lateral scutes lighter. Body covered with 5 rows of bony scutes (plates); the dorsal row of bony plates consists of 11-17, each of lateral rows has 32-47, and bottom rows 6-12 scutes. Lower lip interrupted. Caudal fin is asymmetrical, with a larger upper lobe (heterocercal), which is always covered with rhombic scales. Body usually covered only with small granules above lateral rows; platelets very small if present. The dorsal fin (D) has 35-53 rays, while the anal fin (A) has 20-32 rays. A strong spine in pectoral fins. Gill rakers non fan-shaped, number of rakers on the first arch is 36-45.



CONSERVATION STATUS

Global: Endangered A1acd & A2d,
Regional: Data Deficient.
Listed as very rare under the Mongolian Law on Fauna. (2000, 2012).



BIOLOGY

Amur sturgeon reaches maximum length up to 290 cm, weight up to 200 kg. Males are at least 8-10 years old and 75-105 cm total length before sexual maturity, females do not mature until they are 11-14 years old and 108-120 cm. The spawning period starts in late April when water temperatures reach 6-7°C, usually from late of May to mid of July. Spawning takes place in deep (2-3 m) sites of the river with swift currents and gravel bottom. Female produce 27,6-434 thousands eggs, about 2.5-3.0 mm in diameter. When the juveniles grow at 2 cm feeds on small benthic invertebrates, usually larvae of chironomids. Adults are benthic feeders, and they may also consume small fish, and mollusks.



HABITAT

Life history is related with freshwater. Inhabits rivers with moderate current with sand or gravel bottom. During the whole year actively moves. Larvae and juveniles have wintered in deep parts of river; and after melt migrate to the lake and upper its tributaries. Adults do not migrate as far as.



DISTRIBUTION

Should be expected in the Onon River of Mongolia.

ШӨВГӨР ХОНШООРТ ЗЭВЭГ

Brachymystax lenok Pallas, 1773
Sharp-snouted lenok or Asian trout



ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн зүс алтлаг бор буюу алтлаг бараавтар. Бие хажуугаасаа бөөрөнхийдүү. Ам жижиг, хагас доод. Дээд эрүү богино, нүдний дунд хэсэгт хүрнэ. Харьцангуй урт (биеийн уртын%) харьцуулахад дээд эрүү 8,4; доод эрүү 10.5 байна. Нүдний харьцангуй диаметр 4.1. Хайрс жижиг. Биеийн хажуу, толгой, нурууны болон сүүлний сэлүүрүүд дугуйвтар том хар толботой. Биеийн хажуугаар 6-8 зэсэн улаан судалтай. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Сүүлний сэлүүрийн ухлаадас бага. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-V, салаалсан 10-11, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III-V, салаалсан 8-11, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 13-16, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 9-10 гуурстай. Заламгайн өргөс 19-29. Хажуугийн шугаманд 107-152 хайрстай. Эрүү, тагнайд шүдтэй.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт эмзэг, A3d. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Монгол оронд тархан амьдрах зэвгэ загас нь 67 см, 6 кг хүрнэ. Зэвгэ загас 13 насална. 6-7 насандаа биеийн урт 40-45 см, жин 700-900 гр хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. 4 сарын сүүлчээс 5 сарын дунд хүртэл усны хэм 6-12°C болоход голоо өгсөн хайрга чулуун ёроол бүхий хэсэгт 0.5-0.8 м диаметртэй, 15-20 см гүнтэй үүр ухан бөөнөөрөө түрсээ шахан үржинэ. Атуу дунджаар 2,5-7,8 мянган түрс гаргана. Түрсний диаметр (голч) 4.2-4.5 мм. Зэвгэ нь усны ёроолын шавьж, хуурай газрын шавьж, жижиг загас, бие гүйцсэн том зэвгэ нь жижиг хөхтөнөөр хооллосон байдаг.




АМЬДРАХ ОРЧИН

Тунгалаг, цэнгэг, хүчилтөрөгчөөр баялаг, ширүүн урсгалтай голууд, гол төлөв хүйтэн устай голын дээд хэсэг, өндөр уулын нуурт тархан амьдарна.



ТАРХАЛТ

Сэлэнгэ, Дэлгэрмөрөн, Идэр, Орхон, Ерөө, Туул, Чулуут, Суман гол, Тэрхийн Цагаан нуур, Хөвсгөл нуур, Дархадын хотгорын нуур, голууд зэрэг Хойд мөсөн далайн ай сав, Онон, Хэрлэн, Халх гол, Буйр нуур зэрэг Номхон далайн ай савын нуур, голуудад тархана.



DESCRIPTION

Body color is gold brown or gold darkish. Body relatively round in shape. Mouth small, subterminal. Short upper jaw, does reach middle of eye. Relative length (% of body length) of upper jaw is 8.4; The relative length of the lower jaw is 10.5. Relative diameter of eye is 4.1. Scales small. Sides of body, head, dorsal and adipose fins have medium rounded dark brown spots. On the sides of body have 6-8 brazen-red parr marks. Behind dorsal fin has adipose fin. Caudal fin not deeply forked. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 10-11 branched soft rays, the anal fin (A) has III-V unbranched soft rays, and 8-11 branched soft rays, the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 13-16 branched soft rays, the pelvic fins (V) have I unbranched soft ray, and 9-11 branched soft rays. Gill rakers on the first arch are 19-29. Lateral line with 107-152 scales. On the jaws and palate have teeth.



CONSERVATION STATUS

Global: Vulnerable, A3d.
Regional: According to the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibited from April 1st to June 15th of the following current year.



BIOLOGY

The sharp-shout lenok of the Mongolia reaches a total length of 67 cm and weight 6 kg. Can reach at least 13 years of age. They are mature in 6-7 years of ages, 40-45 cm length, and in weight 700-900 g. Spawning takes place between late April and middle May when water temperatures rich 6-12°C. Spawning occurs in gravelly riffles. Both males and females dig spawning redds 0.5-0.8 m in diameter and 15-20 cm in deep. Female produce 2,5-7,8 thousands eggs, about 4.2-4.5 mm in diameter. It feeds on bottom invertebrates, including insect larvae as well as terrestrial insects. Large individuals can consume small mammals.



HABITAT

Livers in clear rivers, with high oxygen, and riffles, usually in upper reaches where the water is colder, as well in high mountain lakes.



DISTRIBUTION

Selenga, Delgermuren, Eg, Uur, Ider, Orkhon, Eruu, Tuul, Chuluut and Suman rivers; Terkhiin Tsagaan, Khuvsgul, Ugii lakes and rivers and lakes of Darkhad Depression (Arctic ocean basin); Onon, Kherlen and Khalkh rivers and Buir Lake (Pacific ocean basin).

МОНХОР ХОНШООРТ ЗЭВЭГ

Brachymystax tumensis Mori, 1930

Blunt-snouted lenok



ЕРӨНХИЙ ШИНЖ

Монхор хоншоорт зэвэг нь шөвгөр хоншоорт зэвэгтэй төстэй. Бие алтлаг бор шаргал, хажуугийн шугамаас дээш доош том том толботой. Ам жижиг, тэгш. Дээд, доод эрүү бараг тэнцүү эсвэл доод эрүү дээд эрүүнээс үл ялиг бага. Дээд эрүү нүдний дунд хүрнэ. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Хайрс жижиг. Биеийн хажуу, толгой, заламгайн хавхлаг, өөхөн сэлүүр болон нурууны сэлүүр дээр том том хар толботой. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 9-10, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 8-10, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 15-16, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 9 гуурстай. Дээд, доод эрүү, тагнайд тах хэлбэртэйгээр шүд байршсан. Заламгайн өргөс 23-25. Хажуугийн шугаманд 111-124 хайрстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Монхор хоншоорт зэвэг загас нь 65 см хүрнэ. 5 сарын дундуур голоо өгсөн хайрга чулуун ёроол бүхий хэсэгт сүрэглэн түрсээ шахна. Агуу 1,300 ширхэг түрс гаргана. Үржлийнх нь үед заримдаа биеийн хажуугаар хэлбэр дүрсгүй улаан толбо үүснэ. Монхор хоншоорт зэвэг нь усны ёроолын шавьж, түүний авгалдай, хүүхэлдэй, хуурай газрын шавьж, бие гүйцсэн зэвэг нь жижиг загасаар хооллосон байдаг.



АМЬДРАХ ОРЧИН

Хүчилтөрөгчөөр баялаг, цэвэр тунгалаг устай голуудын хайрга чулуун ёроолтой хэсгээр тархан амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлээгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Онон гол, түүний цутгал Балж, Агацын голд тархана.



DESCRIPTION

Blunt-snouted lenok are similar in appearance to short-snouted lenok. Body color is gold brown yellowish, above and below lateral line have large dark spots. Mouth small, terminal. Upper and lower jaws are equal, either lower jaw slightly smaller than upper jaw. Upper jaw does reach middle of eye. Behind dorsal fin has adipose fin. Scales small. Sides of body, head, operculum, dorsal and adipose fins have large rounded dark spots. The dorsal fin (D) has III branched soft rays, and 9-10 unbranched soft rays, the anal fin(A) has III branched soft rays, and 8-10 unbranched soft rays, the pectoral fins (P) have I branched soft ray, and 15-16 unbranched soft rays, and the pelvic fins (V) have I branched soft ray, and 9 unbranched soft rays. In the jaws and palate have teeth. Gill rakers on the first arch are 23-25. Lateral line with 111-124 scales.

BIOLOGY

Blunt-snouted lenok can reach up to 65 cm. Spawning starts in middle of May. Spawners migrate to upstream, and spawning occurs in gravel, cobble bottoms. Female produce 1,300 eggs. Sometimes during the spawning time retain in sides of body unshaped red spots. Feed upon benthic invertebrates (mainly insect's larvae) and terrestrial insects, large adults feed in small fish.

HABITAT

Live in rivers clear, with high oxygen, and with currents on gravel and cobble bottom.

CONSERVATION STATUS

Regionally Not Evaluated


DISTRIBUTION

The Onon River and its tributaries Balj and Agats rivers (Pacific ocean basin).

ЕРДИЙН ТУЛ

Hucho taimen Pallas, 1773

Taimen



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие, толгой оливийн ногоон, сүүл хэсэг рүүгээ улаавтар бор. Өөхөн сэлүүр, сүв болон нурууны сэлүүрүүд гол төлөв хар улаан өнгөтэй. Хэвлий цагаанаас хар саарал болж өөрчлөгдөнө. Ам тэгш, том. Дээд эрүүний урт, нүднээс хойш давсан. Толгой дээрээ жижиг дугуй бараан толботой, биеийн гадаргуудаа х хэлбэрийн, хагас сар хэлбэрт хар бараан толботой. Хайрс жижиг. Үржлийн үед атуухын биеийн гадаргуу зэсэн хүрэн, сүүлний сэлүүр улаан болно. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 9-11, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III-IV, салаалсан 8-9, цээжний сэлүүр (P) салаалаагүй I-III, салаалсан 12-15, хэвлийн (V) сэлүүр салаалаагүй I-II, салаалсан 8-10 гуурстай. Самалдаг, тагнайд хүчирхэг шүдтэй. Заламгайн өргөс 9-12. Хажуугийн шугам 190-242 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт устаж болзошгүй, A2de болон A3de болон B2ab (iii,v). Монгол Улсын Амьтны тухай хуулинд ховор гэсэн ангилалд бүртгэгдсэн хэдий ч энэ зүйл загасыг тусгай зөвшөөрлөөр бариад-буцаан тавихаар тусгасан (Wingard & Odgerel, 2001). Тус хуулинд жил бүрийн 10 дугаар сарын 30-ны өдрөөс дараа оны 6 сарын 15-ны өдөр хүртэл олзворын ангийн зориулалтаар агнахыг хориглоно хэмээн заасан.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Монгол оронд тархан амьдрах тул загас нь 1.8 м, 45 кг хүрнэ. Тул загас 55 наслана. 7 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 5 сарын дундаас усны температур 10°C болоход голоо өгсөн ширүүн урсгалтай хайрга чулуун ёроол бүхий хэсэгт үржинэ. Үржлийнхээ үед хос үүсгэнэ. Үржлийн хосууд 0.5-1.0 м гүнд 1.0-1.5 м диаметртэй, 10-20 см гүнтэй үүр ухан түрсээ шахна. Атуу дунджаар 8.5-30.0 мянган түрс гаргана. Биеийн жин, урт нь нэмэгдэх тутам төлжилт ихсэнэ. Түрсний диаметр (голч) 5.3-5.9 мм. Тулын жараахай усны элдэв сээр нуруугүйтэн амьтдаар хооллож байгаад 2 сарын дараагаас загасаар хооллож эхэлнэ. Бие гүйцсэн тул махчин, хуурай газрын жижиг хөхтөн, шувуу барьж иднэ.




АМЬДРАХ ОРЧИН

Уулын ширүүн урсгалтай, хүйтэн, тунгалаг, хүчилтөрөгчөөр баялаг голын гүнзгий хэсэг, голын тохойрсон болон хадан хясаа, эгц эрэг бүхий цүнхээл, гүнзгий булан тохойд зонхилон амьдарна. Голын цүнхээлд өвөлжинө.



ТАРХАЛТ

Сэлэнгэ мөрөн түүний цутгал голууд, Идэр, Чулуут, Дэлгэрмөрөн, Эг, Үүр, Орхон, Туул голын эх, Ерөө, Шишхэд, Тэнгис, Хөг, Доод Цагаан нуур, Тамир, Суман, Тэрхийн цагаан нуур зэрэг Хойд мөсөн далайн ай савын нуур, голууд Хэрлэн, Онон, Балж, Нөмрөг, Халх гол, Буйр нуур зэрэг Номхон далайн ай савын нуур, голуудад тархан амьдарна.



DESCRIPTION

Body is olive green on the head blending to reddish brown in the tail. Adipose, anal, and caudal fins are often dark red. The belly ranges from nearly white to dark gray. Mouth large, terminal. Long upper jaw, posterior edge of maxillary extends at least as far back of eye. Sides of body, head, and operculum have dark brown spots, above lateral line have x shaped, like crescent dark spots. Scales small. Spawning males are typically brazen brown on the sides, with the red caudal fin. Behind the dorsal fin has an adipose fin. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 9-11 branched soft rays, the anal fin (A) has III-V unbranched soft rays, and 8-9 branched soft rays, the pectoral fins (P) have I-III unbranched soft rays and 12-15 branched soft rays, the pelvic fins (V) have I-II unbranched soft rays, and 8-10 branched soft rays. Gill rakers on the first arch are 9-12. Lateral line with 190-242 scales. In the jaw and palate has well-developed teeth.

CONSERVATION STATUS

Regional: Endangered, A2de and A3de and B2ab (iii,v). Listed as Rare under the Mongolian Law on Fauna, although it remains possible to obtain fishing licenses on the principle of catch-release. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from October 30th to June 15th to the next year.

BIOLOGY

The maximum length taimen in Mongolia is about 180 cm, and weight 45 kg. It can reach 55 years of age. Taimen reaches maturity at the age of 7 years. Spawning starts in middle of May when water temperature 10°C. Taimen migrate to upper reaches of river, and spawning occurs in gravelly riffles. The pair of spawners stops in a selected site and prepare the spawning redd. Both males and females dig spawning redds 1.0-1.5 m in diameter, at a depth of 0.5-1.0 m, and eggs covered by 10-20 cm of gravel and small cobble. Female produce 8.5-30.0 thousands eggs, about 5.3-5.9 mm in diameter. Larvae start feeding on invertebrates and become piscivorous after two months. Adult taimen are mainly piscivorous, though they frequently eat terrestrial prey such as rodents and birds.

HABITAT

Taimen are most common in clear, with current, cold, high oxygen mountain rivers, river creek or rocky cliff, pools with steep and deep bay. Taimen winters in deep pools.

DISTRIBUTION

The Selenga River, and its tributaries, Ider, Chuluut, Delgermuren, Eg, Uur, Orkhon, upper Tuul, Eruu, Shishkhed, Tengis, Kheg, Tamir, Suman; Lake Dood, Lake Terkhiin Tsagaan (Arctic ocean basin), and Kherlen, Onon, Balj, Nemreg, Khalh rivers, Buir Lake (Pacific ocean basin).

БАЙГАЛИЙН ОМУЛЬ

Coregonus autumnalis Pallas, 1776

Baikal omul



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие мөнгөлөг цагаан өнгөтэй, хар толбо байхгүй, хайрс том. Ам тэгш, жижиг. Нүд том, духны $\frac{3}{4}$ эзэлнэ. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Заламгайн өргөс маш олон (36-43). Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 9-12, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 10-13, цээжний сэлүүр (P) салаалсан 13-16, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 9-12 гуурстай. Хажуугийн шугаманд 80-96 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг. Монгол Улсын Амьтны тухай хуулинд жил бүрийн 8 дугаар сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл агнахыг хориглосон. Монгол Улсын Улаан Номонд орсон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Байгалийн омуль загасны хамгийн том нь 56 см, 2.5 кг хүрнэ. 6-7 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 9 сарын сүүлч 10 сарыг дуустал цутгал голуудыг сүрэг сүргээрээ өгсөж голын дээд эх хүртэл нүүдэллэх ба усны температур 2.0-1.4°C буурахад түрсээ голын түргэн урсгалтай хэсгийн хайрга чулуунд шахна. Атуу дунджаар 49,800 түрс гаргана. Түрс шаргал өнгөтэй. Түрсний диаметр (голч) 1.8-2.0 мм. Залуу бодгалиуд нь ихэвчлэн хөвөгч амьтдаар, 5-аас дээш насных хөвөгч амьтад, ёроолын амьтдаар хооллодог.



АМЬДРАХ ОРЧИН

Байгалийн омуль нь нүүдлийн загас. Байгаль нуурт идээшилэн зөвхөн үржлийнхээ үед гол өгсөн нүүдэллэнэ. Гүний амьдралтай. Зуны улиралд нуурын гадаргууд ойр, задгай талбайн хэсгээр, нуурын гүнд өвөлждөг.



ТАРХАЛТ

Үржлийнхээ үед Байгаль нуураас Сэлэнгэ мөрөн, Орхон голыг өгсөн үрждэг. Монголд Хөвсгөл нуур, Завхан аймгийн Улаагчны Хар нуурт нутагшуулсан.



DESCRIPTION

The body is light silver sides and a dusky on the back. Large scales. Mouth is terminal, small. Large eye, about $\frac{3}{4}$ of forehead. Behind dorsal fin has an adipose fin. Have a large number of gill rakers (36-43). The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 9-12 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 10-13 branched soft rays, the pectoral fins (P) have 13-16 branched soft rays, the pelvic fins (V) have II unbranched soft rays, and 9-12 branched soft rays. Lateral line with 80-96 scales.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive August 30th to October 30th. Listed in Red Book of Mongolia.



BIOLOGY

The maximum reported length of omul is 56 cm, weighing about 2.5 kg. Baikal omul reaches maturity at the age of 6-7 years. Spawning starts from late September to late October when water temperature decrease to 2.0-1.4°C. Spawners form schools and migrate to the headwaters of the rivers, where spawning occurs in gravelly riffles. Female produce 49,800 eggs, about 1.8-2.0 mm in diameter. Eggs yellowish. Juveniles feed mainly on zooplankton; adults feed on zooplankton, small fish and benthic organisms.



HABITAT

Baikal omul is an anadromous species. The omul enters Lake Baikal inlet rivers to spawn. Pelagic fish. Stay near surface of the lake, profundal area in summer, and in winter in deep.



DISTRIBUTION

During the spawning period from Baikal lake move to Selenga and Orkhon rivers. In Mongolia intentionally introduced to Khuvsgul Lake and to Ulaagchnii Khar Lake of the Zavkhan province.

ЦАГААН ХАДИР

Coregonus chadary Dybowski, 1862
Khadary-whitefish



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие болон хажуу хэсэг мөнгөлөг цагаан өнгөтэй, том хайрсаар хучигдсан. Цагаан хадирын толгой болон нурууны хэсэгт жижиг хар толботой. Дээд эрүүний яс урт. Дээд эрүү, доод эрүүгээ ялимгүй давсан. Дээд эрүүний яс нүдний өмнөд захад хүрдэггүй. Сэлүүрийн үзүүр бараан. Өөхөн сэлүүртэй. Заламгайн өргөс цөөн (23-28). Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 10-13, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 12-15 гуурстай. Хажуугийн шугаманд 72-88 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Цагаан хадир нь 59 см хүрнэ. 7-8 насандаа биеийн урт 40 см, 900 гр жинтэй болоход бэлгэ боловсорч үржилд орно. Намар орой 10-11 сард голын хайрга чулуу, элсэрхэг ёроолд түрсээ шахан үржинэ. Атуу дунджаар 12,000 түрс гаргана. Гол төлөв хоовгон, жингэнүүр ялааны авгалдай зэрэг ёроолын амьтдаар хооллох ба заримдаа загасаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Хүйтэн, хүчилтөрөгчийн хангамж сайтай голын дээд хэсэгт тархан амьдарна. Намар усны хэм буурахад голын доод хэсэг рүү сүрэлгэн уруудна.



ТАРХАЛТ

Онон гол, түүний цутгал Балж, Хурх гол, зарим жижиг нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

The body is light silver sides, covered by large scales. Khadary-whitefish has small black spot in the head or back. Upper jaw is long. Upper jaw is slightly beyond lower jaw. Maxillary not extends beyond posterior margin of eye. Fin's edges are darkish. Adipose fin present. Relatively low number of gill rakers (23-28). The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 10-13 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, 12-15 branched soft rays. Lateral line with 72-88 scales.



CONSERVATION STATUS

Data Deficient. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive April 1st to June 15th.



BIOLOGY

Khadary-whitefish can reach up to 59 cm. They are matured in 7-8 years of ages when 40 cm length, and weight 900 g. Spawning takes place in late autumn, from October to November. Females lay eggs in gravel, cobble or sandy bottom. Female produce 12,000 eggs. Feed mainly on chironomids, and caddisflies (Trichoptera) larvae, and sometimes feed on fish.



HABITAT

Inhabit upper reaches of rivers with cold, high oxygen. In fall when water temperature decrease swim in schools to down reaches of the river.




DISTRIBUTION

The Onon river, it's tributaries Balj, Khurkh rivers, some small lakes.

ЦАГААН ЗАГАС

Coregonus lavaretus pidschian Gmelin, 1788 = *Coregonus pidschian*
Arctic whitefish, pidschian



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие хажуугаасаа хавчгар, жижиг амтай, хошуунарийн. Бие мөнгөлөг цайвар, хайрс том, элдэв толбо байхгүй. Нуруу бөгтөр. Өөхөн сэлүүр сайн хөгжсөн, ялангуяа атуухынх нь том. Заламгайн өргөс цөөн (19-25). Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 9-12, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III-IV, салаалсан 10-12 гуурстай. Хажуугийн шугаманд 71-98 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт устаж болзошгүй, B2ab(iii,v). Европын зэрлэг амьтан болон Байгалийн унаган идээшил нутгийг хамгаалах конвенцийн III Хавсралтанд (Bern Convention) орсон. Монгол Улсын Амьтны тухай хуулинд жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Цагаан загас нь 66 см, 3.5 кг хүрнэ. Цагаан загас 13 насална. 5-7 насандаа биеийн урт 38 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. Нуурын цагаан загасны бүл 8 сарын дундаас ус 12-18°C хэм байхад 1.5-3.0 м гүнд, нуур-голын цагаан загасны бүл намар 10 сарын эхээр ус 30C хэмийн дулаанаас -0.8°C хэм болоход 2-4 м гүнд элс, хайрга чулуун дээр сүрэглэн түрсээ шахна. Атуу дунджаар 8,000-33,300 түрс гаргана. Түрсний диаметр (голч) 1.2-1.5 мм. Түрс шаргал өнгөтэй. Цагаан загас нь жингэнүүр ялааны авгалдай, зөөлөн биетэн, хоовгоны авгалдай зэрэг усны ёроолын шавьжаар хооллодог. Заламгайн өргөсний тооноос хамааран олон хэлбэр үүсгэдэг.




АМЬДРАХ ОРЧИН

Голын доод хэсгийн зөөлөн урсгалт хэсгээр, томоохон нуур түүний цутгал голуудаар тархан амьдарна.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн ай савын Дархадын хотгорын нуур, голууд, Эг, Үүр, Идэр, Сэлэнгэ мөрөн түүний цутгал голуудад тархан амьдарна.



DESCRIPTION

A slender body, mouth is small, snout narrow. The body is light silver on side, with large scales, and any spots are absent. Hump backed. Adipose fin well developed, often larger in males. A low number of gill rakers (19-25). The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 9-12 branched soft rays, the anal fin (A) has III-IV unbranched soft rays, and 10-12 branched soft rays. Lateral line with 71-98 scales.

CONSERVATION STATUS

Regionally Endangered, B2ab(iii,v). Appendix III of the Convention on the Conservation of European Wildlife and Natural Habitats (Bern Convention). The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from August 1st to October 20th.

BIOLOGY

Pidschian can reach up to 66 cm, and weight 3.5 kg. It can reach at least 13 years of age. They are mature in 5-7 years of ages and 38 cm of length. Lake population of pidschian spawning takes place in middle of August at water temperatures of 12-18°C, at depth down to about 1.5-3.0 m. Pidschians of lake-river populations (forms) spawn in early October at water temperatures of 3.0-0.8°C, at depth down to about 2.0-4.0 m. Lays eggs in sandy or gravel bottom. Female produce 8,000-33,300 eggs, about 1.2-1.5 mm in diameter. Eggs yellowish. Feed mainly on aquatic benthic insects larvae such as chironomids and caddisflies, and mollusks. Depending from number of gill rakers generate distinct intraspecies forms.

HABITAT

Inhabits lower reaches of rivers with slow current, large lakes with tributaries.

DISTRIBUTION

Rivers and lakes of Darkhad Depression; the Selenga River, and its tributaries Eg, Ider and Uur rivers (Arctic ocean basin).

БУХ ЗАРАМ

Coregonus peled Gmelin, 1789

Peled



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу бага зэрэг бараан, хажуу мөнгөлөг, гэдэс цагаан, бие өндөр, босоо. Толгойн ар хэсгээс шууд өргөссөн. Ам тэгш. Эрүү бараг тэгш, хоншоор нь доод эрүүнээсээ урт байдгаараа бусад цагаан загаснаас ялгаатай. Өөр нэг онцлох шинж нь заламгайн анхдугаар нуманд 50-65 заламгайн өргөс байдаг нь бусад зүйлүүдийнхээс харьцангуй их юм. Нурууны сэлүүрийн ард өөхөн сэлүүртэй. Заламгайн өргөс олон 49-68. Нурууны сэлүүр (D) дунджаар 9.5 салаалсан, сүвийн сэлүүр (A) 12-16 салаалсан гуурс, хэвлийн сэлүүрт дунджаар 15.5 салаалсан гуурстай. Хажуугийн шугам 76-102 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлээгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд жил бүрийн 9 дүгээр сарын 05-ны өдрөөс дараа оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл агнахыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Бух зарам загас нь 40-55 см, 3-5 кг хүрнэ. 2-3 насандаа бэлгэ боловсорч үржилд орох бөгөөд 12 насална. Намар болон өвөл үржих бөгөөд нуурын эргийн хатуу элс, голын хайрга чулуун ёроолд түрсээ шахна. Атуу дунджаар 5,000-85,000 түрс гаргана. Түрс жижиг, шаргал өнгөтэй. Гол төлөв хөвөгч амьтдаар хооллох бөгөөд заримдаа ёроолын сээрнуруугүйтэн амьтад, жараахай, замаг болон хөвж буй шавьжаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Нуурын гүехэн хэсгээр тархан амьдарна. Намар орой бие гүйцсэн бодгалиуд үржлийн гүйдэлд орж, нуурын цутгал голуудаар цугларна. Үржлийн бус цагаар нуурын гүнд амьдарна.



ТАРХАЛТ

Монголд Хөвсгөл аймгийн Доод Цагаан нуур, Тарган нуур, Завхан аймгийн Улаагчны Хар нуур, Өвөрхангай аймгийн Найман нуурт нутагшуулсан.



DESCRIPTION

Peled has a dark back, silvery flanks and white belly, a deeper body which becomes less tapered and blockier. Mouth terminal. The jaws are of equal length which is in contrast to the whitefish which has a snout longer than its lower jaw. Another distinction is that the first gill arch has 50-65 gill rakers, a larger number than either of the other whitefishes species. Has an adipose fin. The dorsal fin (D) has an average 9.5 branched soft rays, the anal fin (A) has 12-16 branched soft rays. Pelvic fins (V) have an average 15.5 branched rays. Lateral line scales number -76-102.



CONSERVATION STATUS

Regionally Not Evaluated. The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from September 5th to January 30th.



BIOLOGY

Peled grows to a length of about 40-45 cm and a maximum weight of 3-5 kg. Fish mostly become mature when 2-3 years old and can live to about twelve years old. Peled spawn in autumn and winter on hard sand at the edges of lakes, and on sand gravel and pebbles in rivers. Female produce 5,000-85,000 eggs. Eggs small, yellowish. Peled mostly eats zooplankton, but also consumes bottom-dwelling invertebrates, fish fry, algae and floating insects.



HABITAT

Peled inhabits lakes with shallow water. Mature individuals in late fall accumulate at tributaries of the lake. In other time peled stay in deep water of lake.



DISTRIBUTION

Peled have been introduced into Lakes Dood and Targan of Khuvsgul province, and Ulaagchnii Lake of Zavkhan province, and lake Naiman of Uverkhangai province.

ШИВЭР ХАДРАН

Thymallus arcticus Pallas, 1776
Arctic grayling



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нурууны сэлүүр урт, түүний суурь толгойн ургаас урт, улаан болон улбар шар хүрээ бүхий ягаан толбон эгнээтэй. Нуруу хөх саарлаас нил ягаан, хажуу мөнгөлөг хөх саарал, заримдаа ягаавтар, цээжний хэсэгт хар толботой, биеийн хажуу тал улаавтар хөндлөн зурвастай. Нурууны сэлүүрийн суурийн урт биеийн уртын 20-27%-ийг эзэлнэ. Ам тэгш. Дээд эрүүний урт нүдний голчын төвийн харалдаа хүртэл үргэлжилнэ. Өөхөн сэлүүртэй. Заламгайн өргөс 16-21. Нурууны сэлүүр (D) салаалаагүй VI-VIII, салаалсан 12-14, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-IV салаалсан 8-10, цээжний сэлүүр (P) салаалаагүй I-III, салаалсан 13-15, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 8-9 гуурстай. Хажуугийн шугам шулуун, бүтэн, 73-103 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт ховордож болзошгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Шивэр хадран нь 50 см хүрнэ. 3-4 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 4 сарын сүүлээс ус 6°C хэм болж ирэхэд түрсээ шахаж эхлэх бөгөөд 5 сарын дунд хүртэл үргэлжилнэ. Голын ширүүн урсгалтай хэсгийн хайрга чулуун ёроолд 2.5-3.0x3.5-4.5 м диаметр бүхий тэгш өнцөгт эсвэл 1.8-2.4x2.4-3.1 м диаметр бүхий зуйван хэлбэртэй үүр засан сүрэг сүргээрээ түрсээ шахна. Түрсээ шахсаныхаа дараа үржлийнхээ талбайг агуух нь хамгаалан үлддэг. Атуу дунджаар 5-10 мянган түрс гаргана. Элдэв идэшт. Хоовгон, шаамий хавч, зөөлөн биетэн, соно, жингэнүүр ялааны авгалдай зэрэг ёроолын амьтад, усны ургамал, замаг, заримдаа усны гадаргуу дээр унасан хуурай газрын шавьжаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Хүйтэн, хүчилтөрөгчийн хангамж сайтай уулын гол, өндөр уулын нуурт тархан амьдарна.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрний бүх цутгал голууд, Хар Эрчисийн эхэн Хуримт, Сонгинот, Ёлтын гол, Дархадын хотгорын нуур, гол, Хөвсгөл, Тэрхийн Цагаан нуур, Туул голын эх, Орхон голд тархан амьдарна.



DESCRIPTION

Dorsal fin long, its fin base longer than head length, has rows of pink spots and red or orange border. Back bluish gray to purple, sides silvery bluish gray, often with pinkish cast and anterior dark spots. On the sides of body have reddish parr marks. Head short, teeth small. Dorsal fin base length is 20-27% of body length. Mouth terminal. Upper jaw extends to middle of eye. Adipose fin present. Caudal fin deeply forked. Gill rakers are 16-21. The dorsal fin (D) has VI-VIII unbranched soft rays, and 12-14 branched soft rays, the anal fin (A) has II-IV unbranched soft rays, and 8-10 branched soft rays, the pectoral fins (P) have I-III unbranched soft rays, and 13-15 branched soft rays, the pelvic fins (V) have II spines unbranched soft rays, and 8-9 branched soft rays. Lateral line straight, complete, has 73-103 scales.

CONSERVATION STATUS

Regionally near threatened. The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from April 1st to June 15th.

BIOLOGY

Can reach up to 50 cm in length. Sexual maturity is attained in 3-4 years. Spawning occurs in spring from late April up to middle May. They spawn on gravel or rocky bottoms, in riffle sites of rivers with strong current. Female produce 5,000-10,000 eggs. Grayling fry feed primarily on zooplankton (copepods and cladocerans) and aquatic insects. Adults feed primarily on insect larvae, and imago of terrestrial insects that have fallen on the water.

HABITAT

Inhabits clear, cold mountain rivers, and high mountain lakes.

DISTRIBUTION

The Selenga River it's tributaries, upper reaches of Khar Erchis Khurimt, Songinot, Ult rivers, lakes and rivers of Darkhad's Depression; Khuvsgul and Terkhiin Tsagaan lakes, upper reaches of Tuul, and Orkhon rivers (Arctic ocean basin)

МОНГОЛ ХАДРАН

Thymallus brevirostris Kessler, 1879

Mongolian grayling



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бусад хадрантай харьцуулахад Монгол хадрангийн нурууны сэлүүр богино, намхан, хүчирхэг шүд бүхий том амтай. Бие бахим, бараавтар саарал, нуруун тал бүдэг хар ногоон туяатай, хэвэл цайвардуу, нурууны сэлүүр солонгорсон хүрэн ягаан толбогүй. Үржлийнх нь үед ч толбо байдаггүй. Бие маш нягт том хайрсаар бүрхэгдсэн. Өөхөн сэлүүртэй. Заламгайн өргөс 15-21. Нурууны сэлүүр (D) салаалаагүй V-X, салаалсан 10-16, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III-IV, салаалсан 7-12, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 12-17, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 8-12 гуурстай. Хажуугийн шугаманд 70-94 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт эмзэг, B2ab (iii,v). Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Монгол хадран нь 70 см, 3 кг хүрнэ. Монгол хадран нь 16 нас хүрнэ. 5-6 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 4 сарын сүүлээс ус 4-6.0 хэм болоход нуурт цутгаж буй голоо өгсөн сүрэглэн хайрга чулуун ёроолд үүр засан түрсээ шахна. Үр тогтосны дараа атуух нь 7-10 хоног үүрээ манана. Атуу 5,000-18,000 түрс гаргана. Өсвөр насны хадран ёроолын амьтдаар хооллох ба бие гүйцсэн нь загасаар хооллодог. Том биетэй нь жижиг хөхтөнөөр хооллосон байдаг.




АМЬДРАХ ОРЧИН

Хүчилтөрөгчийн хангамж сайтай, харгиа боргио, голын цутгал хавийн харзтай хэсэгт тархан амьдарна. Зундаа нуурын 3.0-4.5 метрийн гүнд, өвөлдөө нуурын гүн хэсэгт амьдарна.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын унаган загас. Ховд, Буянт, Бөх мөрөн, Хариг, Чигэстэй, Богд, Яруу, Завхан гол, Хотон, Хоргон, Даян, Ачит, Хар, Хар-Ус, Хонгор-Өлөн, Толбо нуурт тархан амьдардаг.



DESCRIPTION

Compared to the other graylings, the Mongolian grayling has a smaller short dorsal fin, more well-developed teeth, and a larger mouth. Body massive, back is dark green, on sides silvery greyish, belly pallid, spots on dorsal fin are absent. Usually during the spawning spots are absent. Body covered densely sitting large scales. Adipose fin present. Gill rakers number -15-21. The dorsal fin (D) has V-X unbranched soft rays, and 10-16 branched soft rays, the anal fin (A) has III-IV unbranched soft rays, and 7-12 branched soft rays, the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 12-17 branched soft rays, the pelvic fins (V) have II unbranched soft rays, and 8-12 branched soft rays. Lateral line with 70-94 scales.



CONSERVATION STATUS

Regionally Vulnerable, B2ab (iii,v). The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from April 1st to June 15th.



BIOLOGY

Can reach up to 70 cm length, and weight 3 kg. Mongolian grayling can live to about 16 years old. Sexual maturity is attained in 5-6 years. Spawning occurs in spring from late April. They spawn on gravel or rocky bottoms, with strong current of river. Female produce 5,000-18,000 eggs. Juvenile Mongolian grayling feed primarily on benthic organisms, adults feed on fish. Large individuals can consume small mammals.



HABITAT

Inhabits clear, cold, high oxygen rivers, with fast currents and riffles. In summer on 3.0-4.5 m deep of lakes, and wintered in the deep of lakes.



DISTRIBUTION

Endemic of the Central Asian Internal Drainage Basin. Occurs in Khovd, Buyant, Bekhmuren, Kharig, Chigestei, Bogd, Yaruu, Zavkhan rivers, Khoton, Khorgon, Dayan, Achit, Khar, Khar-Us, Khongor Ulen, Tolbo Lakes.

АМАРЫН ХАДРАН

Thymallus grubei Dybowski, 1869

Amur grayling



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу хар ногоон, биеийн хажуу бүдэг ягаан туяатай, хэвэл мөнгөлөг цайвар, биеийн хажуу талс хэлбэрийн хар толботой, хажуугийн шугамаас доош толбоны хэмжээ жижгэрч бүдгэрч цөөрдөг. Нурууны сэлүүрийн суурийн урт биеийн ургын 28.5-35.5%-тай тэнцүү. Нурууны сэлүүрийн захаар хүрэн улаан жижиг толботой. Бие маш нягт дунд зэргийн хайрсаар хучигдсан. Дээд эрүүний урт нүдний дунд хүртэл үргэлжилнэ. Өөхөн сэлүүр цайвар ягаан өнгөтэй. Сүүлний сэлүүр улаавтар хүрэн өнгөтэй. Заламгайн өргөс 16-20 (22). Нурууны сэлүүр (D) салаалаагүй VII-X, салаалсан 12-14, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III-IV, салаалсан 8-10, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 14-16, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 8-9 гуурстай. Хажуугийн шугаманд 78-100 хайрстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Амарын хадран нь 30 см хүрнэ. 3-4 насандаа биеийн урт 20.6 см, жин 76 гр хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 4 сарын сүүлээс ус 2.5-8.5°C хэм болоход сүрэглэн гол өгсөн түрсээ шахна. Шаамий хавч, зөөлөн биетэн, өдөрч, хаварч зэрэг усны ёроолын шавьжийн авгалдайгаар хооллохоос гадна хуурай газрын шавьж ялангуяа далавчилсан шоргоолжоор хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Цэнгэг усны индикатор загас. Хүчилтөрөгчийн хангамж хамгийн ихтэй харгиа боргио бүхий чулуутай хэсгээр зонхилон амьдарна. Амарын хадран нь голын гүн хэсэгт өвөлжинө.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт устаж болзошгүй, B2ab (iii,v). Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



ТАРХАЛТ

Онон, Хэрлэн тэдгээрийн цутгал голуудад тархана. Халх гол, Буйр нуурт тэмдэглэгдсэн төдий.



 **DESCRIPTION**

The back is darkish gray; sides bluish pink, and belly silvery pallid. On the sides crystalline dark spots, and below lateral line, spots smaller, not well noticeable, their number decreases. Dorsal fin base length is 28.5-35.5% of body length. Dorsal fin edge with small pink spots. Body covered densely sitting medium scales. Upper jaw extends to middle of eye. Adipose fin is crimson. Caudal fin colored reddish brown. Gill rakers is 16-20 (22). The dorsal fin (D) has VII-X unbranched soft rays, and 12-14 branched soft rays, and the anal fin (A) has III-IV unbranched soft rays, and 8-10 branched soft rays, and the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 14-16 branched soft rays, the pelvic fins (V) have II unbranched soft rays, and 8-9 branched soft rays. Lateral line with 78-100 scales.

 **BIOLOGY**

Can reach up to 30 cm. Sexual maturity is attained in 3-4 years, when 20.6 cm in length, and weight 76 g. Spawning occurs in spring from late April, when water temperature reach 2.5-8.5°C, in upper reaches of rivers. Amur grayling feed primarily on benthic organisms, such as gammarids, mollusks, and insect larvae of mayflies (Ephemeroptera), stoneflies (Plecoptera) and imago of terrestrial insects that have fallen on the water, especially by winged ants.

 **HABITAT**

Indicator of the fresh water species. Inhabits in rivers with high oxygen strong current and rocky bottom. Amur grayling spend the winter in deep sites of rivers.

 **CONSERVATION STATUS**

Regionally Endangered B2ab (iii,v). The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from April 1st to June 15th.

 **DISTRIBUTION**

Onon, Kherlen, Khalkh rivers and its tributaries, Buir Lake (Pacific ocean basin).

ХӨВСГӨЛ ХАДРАН

Thymallus nigrescens Dorogostaisky 1923
Khuvsgul grayling



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие сунасан урт, хар эсвэл хар бараан өнгөтэй, толбогүй. Нурууны сэлүүрийн үзүүр хүрэн улаан. Өөхөн сэлүүртэй. Бие маш нягт дунд зэргийн хайрсаар хучигдсан. Толгой уртавтарт, дээд эрүү нүдний голчийн төвд бараг хүрнэ. Эрүүний шүд сайн хөгжсөн. Заламгайн өргөс 15-21. Нурууны сэлүүр (D) салаалаагүй VII-X, салаалсан 8-14, сүвийн сэлүүр (A) салаалаагүй IV-VI, салаалсан 7-12, цээжний сэлүүр (P) салаалаагүй I-II, салаалсан 11-16, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 8-10 гуурстай. Хажуугийн шугам 75-102 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт устаж болзошгүй, B2ab (i,ii,iii,iv,v). Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Хөвсгөл хадран нь 35 см, 310 гр хүрнэ. Хөвсгөл хадран нь 11 насална. 5-6 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Эхний бүл нь 4 сарын сүүлээс ус 6.8-10.0°C хэм болоход нуурт цутгаж буй голоо өгсөн хайрга чулуун ёроолд түрсээ шахна. 2 дахь бүл нь 7 сарын эхнээс 8 сарын эхэн хүртэл нуурын эргийн хайрга чулуунд болон голоо 3-5 км өгсөн түрсээ шахна. Атуу 1,100-4,200 түрс гаргана. Үржлийн дараа идэвхтэй идээшилнэ. Нуурын гүнээр тархан амьдрах Хөвсгөл хадран нь хөвөгч амьтдаар, эргийн дагуух нь ёроолын амьтан, хуурай газрын шавьжаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Гүний загас. Зундаа Хөвсгөл нуур, түүнд цутгадаг гол горхиор амьдарна. Өвөл нуурын 25 м-ийн гүнээс доош тархана.



ТАРХАЛТ

Хөвсгөл хадран зөвхөн Хөвсгөл нуур, түүний цутгал голуудад амьдардаг унаган загас.



DESCRIPTION

Body is tapering, dark or darkish, without spots. Dorsal fin edge is crimson. Adipose fin present. Body covered densely sitting medium scales. Head is long, upper jaw extends to middle of eye. In the jaw well developed teeth. Gill rakers number - 15-21. The dorsal fin (D) has VII-X unbranched soft rays, and 8-14 branched soft rays, the anal fin (A) has IV-VI unbranched soft rays, and 7-12 branched soft rays, and the pectoral fins (P) have I-II unbranched soft ray, and 11-16 branched soft rays, the pelvic fins (V) have II unbranched soft rays, and 8-10 branched soft rays. Lateral line with 75-102 scales.

CONSERVATION STATUS

Regionally Endangered B2ab (i,ii,iii,iv,v). The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from April 1st to June 15th.

BIOLOGY

Can reach up to 35 cm length, and weight 310 g. It can reach at least 11 years of age. Sexual maturity is attained in 5-6 years old. First spawning run occurs in spring from late April, when water temperature 6.8-10.0°C, in upper reaches of rivers, on gravel, cobble bottom. Second spawning run observed from early July to early August in near shore of the lake in gravel bottom or to 3-5 km to the top along the river. Female produce 1,100-4,200 eggs. After spawning feeding active. Pelagic Khuvsgul grayling feed primarily on zooplankton; near shore graylings feed on benthic invertebrates, and terrestrial insects.

HABITAT

Pelagic. Summer habitats situated in tributaries of the Khuvsgul Lake, spend winter in deep water more than 25 m.

DISTRIBUTION

Endemic of the Khuvsgul Lake, and its tributaries.

ЕНИСЕЙН ХАДРАН

Thymallus svetovidovi Dorogostaisky 1923
Upper Yenisei grayling



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие бахим. Биеийн үндсэн өнгө хар-саарал, нуруу хар, нэг өнгийн, хэвлий цагаан. Сүүлний сэлүүрийн бариул болон сүүлний сэлүүрийн суурь маш тод шар өнгөтэй. Хайрс том, нягт суурьшсан. Хошуу мөнхор, ам тэгш. Дээд эрүү нүдний голч хүрэхгүй. Хэвлийн сэлүүрээс дээш, хажуугийн шугамаас доош хайрс бүдэг улаавтар туяатай. Түүний дээд зах өргөн, зуйван. Нурууны сэлүүр хэд хэдэн эгнээ янз бүрийн хэлбэртэй хүрэн улаан толботой. Сэлүүрийн дунд хэсгээс толбо бөөрөнхий хэлбэртэй болж тод ялгарна. Дээд эгнээний толбо том, хэлбэр дүрсгүй. Өөхөн сэлүүр том, хөх ягаан өнгөтэй. Цээжний сэлүүр жигд шаравтар саарал өнгөтэй. Нурууны сэлүүр (D) 20-23 салаалсан гуурстай, сүвийн сэлүүр (A) 11-12 салаалсан гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Шивэр хадран загастай адил. Монгол оронд тархан амьдрах Енисейн хадрангийн талаар мэдээлэл хомс.



АМЬДРАХ ОРЧИН

Цэвэр, хүйтэн, хүчилтөрөгчөөр баялаг голд тархан амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлгээ хийгдээгүй.



ТАРХАЛТ

Дархадын хотгорын Шишхэд, Шаргын гол (Хойд мөсөн далайн ай сав), Тэсийн гол, Боршоо голд (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав) тэмдэглэсэн.



DESCRIPTION

Body massive. Main body coloration is gray-black, back dark, monotonous, belly white. Caudal peduncle and base of caudal fin high colored by yellow orange. Scale large, densely sitting. Snout oval, mouth terminal. Upper jaw not extending beyond midorbit. Above ventral fins, below lateral line, scales have a weak reddish shade. Its upper edge wide, oval. Dorsal fin pattern consists of several series of red-crimson spots of different shape. Closer to the middle on the fin, spots become rounded in the shape and well noticeable. Spots of the upper row are the largest, of an irregular shape. Adipose fin large, of lilac color. Pectoral fins monotonous, yellowish gray. The dorsal fin (D) has 20-23 branched soft rays, the anal fin (A) has 11-12 branched soft rays.



BIOLOGY

Biology is similar to Siberian grayling. There are no data from the territory of Mongolia.



HABITAT

Inhabits clear, cold, high oxygen rivers.



CONSERVATION STATUS

Regionally Not Evaluated.



DISTRIBUTION

Shishkhed and Sharga rivers (Darkhad Depression, Arctic ocean basin), and Tes and Borshoo rivers (Central Asian Internal Drainage Basin).

ЕРДИЙН ЦУРХАЙ

Esox lucius Linnaeus, 1758

Northern pike



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие сунаж уртгассан, сум хэлбэрийн. Нуруу оливын ногооноос ногоовтор бор; хажуу цайвар, эмх замбараагүй эгнээ бүхий жижиг зуйван шар толботой ба хайрс бүхний ирмэгээр жижигхэн алтлаг толботой, хэвлий кремэн цагаан. Хос биш сэлүүрүүд ногооноос цагаан, заримдаа улаавтараас улбар шар өнгөтэй ба хар толботой. Толгой уртавтгар, биеийн уртын дөрөвний нэгийг эзэлнэ. Доод эрүүний хоёр талд 5 том мэдрэхүйн нүх бий. Дээд доод эрүү, тагнай, хэлэн дээр хүчирхэг шүдтэй. Доод эрүү дээд эрүүгээ давсан. Хайрс жижиг, хажуугийн шугаманд 105-148 хайрстай. Нурууны сэлүүр сүвийн сэлүүрийн харалдаа байрлаж, нуруунаас хойшилж тогтсон. Хэвлийн сэлүүр биеийн дунд хэсэгт хэвлийн доор байрлана. Нурууны сэлүүр (D) салаалаагүй VI-X, салаалсан 13-17, сүвийн сэлүүр (A) салаалаагүй IV-VII, салаалсан 10-14, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 11-16, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I-II, салаалсан 7-12 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Цурхайн биеийн урт 1 м, жин 35 кг хүрнэ. 3-4 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 4-р сарын эцэс 5-р сард усны температур 3.0-6.0°C болох үеэс үржил эхлэнэ. Үржлийн үедээ нуурын эрэг, булан тохой, голын адаг орчмын намуун урсгалтай, ургамлын үлдэгдэл ихтэй, 0.5-1.0 м орчим гүнтэй хэсэгт сүрэглэн цугларна. Атуу 14,800-121,000 түрсийг эрэг орчмын усны ургамалд шахна. Түрс наалдамхай, голч 2.1-3.5 мм. Жарамгайн үедээ голлон хөвөгч амьтад, шавьжийн авгалдайгаар хооллож байгаад бие гүйцсэн үедээ загасаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Тогтуун урсгалтай томоохон гол, горхи, нуур, цөөрмийн ургамлаар баялаг хэсэгт тархан амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд зааснаар 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



ТАРХАЛТ

Сэлэнгэ мөрөн түүний цутгал голуудын адаг хэсэг, Өгий, Тэрхийн цагаан нуурт тархан амьдарна. Ердийн цурхайг Баруун Монголын Дөрөө нуурт зориудаар нутагшуулсан.



DESCRIPTION

Body elongate, arrowy. Back dark olive green to greenish brown; sides lighter, with irregular rows of small oval yellow spots and small gold spot on exposed edge of each scale; belly creamy white. Unpaired fins green to white, occasionally reddish orange, with darkish spots. Head one-fourth total length. Low jaw protrudes, with 5 large sensory pores on each side. Well developed teeth. Low jaw beyond upper jaw. Cheek and upper half of opercle scaled. Scales are small, 105-148 in lateral line. Dorsal fin is located opposite anal fin, engaged back. Pelvic fins in the medium body, under belly. The dorsal fin (D) has VI-X unbranched soft rays, and 13-17 branched soft rays, the anal fin (A) has IV-VII unbranched soft rays, and 10-14 branched soft rays, the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 11-16 branched soft rays, the pelvic fins (V) have I-II unbranched soft rays, and 7-12 branched soft rays.

BIOLOGY

Can reach up to 1 m length, and 35 kg weight. Sexual maturity is attained in 3-4 years old. Spawning occur since late April to middle May, when water temperature 3.0-6.0°C. During spawning pike accumulate in schools near shore or bay of lakes, in down reaches of the rivers with moderate current, and with abundance aquatic vegetation, on deep 0.5-1.0 m. Females produce 14,800-121,000 eggs, lays on water vegetation. Eggs sticky have diameter in 2.1-3.5 mm. Pike fry consume primarily on zooplankton, and larvae of insects; adults feed on fish.

HABITAT

Large slow-moving stream, lakes, and ponds with abundant aquatic vegetation.

CONSERVATION STATUS

Regionally least concern. The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from April 1st to June 15th.

DISTRIBUTION

The Selenga River, and down reaches of its tributaries, Ugii and Terkhinn Tsagaan lakes. Northern Pike intentionally introduced to Duree Lake in Western Mongolia.

АМАРЫН ЦУРХАЙ

Esox reichertii Dybowski, 1869

Amur pike



ЕРӨНХИЙ ШИНЖ

Амарын цурхай нь ердийн цурхайтай төстэй. Бие шувтан урт, суман хэлбэртэй, хүчирхэг шүдтэй. Нуруу бараан, хэвлий цайвар. Биеийн хажуугаар болон толгой дээр бөөрөнхий том хар бараан толботой. Хос бус сэлүүрүүд бараан толбонуудтай. Доод эрүү дээд эрүүг давсан. Нурууны сэлүүр нуруунаас хойш сүвийн сэлүүрийн харалдаа байрлана. Заламгайн хавхлаганы дээд хэсэг, шанаа нь хайрсаар хучигдсан. Нурууны сэлүүр сүвийн сэлүүрийн харалдаа байрлаж, нуруунаас хойшилж тогтсон. Хэвлийн сэлүүр биеийн дунд хэсэгт хэвлийн доор байрлана. Нурууны сэлүүр (D) салаалаагүй VI-VII, салаалсан 11-15, сүвийн сэлүүр (A) салаалаагүй IV-V, салаалсан 11-14 гуурстай. Хажуугийн шугам бүтэн, 135-165 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд зааснаар 4 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Амарын цурхайн биеийн урт 1.2 м, жин 16 кг хүрнэ. Биеийн урт 35.0-42.0 см хүрэхэд 6-7 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 4-р сарын эцэс 5-р сард усны температурын хэмээс хамааран түрсээ ургамалд шахан орхино. Түрс наалдамхай. Атуу 73,000-236,500 түрс гаргана. Түрсний голч 2.1-2.5 мм. Жилийн бүх улиралд идэвхитэй хооллогч махчин загас.




АМЬДРАХ ОРЧИН

Урсгал намуун, ургамал ихтэй, гүехэн хэсгээр зонхилон идээшлэнэ. Бие гүйцсэн Амарын цурхай нь Буйр нуурт нуурын гүн хэсгээр өсвөр насны цурхай зуны улиралд нуур, голын эрэг орчмын ургамалтай хэсгээр тархана. Өвөл нуурын гүн тийш шилжин нүүдэллэж, голын булан тохойн загас элбэгтэй гүн хонхорт өвөлжинө.



ТАРХАЛТ

Хэрлэн, Онон, Оршуун, Халх гол, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Amur pike is similar in appearance to Northern pike. Body elongate, arrowy, with well developed teeth. Back darkish, belly whitish, on sides and head with big round black spots. Median fins with darkish marking. Low jaw beyond upper jaw. Cheek and upper half of opercle scaled. Dorsal fin is located opposite of anal fin, engaged back. Pelvic fins in medium body, under belly. The dorsal fin (D) have VI-VII unbranched soft rays, 11-15 branched soft rays, the anal fin (A) have IV-V unbranched soft rays, and 11-14 branched soft rays. Lateral line complete, with 135-165 scales.



CONSERVATION STATUS

Regionally Least concern. The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from April 1st to June 15th.



BIOLOGY

Can reach up to 1.2 m, and weight 16 kg. They are mature in 6-7 years of ages, 35.0-42.0 cm length. Spawning late April to May, depending from water temperature, lays eggs on water plants. Eggs sticky. Female produce 73,000-236,500 eggs, with diameter in 2.1-2.5 mm. Piscivorous, around the year active eat.



HABITAT

Slow-moving stream, shallow with abundant aquatic vegetation. Buir Lake adult habitats in deep water, juvenals in summer habitat near shore of rivers and lakes with high abundance of aquatic vegetation. In winter move to the pelagic and deep bay of rivers with abundance fish.



DISTRIBUTION

Kherlen, Onon, Orshuun, Khalkh rivers and Buir lake.

ЗООДОЙ ЗАГАС

Abramis brama Cuvier, 1816

Common bream



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие хажуугаасаа хавтгай, нуруу өндөр, үл ялиг доод амтай. Ам хөдөлгөөнтэй. Бие гол төлөв мөнгөлөг саарал өнгөтэй, цэнгэг усанд хүрэн бор өнгөтэй харагдана. Сэлүүрүүд саарлаас хар өнгөтэй байдаг.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлгээ хийгээгүй.



ТАРХАЛТ

Байгаль нуурын сав газарт нутагшуулсан, Монгол орны Орхон, Туул голоос тэмдэглэсэн.




БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Зоодой загасны биеийн урт 55 см хүрнэ. 3-4 насандаа бэлгэ боловсорно. 4 сарын сүүлээс 6 сар хүртэл усны температур 17°C байхад үржинэ. Атуу 100,000-300,000 түрсийг усны ургамалд шахна. Ёроолын хэсгээр сүрэглэн амьдарна. Зоодой загас усны сээрнууруугүйтэн, жингэнүүр ялааны авгалдай, цөөн өргөст хорхой, зөөлөн биетэн төдийгүй усны ургамал, хөвөгч амьтдаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Зоодой загас нь голын доод хэсэг, шим тэжээлээр баялаг нуур, цөөрмийн замгаар баялаг, шаварлаг ёроол бүхий хэсэгт тархан амьдарна.



DESCRIPTION

It has a laterally flattened and high-backed body and slightly undershots mouth. Protractile mouth. It is a silvery grey color, or bronze-colored especially in clear waters. The fins are grayish to black.



CONSERVATION STATUS

Regionally Not Evaluated.



DISTRIBUTION

It has been introduced to the Baikal basin and self spread to Orkhon and Tuul rivers in Mongolia.



BIOLOGY

The bream reach 55 cm in length. In age 3-4 years old, it becomes sexually mature. Spawns from April to June, when water temperatures are around 17°C. The females produce 100,000 -300,000 eggs. Lay eggs on water plants. Lives in schools near the bottom. They feed primarily on aquatic invertebrates, larvae of chironomids, Tubifex worms, gastropods, water plants, detritus and plankton, as well.




HABITAT

The common bream lives in rivers, especially in the lower reaches and in nutrient-rich lakes and ponds with muddy bottoms.

ХЯТАДЫН ХУУРАМЧ ГҮРЦ

Abbottina rivularis Basilewsky, 1855
Chinese false gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Доод уруул үргэлжилсэн. Уруул соруулгүй. Дээд эрүүнд нэг хос богино сахалтай. Сүвийн нүх сүвийн сэлүүрээсээ илүү хэвлийн сэлүүрийн суурьтай ойролцоо байрлана. Бие хажуугийн шугамын дагуу найман бөөрөнхий бараан судалтай. Ам доод, нурууны сэлүүрийн үзүүр гүдгэр, сүүлний сэлүүр хэд хэдэн хөндлөн эгнээ бүхий хар толботой. Заламгайн өргөс 8-15. Нурууны сэлүүр (D) II-III салаалаагүй, 7-8 салаалсан гуурстай, сүвийн сэлүүр (A) II-III салаалаагүй, 5-7 салаалсан гуурстай. Хажуугийн шугам гүйцэд, 36-41 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлээгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Биеийн хамгийн урт 18.9 см хүрнэ. Биеийн урт 4.2 см хүрэхэд 1 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Атуух голын ёроолд 8-34 см гүнд 12-43 см-ийн диаметр бүхий үүр засна. Атуу 1,700 түрс шахна.




АМЬДРАХ ОРЧИН

Бие гүйцсэн загас голын гүехэн хэсэг, нуурын элсэрхэг болон шавран ёроолтой хэсэгт тархан амьдарна.



ТАРХАЛТ

Буйр нуурын харь зүйл (Номхон далайн ай сав).



DESCRIPTION

Lower lip continuous. No papilla on lips. One pair of short maxillary barbells. Anus close to ventral-fin base that to anal-fin base. Body with eight rounded dusky blotches along lateral line. Mouth inferior; dorsal with convex distal margin; several vertical rows of black spots on caudal. Number of gill rakers - 8-15. The dorsal fin (D) has II-III unbranched soft rays, and 7-8 branched soft rays, the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5-7 branched soft rays. Lateral line complete, with 36-41 scales.

CONSERVATION STATUS

Regionally Not Evaluated.

BIOLOGY

Non game species. Maximum body length is 18.9 cm. Becomes sexually mature in age 1 year when 4.2 cm length. The male build a nest 12-43 cm in diameter on the bottom of the rivers, at a depth of 8-34 cm. The females produce 1,700 eggs.

HABITAT

Adults inhabit shallow zones of lentic rivers and lakes with sandy or muddy bottoms.

DISTRIBUTION

Alien species of the Buir Lake (Pacific ocean basin).

ХАТГУУРТ ХАРВАА ЗАГАС

Acheilognathus asmussi Dybowski, 1872

Amur spiny bitterling



ЕРӨНХИЙ ШИНЖ

Халбаган жараагаас ялгагдах нь нурууны болон сүвийн сэлүүр хатгууртай, сүвийн сэлүүр урт, хажуугийн шугам бүрэн. Бие гүйцсэн бодьгалын дээд эрүүнд мэдэгдэх төдий сахалтай. Нуруу ногоовтор-бор, хажуу мөнгөлөг, заримдаа хөхөлбөр туяатай. Тод алтлаг хайрстай. Хэвлийн сэлүүрийн дээгүүр алтлаг толботой. Толгой жижигхэн. Ам тэгш. Нуруу өндөр, бие хажуу талаасаа хавчиг. Сүүлний хэсгээр тууш бараан зураастай. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 16-19, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 12-14 гуурстай. Залигуур араа нэг эгнээ 4-4 шүдтэй. Хажуугийн шугам 36-39 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт ховордож болзошгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Биеийн урт 16 см хүрнэ. 3 насандаа биеийн урт 7 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. 5 сарын сүүлчээс 7 сарын эхэн хүртэл түрсээ хэсэгчилэн шахна. Үржлийнхээ үед атуу дунгийн хясаан завсар түрсээ шахахад атуух нь тэнд нь үр тогтооно. Хосууд түрсээ хамгаалдаггүй. Атуу 300-1,100 ширхэг түрс гаргана. Хатгуурт харваа нь замаг, усны ургамлаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Энэ загас сэрүүн уур амьсгалтай бүсийн 18-22°C хэмийн дулаантай усанд амьдардаг. Голын торгон элсэрхэг ёроолтой зөөлөн урсгалтай тогтуун хэсэг, нуурт тархан амьдарна.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Халх, Оршуун гол, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

A distinguished Amur bitterling, dorsal and anal fins are with spiny rays, dorsal fin long, and lateral line is complete. In upper jaw of adult have unfamiliar barbells. Back is grayish brown, on side is silvery, sometimes bluish. Scales are light gold. Pelvic fins have goldish spots. Head small. Mouth terminal. High-backed and a laterally flattened. Near the caudal fin have greyish stripes. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 16-19 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 12-14 branched soft rays. The pharyngeal teeth are in a single row, usually 4-4. Lateral line with 36-39 scales.



CONSERVATION STATUS

Regionally Near Threatened.



BIOLOGY

Non game species. Maximum body length is 16.0 cm. Sexual maturity is attained in 3 years old, with length 7.0 cm. Spawning from late May to early July, lay eggs by little by little. When spawning, female hides eggs inside mussels the male fertilizes them externally. The pair does not guard the eggs. The females produce 300-1,100 eggs. They feed on algae and aquatic plants.



HABITAT

It lives in a temperature climate in water with a temperature range 18°-22°C. It lives in rivers with a sandy bottom and a moderate current, and also in lakes.



DISTRIBUTION

Kherlen, Onon, Khalkh, Orshuun rivers and Buir Lake (Pacific ocean basin).

АЛТЛАГ ХЭЛТЭГ

Carassius carassius Linnaeus, 1758

Crucian carp



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие алтлаг бор гялалзсан өнгөтэй, хэвлий цайвар. Сэлүүрүүдийн үзүүр бараан улаавтар. Хоншоор дугариг. Хайрс гөлгөр. Нурууны сэлүүр өндөр, гүдгэр дугуй. Сүүлний ухлаадас бага. Бие өндөр, бөөрөнхий. Нуруу зузаан. Хайрс том, хажуугийн шугаманд 32-36 хайрстай. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 14-21, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 6-8 гуурстай. Залигуур араа нэг эгнээ 4-4 шүдтэй, мохоо. Заламгайн өргөс 31-36.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 64 см, жин 5.0 кг хүрнэ. Гол төлөв 24 см, 600 гр жинтэй тохиолдоно. 4-5 насандаа бие гүйцэж үржилд орно. Усны температур 14 хэм болоход түрсээ шахаж эхэлнэ. Үржлийнхээ үед атуу түрсээ хэсэг хэсгээр усны ургамалд шахна. Атуу 300,000 ширхэг түрс гаргана. Агнуурын ач холбогдолтой. Алтлаг хэлтэгний жараахай хөвөгч амьтдаар хооллох ба бие гүйцсэн үедээ ургамал, хөвөгч амьтад, усны ёроолын шавьжийн авгалдай, ялзмагаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Бүлээн усны загас. Голдуу намгархаг, ургамал их ургасан нуурын тохой, голын урсгал багатай, тогтуун хэсэгт тархан амьдарна.



ТАРХАЛТ

Булган голд тархан амьдарна.



DESCRIPTION

Body color is golden bronze shining, belly silver. Fins edges are dark reddish. The snout well rounded. Scales are mirror. The dorsal fin is higher and convexly rounded. Caudal fin bluntly lobed. Body shape is high, circular. Back is thick. Scales large, lateral line with 32-36 scales. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 14-21 branched soft rays, the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 6-8 branched soft rays. The pharyngeal teeth are in a single row, usually 4-4, are blunt. Gill rakers number - 31-36.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable. The Mongolian Law on Fauna prohibits the catching of this fish from April 1st to June 15th.

BIOLOGY

Can reach up to 64 cm length, and 5.0 kg weight. Usually in length 24 cm, and in weight 600 g. Sexual maturity is attained in 4-5 years old. Spawning starts when water temperature is 14°C. Females lay eggs to aquatic vegetation by little by little. Female produce 300,000 eggs. Commercial species. The Crucian carp fry feed on zooplanktons, adults preliminary feed on plant material, zooplankton, larvae of insects, other benthic invertebrates and detritus.

HABITAT

Usually inhabit muddy lakes with abundance vegetations and slow moving rivers.

DISTRIBUTION

In Mongolia it was found only in the Bulgan River.

МӨНГӨЛӨГ ХЭЛТЭГ

Carassius gibelio Bloch, 1782
Prussian carp



ЕРӨНХИЙ ШИНЖ

Мөнгөлөг хэлтэг хавтгай. Бие ногоон, ногоовтор бор, хайрс нь захаараа бараан эмжээртэй. Шөвгөр хоншоортой. Нурууны сэлүүр урт. Нурууны сэлүүрийн хэлбэр хотгор. Хайрс том, нягт сууж өгсөн, хажуугийн шугаманд 27-31 хайрстай. Ам тэгш. Сүүлний сэлүүрийн ухлаадас Алтлаг хэлтэгээс их. Залигуур араа нэг эгнээ 4-4 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 15-17, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 5 гуурстай. Заламгайн өргөс 41-51.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 15-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 45 см, жин 1.0 кг хүрнэ. Гол төлөв 20 см, 350 гр жинтэй тохиолдоно. 2-3 насандаа биеийн урт 12 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. Үржил 5-р сарын сүүлийн хагасаас 7-р сарын дунд үе хүртэл усны температур 14-15°C хэмд үргэлжилнэ. Үржлийн хугацаандаа 3 удаа түрээ хэсэгчилэн усны ургамалд шахна. Атуу 32,000-135,000, дунджаар 78,600 ширхэг түрс гаргана. Мөнгөлөг хэлтэг нь элдэв идэшт. Гол төлөв хөвөгч амьтад, усны ёроолын шавьжийн авгалдай, замаг, усны ургамал, органик ялмагаар холлоно.




АМЬДРАХ ОРЧИН

Бүлээн усны загас. Хүчилтөрөгчийн дутагдал багатай, бага зэргийн бохирдсон усанд амьдрах чадвартай. Ихэвчлэн нуурын эргийн усны ургамал бүхий хэсэгт амьдарна. Хүчилтөрөгчөөр дутмаг, тогтуун усанд өвөлжинө.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Онон, Хэрлэн, Улз, Цөх гол, Халх гол, Хөх, Буйр, Дөрөө, Тээлийн цагаан нуурт тархан амьдарна. Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрний сав Орхон, Хараа, Ерөө, Туул, Өгий нуурт нутагшсан.



DESCRIPTION

The Prussian carp is a deep-bodied. Body color is a gray, greenish brown, scales edges are dark. More pointed snout. Dorsal fin is long and concave in shape. Scales large, setting deeply, lateral line with 27-31 scales. Mouth terminal. Caudal fin more deeply forked than in Crucian carp. The pharyngeal teeth are in a single row, usually 4-4. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 15-17 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 5 branched soft rays. Gill rakers - 41-51.

CONSERVATION STATUS

Regionally Least Concern. The Mongolian Law on Fauna prohibits the catching of the Buir Lake fish from May 15th to August 1st.

BIOLOGY

Can reach up to 45 cm length, and 1.0 kg weight. Usually 20 cm in length, and 350 g in weight. Sexual maturity is attained in 2-3 years old, when length 12 cm. Spawning since late May to middle July when water temperature is 14°C-15°C. Females lay eggs on aquatic vegetation 3 times by little by little. Females produce 32,000-135,400 eggs, in an average 78,600 eggs. Commercial species. The Prussian carp are omnivores. Prussian carp feed heavily on algae; consume zooplankton, large amount of detritus, aquatic macrophytes, insect larvae and other benthic invertebrates.

HABITAT

Warm water species. Can strongly tolerate low oxygen concentrations and pollution. Usually inhabit shallow waters, near shores of lake with heavy growths of aquatic vegetation. Often oxygen-deficient water in areas where winters are mild.


DISTRIBUTION

In Mongolia native for Onon, Kherlen, Ulz, Khalkh rivers, Khukh, Buir, Duree and Teelin Tsagaan lakes (Pacific ocean basin). It has been introduced to the Baikal Basin and found in the Selenga River and its tributaries Orkhon, Kharaa, Eruu, Tuul rivers and Ugii lake (Arctic Ocean basin).

ЦАГААН ДОГТОР

Chanodichthys erythropterus Basilewsky, 1855

Red fin culter



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу боровтор-шар, заримдаа боровтор ногоон. Биеийн хоёр хажуу ба хэвлий мөнгөлөг. Цээжний сэлүүр шаргал, хэвлийн болон сүвийн сэлүүр цайвар-ягаан туяатай. Доод эрүү дээшээ хүчтэй матийсан. Ам дээд. Бүх сэлүүрүүдийн үзүүр бараан. Хайрс жижиг, хайрс тус бүрийн захаар олон тооны хар цэгээс тогтсон эмжээртэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7-8, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 21-25 гуурстай. Заламгайн эхний нуманд 22-27 өргөстэй. Хажуугийн шугам 81-96 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд зааснаар Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 15-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын загас. Биеийн урт 100 см, жин 9 кг хүрнэ. 6-7 насандаа биеийн урт 40 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. 7 сард түрсээ усны гүнд элсэрхэг хөрсөнд шахна. Атуу 65,500-554,000 ширхэг түрс гаргана. Жараахай хөвөгч амьтдаар хооллож байгаад 6-7 см хүрэхэд загасаар хооллодог. Идэш тэжээлийн бүрэлдэхүүнд нь хавчиг загас, хэлтэг, амарын сугас орно. Усны гүнд хавчаар хооллодог.




АМЬДРАХ ОРЧИН

Цэнгэг усны загас. Нуурын гүнд 3-20 м-д тархан амьдарна. Намар гол руугаа орон идэвхитэй хооллодог.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Back darkish-yellow, sometimes darkly-green, on sides or belly silvery. Pectoral fins tawny, pelvic fins and anal fin white-pink. Low jaw strongly upper. Mouth superior. All fins edges are darkish. Scales small, many black spots on exposed edge of each scale. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7-8 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 21-25 branched soft rays. Gill rakes in the first arch - 22-27. Lateral line with 81-96 scales.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable. The Mongolian Law on Fauna prohibits the catching of the Buir Lake fish from May 15th to August 1st.



BIOLOGY

Commercial specie. Can reach up to 100 cm length, and 9 kg weight. Sexual maturity is attained in 6-7 years old, with length 40.0 cm. Spawns in July, lays eggs to sand in deep water. Female produce 65,500-554,000 eggs. Red fin culter fry feed on zooplankton and become piscivorous in length 6-7 cm, in deep water feed on crustations.



HABITAT

Fresh water. Inhabits in deep 3-20 m of lake. In fall move to the rivers and feed active.




DISTRIBUTION

Buir lake of the Pacific ocean basin.

МОНГОЛЫН УЛААН ДАЛБААТ

Chanodichthys mongolicus Basilewsky, 1855 = *Erythroculter mongolicus*
Mongolian culter



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу ногоон туяатай саарал. Биеийн хажуу мөнгөлөг, жижиг хайрсаар хучигдсан. Хэвлий, сүвийн сэлүүр болон сүүлний сэлүүрийн доод хэсэг улаан, цээжний сэлүүр бараан өнгөтэй. Бие бөндгөр зузаан бус. Ам том, тэгш, доод эрүү бага зэрэг давсан. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II-III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 17-22 гуурстай. Заламгайн эхний нуманд 16-20 өргөстэй. Хажуугийн шугам 72-83 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 15-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 100 см хүрнэ. 5 насандаа биеийн урт 30 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. 5 сарын сүүлч 6 сарын эхээр урсгал сөрж, хүчилтөрөгчийн хангамж сайтай голын эхэн хэсгээр нүүдэллэн үрждэг. Атуу 21,400-113,100 ширхэг түрс гаргана. Түрс саарал өнгөтэй. Түрс нь наалдамхай чанартай, урсгалаар зөөгдөн усан дахь янз бүрийн субстратад наалдана. Түрсний голч 1.2 мм. Жараахай хөвөгч амьтдаар хооллож байгаад 5-6 см хүрэхэд загасаар хооллож эхэлнэ. Махчин загас.




АМЬДРАХ ОРЧИН

Цэнгэг усны загас. Усны гүн хэсгээр зонхилон амьдардаг.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуур, Халх голд тархан амьдарна.



DESCRIPTION

Back darkish-gray, on sides silver, body covered by small scales. Pelvic, anal and caudal fins below red, pectoral fins dark. Body knobby, not thick. Mouth large, terminal, low jaw little upper. The dorsal fin (D) has II-III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 17-22 branched soft rays. Gill rakers in the first arch 16-20. Lateral line with 72-83 scales.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable. The Mongolian Law on Fauna commercial fishes of Buir Lake prohibits the catching from May 15th to August 1st.

BIOLOGY

Can reach up to 100 cm length. Sexual maturity is attained in 5 years old, about in 30.0 cm long. Spawning since late May to early June, in rivers, in sites with high current velocity and high oxygen concentration. Female produce 12,400-113,100 eggs, about 1.2 mm in diameter. Egg color is gray, and pastiness, their eggs drifting by current and sticks any substrates. The fry feed on zooplankton and feed on fish about 5-6 cm long. Piscivorous.

HABITAT

Fresh water specie. Habitats in deep water.

DISTRIBUTION

Buir Lake and Khalkh and Orshuun rivers (Pacific ocean basin).

ЦАГААН АМАР

Ctenopharyngodon idella Valenciennes, 1844

Grass carp



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие урталтар, хажуугаасаа хавчиг биш, махлаг, торпед хэлбэртэй. Нуруу оливийн ногоон, биеийн хажуу бор шаргал, хэвлий цайвар, сул суусан том хайрстай. Ам тэгш бага зэрэг хагас, махлаг, хатуу уруулаар хүрээлэгдсэн, сахалгүй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 8 гуурстай. Заламгайн өргөс богино, цөөн 12-18. Залигуур араа өргөн, 2 эгнээ 2.4-4.2 хөрөө шиг хүчирхэг шүдтэй. Хажуугийн шугам бүтэн 32-42 хайрстай.



АМЬДРАХ ОРЧИН

Нуур, цөөрөм, цүнхээл, томоохон голын тохой, ургамал бүхий намуун урсгалтай, тогтуун усанд тархан амьдарна.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт дунджаар 60-120 см, жин 40 кг хүрнэ. 7-8 насандаа биеийн урт 65-70 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. Зун 6 сараас 7 сар дуустал усны дулаан 26-30 хэм болоход түрсээ хэсэгчилэн шахаж үржинэ. Атуу биеийн хэмжээнээс хамааран 237,000-1,686,000 (дунджаар 800,000) түрстэй. Түрсний голч 1.0-1.3 мм. Түрс нь уснаас бага зэрэг хүнд учир урсгалаар доош зөөгдөн урсгалын тусламжтайгаар хөвдөг. Хэрвээ түрс нь усны ёроолд доош буувал үхнэ. Өсвөр насны загас нь хөвөгч амьтад, жингэнүүр ялаа хириномидын авгалдай, симулидын авгалдай болон замгаар хооллоно. Бие гүйцсэн нь ургамлаар хооллоно. Мөн усны ургамал болон усанд автсан эргийн ургамал, ялзмаг, шавьж болон бусад сээрнууруугүйтэнээр хооллоно.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуурт тэмдэглэгдсэн төдий.



 **DESCRIPTION**

Grass carp have elongated, chubby, massive, torpedo-shaped forms. Body color is dark olive, shading to brown-yellowish on the sides, with a white belly and large, slightly outlined scales. The terminal mouth is slightly oblique with non-fleshy, firm lips, and no barbels. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 8 branched soft rays. Gill rakers short, low number (12-18). Broad, ridged, pharyngeal teeth are in two rows, have formula 2.4-4.2. The complete lateral line contains 32-42 scales.

 **DISTRIBUTION**

Buir Lake (Pacific ocean basin)

 **BIOLOGY**

The average length is about 60-120 cm, and they grow up to 40 kg. Sexual maturity is attained in 7-8 years old, when 65-70 cm length. Spawning from June to July when water temperature increases up to 26-30°C. Can spawn multiple times in a season. Females produce 237,000-1,686,000 (average 800,000) eggs, about 1.0-1.3 mm in diameter. Their eggs, which are slightly heavier than water, develop while drifting downstream, kept in suspension by turbulence. The eggs are thought to die if they sink to the bottom. Juveniles feed on zooplankton, chironomids and black fly (Simuliidae) larvae, and algae. Adults feed mainly on aquatic plants and submerged terrestrial vegetation, but also consume detritus, insects and other invertebrates.

 **HABITAT**

Grass carp occurs in lakes, ponds, and backwaters of large rivers, prefer large, slow-flowing or standing water bodies with vegetation.

 **CONSERVATION STATUS**

Regionally Not Applicable.

ӨЛГӨР ЦАГААН

Culter alburnus Basilewsky, 1855
Topmouth culter



ЕРӨНХИЙ ШИНЖ

Өлгөр цагааны бие урт, хажуугаасаа хавчигардуу. Нуруу ногоовтор-саарал, биеийн хажуу ба хэвлийн мөнгөлөг цагаан, хайрсны захаар бараан эмжээртэй. Ам дээд, сахалгүй. Сүвийн сэлүүр урт, эхний 10 орчим цацраг тод улаан ягаан, хэвлий, сүүлний сэлүүрийн доод хэсэг улбар өнгөтэй. Нурууны сэлүүрт маш хатуу гуурстай. Цагаан Амар загастай харьцуулахад хэвлий болон сүвийн сэлүүр хүртэл үргэлжилсэн хянгатай, хянган хэсэг хайрсгүй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 23-29 гуурстай. Заламгайн өргөс 23-30. Залигуур араа 3 эгнээ өргөн шүдтэй: 2.4.4-5.4.2 эсвэл 2.4.5-4.4.2. Хажуугийн шугам 66-73 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд зааснаар Буйр нуурын загасыг 05 сарын 15-наас 08 сарын 01 хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 35 см хүрнэ. 4 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 6 сарын эхээс голын эхэн болон адаг хавиар цугларч түрсээ шахна. Бэлгийн булчирхай дотор эрхтэний хоёр талаар биш, хэвлийн хөндийн дунд нэг уутанд боловсордог. Атуу 18,600-89,400 ширхэг түрсийг нуурын эргийн зэгс, ургамалд шахна. Түрсний голч 1.0-1.3 мм, цэнхэр ногоон өнгөтэй. Өсвөр насны өлгөр цагаан нь хөвөгч амьтдаар хооллож байгаад бие гүйцсэн үедээ загасаар хооллоно. Түүний идэш тэжээлд хэлтэг, амарын сугас зонхилно.




АМЬДРАХ ОРЧИН

Нуурын усанд амьдрахад зохилдсон загас юм. Дулааны улиралд зэгс, ургамалтай газрыг бараадан эрэг хавиар идээшилж, намар гүн тийш орох боловч голын адаг хавьд зонхилон өвөлжинө.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуур, түүний холбоо Баян нуур, Халх голын адагт тархан амьдарна.



DESCRIPTION

Topmouth culter has elongated compressed body. Back green-gray, on the sides and above silvery white, edge of scale dark. Superior position of the mouth, no barbels. The anal fin is long, first 10 rays bright red pink, pelvic and anal fins below reddish. The dorsal fin (D) has very strong spine. Compared with grass carp, the topmouth culter has a keel, it continues to pelvic and anal fins, and it lack scale. The dorsal fin has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 23-29 branched soft rays. Number of gill rakes -23-30. Broad, pharyngeal teeth are in three rows, have formula 2.4.4-5.4.2 or 2.4.5-4.4.2. Lateral line with 66-73 scales.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable. The Mongolian Law on Fauna commercial fishes of the Buir Lake prohibits the catching from May 15th to August 1st.

BIOLOGY

Can reach up to 35 cm length. Sexual maturity is attained in 4 years old. Spawning from early June in upper and down reaches of rivers. Females produce 18,600-89,400 eggs, about 1.0-1.3 mm in diameter and lay eggs on aquatic vegetation. Juveniles feed on zooplankton, and adults feed on fish.

HABITAT

Usually inhabits lakes. In summer occurs near shore with aquatic vegetation, and winters in down reaches of the rivers.

DISTRIBUTION

Buir Lake, Bayan Lake, the Khalkh River (Pacific ocean basin).

БУЛУУ ЦАГААН

Cyprinus carpio haematoptus Temminck et Schlegel, 1846
Amur carp



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие цул, бага зэрэг хавчигдуу. Биеийн дээд хэсэг оливын бор, биеийн хажуу алтлаг, хэвлий шаравтар, сэлүүрүүд оливын хар, хайрсны захаар бараан эмжээртэй. Дээд уруулдаа хоёр хос богинохон сахалтай. Урагшаа сунасан амтай. Нурууны сэлүүр урт. Нуруу болон сүвийн сэлүүрийн эхний ясан гуурс хөрөө мэт шүдэлсэн. Залигуур араа гурван эгнээ 1.1.2-3.1.1 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 15-20, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 5-6 гуурстай. Заламгайн өргөс 23-28. Хажуугийн шугаманд 32-40 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 15-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 120 см, жин нь хамгийн ихдээ 42 кг-аас давна. Гол төлөв 35-55 см урттай, 1-3 кг жинтэй тохиолдоно. 65 насална. 3-5 насандаа биеийн урт 25 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. 6 сард усны температур 17-20°C хэм болоход үржинэ. Үржлийн хугацаандаа түрсээ хэд хэдэн удаа хэсэгчилэн усны ургамалд шахна. Түрс наалдамхай чанартай. Атуу 9,000 - 1,800,000 ширхэг түрс гаргана. Булуу цагаан ёроолын идэшт бөгөөд зөөлөн биетэн, шавьжийн авгалдайгаар зонхилон хооллохоос гадна мөн усны ургамлаар хооллоно. Буйр нуурын агнуурын үндсэн загас, загас агнуурын 16.9-23.6 хувийг эзэлдэг.




АМЬДРАХ ОРЧИН

Бүлээн усны загас, хамгийн тохиромжтой температур нь 23-30°C. Гол, нуур, цөөрөм болон цэнгэг, булингартай усан сангийн шавар, шаварлаг хөрстэй хэсгийн ургамалтай хэсгээр тархан амьдарна. Нуурын гүн, голын адгийн цүнхээлд өвөлжинө.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Онон, Хэрлэн, Халх гол, Дөрөө, Буйр нуурт тархан амьдарна. 1935 онд Амар мөрний саваас Ангар мөрөнд (Енисей голын сав) нутагшуулсан булууцагаан загас нь Сэлэнгэ мөрөн өгсөж Орхон голоор дамжин Өгий нуурт суурьшсан (Хойд мөсөн далайн ай сав).



DESCRIPTION

Body robust, moderately compressed. Brown olive above, sides goldish; yellowish below; fins dusky olive, scales edges darkish. 2 pairs short barbells on upper lip. Forward-protruding mouth. Dorsal fin long. Dorsal and anal fins each with 1 stout serrate spine. Pharyngeal teeth are in three rows, have formula 1.1.2-3.1.1. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 15-20 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 5-6 branched soft rays. Number of gill rakers - 23-28. Lateral line complete, with 32-40 scales.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable. The Mongolian Law on Fauna commercial fishes of the Buir Lake prohibits the catching from May 15th to August 1st.

BIOLOGY

Can grow to a maximum length of 120 cm, a maximum weight of over 42 kg. Usually 35-55 cm in length, and 1-3 kg in weight. Can reach at least 65 years of age. Sexual maturity is attained in 3-5 years old, about 25 cm long. In June spawning beginning at 17°-20°C. Amur carp spawn multiple times in a season. Eggs sticky. Lay eggs on aquatic vegetation. Females produce 9,000-1,800,000 eggs. Omnivorous. Amur carp prefer mollusks, and insect larvae, can eat water vegetation. It is main commercial species of Buir lake and occupied 16.9-23.6% of annual harvest.

HABITAT

Amur carp prefer warm waters; the ideal temperature is 23-30°C. Inhabits rivers, lakes, ponds, oxbow systems, and reservoirs with both clear and turbid waters and aquatic vegetation, and mud or silt bottom. Wintering in deep water of lake and pools of down reaches of rivers.

DISTRIBUTION

Amur carp historically inhabits Onon, Kherlen, and Khalkh rivers, and in Duree and Buir lakes of the Pacific ocean basin. Has been introduced in 1935 to the Angara River (The Yenisey River basin), then self spread to Selenga and Orkhon rivers and Ugii Lake in Mongolia (Arctic ocean basin).

СУГАСАН ГҮРЦ

Gnathopogon strigatus Regan, 1908
Manchurian gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие уртавтар. Нуруу шаравтар-бор, хоёр хажуу боровтор алтлаг, хэвлий шаравтар ба тууш бараан толбонуудтай буюу бүслүүртэй. Биеийн өндөр уртын 21.4-27.7%-ийг эзлэнэ. Сүүлний урт биеийн уртын 21.2-27.1%-тай тэнцүү. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 6 гуурстай. Хажуугийн шугам 38-40 хайрстай.



АМЬДРАХ ОРЧИН

Нуурт цутгах голын хоолойд сүрэглэн идээшлэх ба нуурт ховор тохиолдоно.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 10.4 см хүрнэ. 2+ насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 6-р сарын эхнээс 7-р сарын сүүлч хүртлэх хугацаанд үрждэг. Түрсээ хэсэгчилэн шахах ба түрс нь 3.4-4.3 мм диаметртэй бөгөөд усны ёроолд дүүжлэгдэн орхигдоно. Усны ёроолын сээр нуруугүйтэн амьтдаар хооллоно.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуурт тэмдэглэгдсэн.



DESCRIPTION

Elongate. Back yellowish-brown, sides gray goldish, below yellowish, and brown mid-lateral spots or with stripe. Body depth is 21.2-27.7% of body length. Caudal fin length is 21.2-27.1% of body length. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has II unbranched soft rays, and 6 branched soft rays. Lateral line with 38-40 scales.

HABITAT

Habitats in mouth of river, and rare in lakes.

BIOLOGY

Non game small fish. Maximum body length is 10.4 cm. They mature in age 2+. Spawning from early June to late July. Spawning takes place multiple times in a season in water column. Manchurian gudgeon has pelagic eggs 3.4-4.3 mm in diameter. They feed on benthic invertebrates.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable

DISTRIBUTION

Buir Lake (Pacific ocean basin)

ШИВЭР ГҮРЦ

Gobio gobio cynocephalus Dybowski, 1869
Dog-faced gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие богино, хос сахалтай. Нуруу ногоовтор бор, хажуу 8-11 бараан толботой. Хэвлий шаравтар туяатай мөнгөлөг. Хошуу урт. Толгойн урт биеийн уртын 22-27%-ийг эзэлнэ. Нуруу болон сүүлний сэлүүрүүд бараан толботой бусад сэлүүрүүд саарал. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7 (8), сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 6 (7) гуурстай. Хажуугийн шугам 38-48 хайрстай.



АМЬДРАХ ОРЧИН

Голын загас. Голын эргийн хайрга чулуун ёроолтой хэсгээр тархан амьдарна.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Биеийн урт 20 см хүрнэ. 2-3 насандаа биеийн урт 8 см болоход бэлгэ боловсорч үржилд орно. Голын урсгалтай хэсгийн хайрга чулуунд түрсээ хэсэг хэсгээр шахна. Үржил 4 сараас 6 сар хүртэл үргэлжилнэ. Атуу 1,000-3,000 ширхэг түрс гаргана. Сүрэглэн амьдарна. Шивэр гүрцийн жараахай ёроолын жижиг сээрнуруугүйтэн амьтдаар хооллодог бол бие гүйцсэн нь жингэнүүр ялааны авгалдай, өдөрч шавьжийн авгалдай, жижиг зөөлөн биетэн, хавартаа бусад загасны түрсээр хооллоно.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

Онон, Хэрлэн, Халх, Буйр нуурт тархан амьдарна. Сэлэнгэ мөрөн түүний ай савын голууд, Булган голд тохиолдох магадлалтай.



DESCRIPTION

Body short, with pair of barbells. Back grayish brown, sides with 8-11 dark gray spots, below silvery yellowish. Snout long. Head length is 22-27% of body length. Dorsal and caudal fins membranes with small dark spots, and other fins grayish. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 (8) branched soft rays, the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 6 (7) branched soft rays. Lateral line with 38-48 scales.



HABITAT

Inhabit in littoral zone of rivers with gravel and cobble bottom



BIOLOGY

Non game species. Maximum body length is 20 cm. They mature in 2-3 years old, about 8 cm long. Spawns in rivers with riffles on gravel bottom, lay eggs multiple times in a season. Spawning continuous from April to June. Females produce 1,000-3,000 eggs. Forms schools. Juveniles feed on small benthic invertebrates, and adults feed on chironomids and mayflies larvae, small mollusks, in spring feed on fish eggs.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



DISTRIBUTION

Dog-faced gudgeon inhabits Onon, Kherlen, Khalkh rivers and Buir Lake (Pacific ocean basin). May be in the Selenga River, its tributaries, and the Bulgan River.

САХАЛТ ГҮРЦ

Gobio albipinnatus tenuicorpus Mori, 1934
Eastern white fin gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу жижиг бараан толбо бүхий шаравтар-бор, хажуу мөнгөлөг, хэвлий цайвар. Биеийн хажуугаар хажуугийн шугам дагууд толботой. Бүслүүрүүд цайвар. Толгойн урт биеийн уртын 25-31%-ийг эзлэнэ. Сахал нь нүдний хойд захын босоо шугам хүртэл буюу заламгайн хавхагны өмнөт ясны хойд зах хүртэл, заримдаа түүнээс урт байдаг. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5-6 гуурстай. Хажуугийн шугам 42-49 хайрстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Биеийн урт 12 см хүрнэ. 2 насандаа үржилд орно. Ёроолын жижиг сээрнууруугүйтэн амьтад, усны ургамлаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Цэнгэг усны индикатор загас. Голын загас, цэвэр, хүчилтөрөгчөөр баялаг, ширүүн урсгалтай хэсгээр зонхилон амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Халх, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Back yellowish brown with small grayish spots, side's silvery, below slightly. On sides under lateral lines have spots, slightly stripe. Head length is 25-31% of body length. Barbells long, extends at least as far back of eye and until to back of opercle or farther. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5-6 branched soft rays. Lateral line with 42-49 scales.



BIOLOGY

Non game species. Maximum body length is 12 cm. They mature in 2 years old. Feed on small invertebrates, and water vegetation.



HABITAT

Fresh water indicator specie. Riverine fish preferring clear, well-oxygenated, running waters.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.



DISTRIBUTION

The Khalkh River, Buir Lake (The Pacific Ocean basin)

ЕРДИЙН ГҮРЦ

Gobio gobio acutipinnatus Menschikov, 1939

Markakul gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу бор шаргал, хажуу шаргал, хэвлий цайвар. Биеийн дунд хэсгээр хажуугийн шугамын дээр 10-14 хар толботой. Нуруу болон сүүлний сэлүүрүүд бараан толботой. Хошуу монхор. Хэвлий болон сүвийн сэлүүрийн хоорондын зай ойрхон. Хажуугийн шугам 40-43 хайрстай. Сүүлний бариул богино, нарийхан түүний урт биеийн ургаас 4-5 дахин бага. Залигуур араа 2 эгнээ 3.5-5.3 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 6 (7) гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 20 см-ээс хэтрэхгүй. 5-6 сард үржиж, түрсээ усны ёроолын элс хайрган хурдас дээр шахна. Усны ёроолын шавьжаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Голын эргийн урсгал бүхий хайрга, чулуун хэсгээр амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Иртыш мөрний сав газрын нуур, голуудаар тархан амьдарна. Монголд зөвхөн Булган голд тэмдэглэгдсэн.



DESCRIPTION

Back brown yellow, sides yellow, bellow slightly. On sides above lateral line have 10-14 dark spots. Dorsal and anal fins membranes with dark spots. Blunt snouted. Distance between pelvic and anal fins is short. Caudal peduncle short, narrow, and 4-5 times shorter than body length. Lateral line with 40-43 scales. Pharyngeal teeth are in two rows, with 3.5-5.3 formula. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 6 (7) branched soft rays.



BIOLOGY

Body length not exceeds 20 cm. Spawning from May to June, lay eggs on sand, and gravel bottom. Feed on aquatic benthic insects.



HABITAT

Inhabits sites near the shore of river with gravel, and stones on the bottom.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.



DISTRIBUTION

Inhabits lakes and rivers of the Irtysh River basin. In Mongolia recorded only in the Bulgan River.

СОЛДАТОВЫН ГҮРЦ

Gobio soldatovi tungusicus Borisov, 1928
Soldatov's gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие дунд зэргийн урттай, хажуугаасаа хавчиг бус. Биеийн хажуугаар тууш бараан зурвастай. Заламгайн хавхагны ард хар толботой. Нуруун дээр бөөрөнхий хар толботой. Нурууны болон сүүлний сэлүүрүүд дээр эгнээ бараан толботой ба бусад сэлүүрүүд өнгөгүй. Ам доод. Сахал богино. Хошууны урт нүдний арын зайнаас бага. Хоолойн хэсэг хайрсгүй. Хэвлийн сэлүүр сүвийн сэлүүр бараг хүрнэ. Залигуур араа 2 эгнээ 2.5-5.2 эсвэл 3.5-5.2 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 6 гуурстай. Хажуугийн шугам 35-42 хайрстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт гол төлөв 8-10 см, хамгийн урт нь 12 см хүрнэ. 4 хүртэл наслана. 2 насандаа биеийн урт 5 см хүрэхэд бэлгэ боловорч үржилд орно. Үржил 6 сараас 7 сарыг дуустал үргэлжилнэ. Атуу түрсээ хайрга чулуунд хэсэгчилэн шахна. Сүрэглэн амьдардаг загас. Усны ёроолын шавьж, гол төлөв жингэнүүр ялааны (хирономид) авгалдайгаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Гол төлөв нуурт амьдардаг, зундаа голын цутгал хавиар идээшилнэ.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуур, Халх голд тархан амьдарна.



DESCRIPTION

Moderately elongate, not compressed. Sides with broad black mid-lateral stripes. Behind opercle has black spot. Back with round spots. Black spots extend into dorsal and caudal fins, other fins clear. Mouth inferior, barbels are short. Length of snout shorter than behind of eye distance. Cheek lack scales. Pelvic fin's edge reaches to anal fin. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-5.2 or 3.5-5.2. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has II unbranched soft rays, and 6 branched soft rays. Lateral line with 35-42 scales.



BIOLOGY

The maximum length is 12 cm, usually 8-10 cm in length. Can reach at least 4 years of age. Maturity in 2 years old with length 5 cm. Spawning continues from June up to July. Females lay eggs into gravel; spawn multiple times in a season. Forms schools. Feeds by benthic insects larvae, in particular larvae of chironomids.



HABITAT

Usually inhabits lakes, and mouth of rivers in summer.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.




DISTRIBUTION

Buir Lake and the Khalkh River (Pacific ocean basin)

МОРИН ТАВХАРАЛ

Hemibarbus labeo Pallas, 1776

Barbel steed



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие урт, бага зэрэг хавчигдуу. Нуруу боровтор бараан, биеийн хажуу бараавтар мөнгөлөг, хэвлий цайвар. Бие гүйцсэн загасны бие дээр хар толбо байхгүй. Биеийн хажуугийн хайрс хар эмжээрэн хөвөөтэй. Толгой биеийн өндрөөс урт. Толгойн урт биеийн уртын 25-28 хувийг эзэлнэ. Хошуу шөмбөгөр урт, доод амтай. Уруулууд махлаг, богиновтор хос сахалтай. Нурууны сэлүүрт хурц хатгууртай. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 5-6 гуурстай. Заламгайн эхний нуманд 15-20 өргөстэй. Хажуугийн шугам 48-52 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 15-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 58.5 см хүрнэ. 4-5 насандаа үржилд орно. Үржил 5-р сарын дундаас 6-р сард явагдах ба түрсээ элс, хайрга чулуун хурдас дээр хэсэг хэсгээр шахна. Түрс цэнхэр ногоон өнгөтэй, жижгэвтэр. Агуу 14,400-42,200 ширхэг түрс гаргана. Үржлийнхээ дараа 7-р сарын сүүлч 8-р сард эрчимтэй идээшилэх ба төрөл бүрийн усны ёроолын шавьжийн авгалдай, зарим тохиолдолд голдуу хавчаар хооллосон байдаг. Агнуурын ач холбогдолтой. Буйр нуурын агнуурын загасны 1.9%-ийг эзэлдэг.




АМЬДРАХ ОРЧИН

Нуурын төв хэсгээр амьдардаг. Зуны улиралд голын урсгалтай хэсгийн ёроолын хэсгээр зонхилж, өвөл нуурын гүнд өвөлжинө.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Хэрлэн, Халхын гол, Оршуун, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Body elongate, slightly compressed. Back brownish dark, side darkish silvery, below light. In adults absence dark spots on body. Side's scales dark edged. Head longer than body depth. Head length is 25-28% of body length. Snout much longer than postorbital head length, mouth inferior. Lips massive well developed, short barbells. In dorsal fin has strong spine. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, 5-6 branched soft rays. Gill rakers on the first arch are 15-20. Lateral line with 48-52 scales.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient. The Mongolian Law on Fauna commercial fishes of Buir Lake prohibits the catching from May 15th to August 1st.



BIOLOGY

Can reach up to 58.5 cm. Maturity in 4-5 years old. Spawning continues from mid May to June. Lays eggs on sand and gravel bottom; spawn multiple times in a season. Eggs smaller, blue green color. Females produce 14,400-42,200 eggs. After spawning in late June and August they eat benthic larvae of insects, some times crayfish. Commercial species, occupied 1.9% annual harvest of Buir lake.



HABITAT

Inhabits in center of lake. In summer occurs in rivers, winters spend in deep sites of lakes.




DISTRIBUTION

Kherlen, Khalkh, and Orshuun rivers and Buir Lake (Pacific ocean basin).

ТОЛБОТ МОРИН ЗАГАС, МОРИН ХАРВАЛ

Hemibarbus maculatus Bleeker, 1871

Spotted steed



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу жижиг бараан толбо бүхий бор шаргал өнгөтэй, биеийн хажуугаар том толботой. Хайрс тус бүрийн суурь хавиар бараан толботой. Хошуу богино, мохоо. Уруул нимгэн, хос сахалтай. Нурууны сэлүүр ба сүүлний сэлүүр бор шаргал өнгөтэй, бараан өнгийн толботой. Цээж, хэвлий, сүвийн сэлүүрүүд толбогүй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6 гуурстай. Заламгайн эхний нуманд 8-14 өргөстэй. Хажуугийн шугам 47-54 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 40 см, жин 1 кг хүрнэ. Гол төлөв 35 см, жин 790 гр байна. 5 насандаа үржилд орно. Атуу 14,400-42,200 ширхэг түрс гаргана. Зундаа гол төлөв жингэнүүр ялааны авгалдай болон бусад сээр нуруугүйтэн амьтад, зөөлөн биетэнээр, өвөлдөө хавч хэлбэртэн болон загасаар хооллосон байх нь тохиолдоно.




АМЬДРАХ ОРЧИН

Бие гүйцээгүй загас нь нуурын булан тохойн эрэг орчмын гүехэн хэсгээр, бие гүйцэхээрээ нуурт амьдарна. Хавар, зундаа нуураас голын урсгал бүхий хэсэг орчим бөөгнөрөн үржлийн сүрэг үүсгэнэ. Усны бохирдолд маш их тэсвэртэй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Хэрлэн, Халхын гол, Оршуун, Буйр нуурт тархан амьдарна.



 **DESCRIPTION**

Back brown yellow with small darkish spot, sides with large spots. Each scales base has darkish spot. Snout short, blunt. Lips thin, with barbells. Dorsal and caudal fins brown yellow, with darkish spots. Pectoral, pelvic and anal fins clear. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 6 branched soft rays. Gill rakers on the first arch are 8-14. Lateral line with 47-54 scales.

 **CONSERVATION STATUS**

Regionally Data Deficient.

 **BIOLOGY**

Can reach up to 40 cm length, and 1 kg weight. Usually 35 cm in length, and 790 g in weight. Maturity in 5 years old. Females produce 14,400-42,200 eggs. Feeds in summer mainly by chironomids, caddis fly and mayfly larvae, mollusks, and other macroinvertebrates; in winter consume crustaceans and fish.

 **HABITAT**

Inhabits streams and creeks with moderate flow and lakes. Juvenile inhabits bay of lakes in shallow water. In spring and summer moves from lake to river for spawning. It is highly tolerant to water pollution.

 **DISTRIBUTION**

Kherlen, Khalkh, and Orshuun rivers and Buir Lake (Pacific ocean basin).

АМАРЫН ХАВЧИГАС

Hemiculter leucisculus warpachovskii Nikolskii, 1903

Buir sharpbelly



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу бор-ногоон, биеийн хажуу ба хэвлий мөнгөлөг буюу хайрс маш нимгэн, мөнгөлөг цагаан өнгөтэй. Ам тэгш. Нүд том. Хэвлийн дагасан хатуу биш хянгатай. Хажуугийн шугам толгойн хэсгээс тэгш эхлэн үргэлжилж байгаад гэнэт өнцөг үүсгэх маягаар хэвлий рүү муруйн цүлхийж ороод дахин дээшлэн сүүлний хэсэгт тэгшрэн төгсдөг. Хажуугийн шугам 44-49 хайрстай. Нурууны сэлүүр хэвлийн сэлүүрийн суурийн дөнгөж араас эхлэнэ. Цээжний болон хэвлийн сэлүүрүүд урт, нурууны болон сүвийн сэлүүрүүд богино. Сүүлний сэлүүр хар эмжээртэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II-III, салаалсан 6-7(8), сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 11-16(17) гуурстай. Заламгайн өргөс богино, 25 хүрнэ. Залигуур араа 3 эгнээ 2.4.5-5.4.2 эсвэл 1.4.5-5.4.1 шүдтэй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 20 см-ээс хэтрэхгүй. Сүрэглэн амьдарна. 3 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Зун 6 сарын сүүлчээс 7 сар дуустал усны гадаргууд түрсээ хэсэгчилэн шахна. Хөвөгч амьтад, ногоон, хөх ногоон ба цахиур замаг, усны ёроолын шавьжаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Нуур, голын хоёуланд нь амьдарна. Намартаа нуураас үндсэн гол руугаа орж өвөлжинө.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуур, Халх голд тархан амьдарна.



DESCRIPTION

Back is brown-green, sides and belly silvery, scales very thin, silvery white. Mouth terminal. Eye large. The keel is not strong. Lateral line extends straight from head and a curved throat in to abdomen, and then folds again up and ends straight in the caudal base. Lateral line with 44-49 scales. Dorsal fin is started opposite of base of pelvic fins. Pectoral and pelvic fins long, and dorsal and anal fins short. Caudal fin dark edged. The dorsal fin (D) has II-III unbranched soft rays, and 6-7 (8) branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 11-16 (17) branched soft rays. Gill rakers short can reach 25. Pharyngeal teeth are in three rows, with 2.4.5-5.4.2 or 1.4.5-5.4.1 formula.



BIOLOGY

The body length is not exceeds 20 cm. Forms a schools. Mature in 3 years old. Spawning from late June to late July. Lays eggs in surface water; spawn multiple times in a season. Feed on zooplankton, green, blue and diatom algae, and aquatic benthic insects.



HABITAT

Inhabits both lakes and rivers. In fall from lake move to main course of the river for wintering.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable



DISTRIBUTION

Buir Lake, and down reaches of the Khalkh River (Pacific ocean basin)

ДУХ ДАВХАА

Hypophthalmichthys molitrix Valenciennes, 1844
Silver carp



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие цул, дугуй, өндөр, маш жижиг хайрсаар хучигдсан. Дух маш өргөн. Нуруу хар ногоовтор, хоёр хажуу, хэвэл мөнгөлөг цагаан, нурууны болон сүүлний сэлүүр улбар өнгөтэй. Толгой болон нүд том, ам жижиг, хагас дээд. Сахалгүй. Заламгайн өргөс туузархуу хэлбэртэй. Нүд толгойн дунд байрласан. Цээж, нуруу, болон сүвийн сэлүүрүүдийн анхдагч гуурс бүдүүн, бие гүйцсэн загасных хатгуур мэт. Сүвийн сэлүүр нурууны сэлүүрээс урт. Залигуур араа нэг эгнээ 4-4 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 11-14 гуурстай. Заламгайн өргөс маш урт, нарийн хоорондоо нийлж хөвсийн шүүлтүүр шиг болсон. Хажуугийн шугам гүйцэд, 109-125 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 100 см, жин 16 кг хүрнэ. 4-5 насандаа үржилд орно. Хоёр голын цутгал орчим, голын харьцангуй ширүүн урсгалтай хэсгийн хайрга чулуу, элсэрхэг хурдсанд усны температур 20°C дээш болоход (голдуу 18-26°C) түрсээ шахна. Үржил 4-р сарын сүүлчээс 6-р сард хүртэл үргэлжилнэ. Атуу 490,000-540,000 ширхэг түрсийг хэсэг хэсгээр шахна. Жараахай нь жижиг хавч хэлбэртэн, хөвөгч амьтдаар хооллож байгаад дараа нь хөвөгч замгаар хооллоно. Бие гүйцсэн давх хавартаа детрит буюу органик ялзмагаар, зундаа замгаар хооллоно. Агнуурын загас.




АМЬДРАХ ОРЧИН

Үржлийнхээ үед голоо өгсөнө. Үржлийнхээ дараа нуурт сүрэглэн идээшилнэ. Намар орой цутгал голуудаа өгсөн тэндээ өвөлжинө.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Оршуун гол, Буйр нуурт тэмдэглэгдсэн төдий.



DESCRIPTION

Heavy-bodied, round, high, covered very small scales. Forehead large. Keel on bellow extends from head to anus. Back black grayish, sides and abdomen silvery white. The dorsal and caudal fins reddish. Head and eyes are large, mouth small, subsuperior. Barbels absent. Slender gill rakers. Eyes located in the middle of the head. First ray of pectoral, dorsal, and anal fins thick, spine-like in adults. Anal fin longer than dorsal fin. Pharyngeal teeth are in one row, have formula 4-4. The dorsal fin (D) has II unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 11-14 branched soft rays. Gill rakers very long, the gill rakers are fused into a sponge-like filter. Lateral line complete, with 109-125 scales.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.

BIOLOGY

Can reach up to 100 cm length, and 16 kg weight. Mature in 4-5 years old. Spawning takes place in rivers at shallow rapids with gravel or sand bottom, in upper water layer or even at surface, during floods, when temperatures above 20°C (usually 18-26°C). Spawning continues from April to late June. Females produce 490,000-540,000 eggs; spawn multiple times in a season. Juveniles feed on zooplankton, adults in spring feeds on detritus, and consume only phytoplankton in summer. Commercial species.

HABITAT

During the spawning migrate to upper reaches of river. After spawning a large schools of silver carp migrate to lakes for feeding; in autumn, move to pools in main course of rivers for wintering.

DISTRIBUTION

Buir Lake. Possible in the Orshuun River (Pacific ocean basin).

ВЛАДИСЛАВ, ТАЧАНОВЫН ГҮРЦ

Ladislavia taczanowskii Dybowski, 1869

Taczanowski's gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн зүс бор буюу ногоовтор хүрэн. Нуруу ба биеийн хажуугийн хайрс бараан эмжээртэй, биеийн хажуугийнх нь бүслүүр мэт харагддаг. Цээж, хэвлий, сүвийн сэлүүрүүд дугуйвтар, нурууны сэлүүрийнх мохоовтор хэлбэрийн. Хошуу мохоо. Сахал мэдэгдэх төдий богино. Ам бараг тэгш. Дух хавтгай. Нүд нь толгойн дээд хэсэгт байрлана. Залигуур араа хоёр эгнээ 2.5-5.2 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6 гуурстай. Хажуугийн шугам 37-42 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутамг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 15 см, жин 12 гр хүрнэ. 3 насандаа биеийн урт 5 см хүрэхэд үржилд орно. Үржил 6 сараас 7 сар хүртэл үргэлжилнэ. Түрсээ голын хайрга чулуун хурдсанд хэсэг хэсгээр шахна. Үржлийн үед агуухын сүвийн болон хэвлийн сэлүүрийн цацраг улайж, толгой дээр цагаан эвэрлэг маягийн төвгөрүүд үүснэ. Усны ёроолын замаг, жижиг сээрнуруугүйтэн амьтдаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Үндсэн голд амьдрах ба гол төлөв уулархаг газрын горхиор байршдаг. Хол нүүдэл хийдэггүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Онон, Балж, Хурхын гол түүний цутгал голуудаар тархан амьдарна.



DESCRIPTION

Body brownish or grayish brown. Back and sides with darkish edged scales, lateral scales looks like stripe. Pectoral, pelvic, and anal fins rounded and dorsal fin blunt shaped. Snout blunt. Barbels very small and short. Mouth subterminal. Forehead plate. Eyes have high location on head. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-5.2. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 6 branched soft rays. Lateral line with 37-42 scales.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



BIOLOGY

Non game small fish. Maximum body length is 15 cm, weight 12 g. Mature in 3 years old when body length reach 5 cm. Spawning from June to July. Lay eggs on gravel, cobble bottom of rivers, spawn multiple times in a season. Spawning males anal and pelvic fins rays redness, and head become covered with white conical epitherial outgrowths. Feeds on aquatic benthic algae, and small invertebrates.



HABITAT

Inhabits main course of rivers, usually in streams of highlands. Not far migrated.



DISTRIBUTION

Onon, Balj, Khurkh rivers and its tributaries (Pacific ocean basin).

ШИВЭР СУГАС

Leuciscus leuciscus baicalensis Dybowski, 1874
Siberian dace



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу хөхөлбөр бор, хэвлий мөнгөлөг цайвар, Нуруу болон сүүлний сэлүүр бараавтар-бор, хэвлий болон сүвийн сэлүүр, цээжний сэлүүрүүд улаан өнгөтэй. Толгойн урт биеийн өндрөөс үл мэдэг бага. Хошуу богино, нурууны сэлүүр босоо өндөр, биеийн яг дунд хэсэгт байрлана. Ам жижигхэн, бараг тэгш. Дээд эрүүний урт толгойн гуравны нэгтэй тэнцэнэ. Залигуур араа хоёр эгнээ 2.5-5.2 эсвэл 2.5-4.2 шүдтэй. Заламгайн өргөс 8-11. Нурууны сэлүүр (D) салаалаагүй I-III, салаалсан 7-8(9), сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 8-10, цээжний сэлүүр (P) салаалаагүй I-II, салаалсан 13-15, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 7-8 гуурстай. Хажуугийн шугам 42-50 (52) хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын загас. Биеийн урт 22 см хүрнэ. 3-6 насандаа биеийн урт 11-14 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. Үржил 5 сарын сүүлчээс 6 сарын эхэн хүртэл үргэлжилж түрсээ голын урсгал ихтэй хэсгийн хайрга чулуун ёроолд шахна. Атуу 2,900-27,000 ширхэг түрс гаргана. Шивэр сугас усны ёроолын шавьжийн авгалдай тэр дундаа хаварч, өдөрчийн авгалдай, Хуурай газрын шавьж, салаа сахалт, сэлүүр хөлт хавч хэлбэртэн, замгаар хооллох ба мөн усны ургамлаар их хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Нуур, голын элс, чулуурхаг хурдастай, түргэн урсгалт, гүехэн хэсгээр зонхилон идээшилнэ. Үргэлж сүрэглэнэ. Мөс хайлсаны дараа голын дээд хэсэг рүү нүүдэллэн үржинэ. Үржлийнхээ дараа бие гүйцсэн загаснууд голын үндсэн гулдрил руу нүүдэллэн зуны турш идээшилнэ. Намартаа нуурын гүн хэсэг, голын цүнхээл рүү нүүдэллэн өвөлжинэ.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрөн түүний цутгал голууд, Орхон Туул, Булган гол, Өгий, Тэрхийн Цагаан нуурт тархан амьдарна. Дархадын хотгорын Доод Шишхэд, Доод Цагаан нуурт тэмдэглэгдсэн.



DESCRIPTION

Back bluish brown, bellow silvery light. Dorsal and caudal fins darkish brown; pelvic, anal, and pectoral fins reddish. Head length slightly smaller than body depth. Snout short. Dorsal fin high, and located in mid of body. Mouth small, subterminal. Upper jaw length equal 3/1 of head. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-5.2 or 2.5-4.2. Number of gill rakers - 8-11. The dorsal fin (D) has I-III unbranched soft rays, and 7-8 (9) branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 8-10 branched soft rays; the pectoral fins (P) have I-II unbranched soft rays, and 13-15 branched soft rays; the pelvic fins (V) have I unbranched soft rays, and 7-8 branched soft rays. Lateral line with 42-50 (52) scales.



CONSERVATION STATUS

Regionally Least Concern. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from April 1st to June 15th of the following calendar year.



BIOLOGY

Commercial species. Body length can reach 22 cm. Mature in 3-6 years old, when 11-14 cm long. Spawning since late May to early June. Lays eggs on gravel and stones in riffles of rivers. Females produce 2,900-27,000 eggs. Feeds on larvae of insect such as caddis flies, mayflies, and imago of terrestrial insects, cladocerans, copepods, algae and higher aquatic plants.



HABITAT

Inhabits shallow water of rivers and lakes with sand and gravel bottom. Always forms large schools. After melt migrates to upper reaches for spawning. After spawning, adults migrate to main course of the rivers and feeds during the summer. In autumn, moves to down to deep waters of lakes and pools of the rivers for wintering.



DISTRIBUTION

The Selenga River and its tributaries Orkhon, Tuul, Bulgan rivers; Ugii and Terkhiin Tsagaan lakes. Recorded for lakes and waters of Darkhad Depression: Dood Tsagaan Lake, and the Dood Shishkhed River (all belong to Arctic ocean basin).

ЗҮҮНГАРЫН СУГАС

Leuciscus dzungaricus Koch and Paepke, 1998
Dzhungarian dace



ЕРӨНХИЙ ШИНЖ

Зүүн гарын сугасны бие мөнгөлөг цайвар өнгөтэй. Хос болон хос бус сэлүүрүүд жигд цайвар. Ам тэгш. Биеийн их өндөр шивэр сугасныхаас их. Хошуу богино, нурууны сэлүүр босоо өндөр. Шивэр сугастай харьцуулахад заламгайн өргөс олон (14-18), нурууны нугалам цөөн (ихэвчлэн 42).



ТАРХАЛТ

Булган голд тархан амьдарна.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын загас. Мэдээлэл хомс.




АМЬДРАХ ОРЧИН

Голын элс, чулуурхаг хурдастай, түргэн урсгалт, гүехэн хэсгээр зонхилон идээшилнэ.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт устаж болзошгүй, В1аb(v) болон 2аb(v).



DESCRIPTION

Body silvery whitish. Paired fins and unpaired fins whitish. Dzhungarian dace has a terminal mouth. Maximum depth of body larger than Siberian dace. Snout shot, dorsal fin depth. Compared with the Siberian dace, it has a larger number of gill rakers (14-18), and less number of vertebrae (usually 42).

DISTRIBUTION

The Bulgan River (Arctic ocean basin)

BIOLOGY

Data Deficient.

HABITAT

Inhabits rivers with running shallow rapids with sand, and gravel bottoms.

CONSERVATION STATUS

Regionally Endangered, B1ab(v) and 2ab(v).

БУХ СУГАС

Leuciscus idus Linnaeus, 1758

Иде



ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн хэлбэр мөрөг загастай төстэй боловч ерөнхийдөө мөнгөлөг өнгөтэй, сэлүүрүүд улаан ягаан. Бие гүйцсэн том загасны өнгө шар-хүрэн болж хувирна. Ам тэгш. Бух сугасны дух өргөн, бие өндөр, толгой харьцангуй жижгэвтэр. Залигуур араа хоёр эгнээ буюу 3.5-5.3 цилиндр хэлбэрийн шүдтэй. Заламгайн өргөс богинохон 10-14 өргөстэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 8, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 9-10 гуурстай. Хажуугийн шугам 52-62 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт ховордож болзошгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын ач холбогдолтой. Биеийн урт 68-80 см, жин 6-8 кг хүрнэ. Гол төлөв 30-50 см, 1 кг жинтэй байна. 4 насандаа биеийн урт 25 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 4 сарын сүүлчээс эхэлж 5 сард усны температур 5-7°C хэм болоход түрсээ голын ширүүн урсгалтай хэсгийн хайрга, чулуу болон ургамал дээр шахна. Атуу 37,600-114,000 мянган ширхэг түрс гаргана. Түрсний голч 1.9-2.3 мм. Түрс нь чулуу болон ургамалд наалдана. Бие гүйцсэн усны ёроолын шавьж, тэдгээрийн авгалдай, зөөлөн биетэн, хорхой, замаг, усны дээд ургамлаар хооллоно. Өгий нуурын агнуурын загасны 1.7-19.2 хувийг эзэлж байсан.




АМЬДРАХ ОРЧИН

Томоохон гол, нуур цөөрөмд тархан амьдарна. Ихэвчлэн сүрэглэнэ. Нуурын ургамал бүхий хэсэгт, сүрэглэн амьдрах зохилдлоготой. Голд урсгал тогтуун, нарны илчинд амархан халдаг булан тохойд бүгэж амьдарна.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн Сэлэнгэ мөрний савын голууд, Орхон, Туул, Өгий нуурт тархана.



DESCRIPTION

The body has a typical cyprinid shape and generally silvery appearance, while the fins are a red pinkish. In older and bigger fish the body color can turn to yellow-bronze. Mouth terminal. Forehead wide, body high and head relatively smaller. Pharyngeal teeth are in two rows, have formula 3.5-5.3, teeth shape is cylindrical. Gill rakers short, their number - 10-14. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 8 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 9-10 branched soft rays. Lateral line with 52-62 scales.

CONSERVATION STATUS

Regionally Near Threatened. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from April 1st to June 15th of the following calendar year.

BIOLOGY

Commercial species. The ide reaches a maximum length of about 60-80 cm, and weight of about 6-8 kg. Usually 30-50 cm in length, and 1 kg in weight. They mature in 4 years old, about in 25 cm long. Spawning from late April to May when a water temperature 5-7°C. Lays eggs in riffles of rivers on gravel or vegetation. Females produce 37,600-114,000 eggs, with diameter 1.9-2.3 mm. Eggs sticking to stones or weeds. Feeds on larvae and adults of insects, mollusks, worms, algae and macrophytes. It is occupied 1.7-19.2% of annual harvest of Ugii lake.

HABITAT

It occurs in large rivers, ponds, and lakes. Typically forms schools. In lakes occurs in sites with vegetation, in rivers with moderate current, and in bays.

DISTRIBUTION

The Selenga River drainage: Orkhon, Tuul rivers and Ugii Lake (Arctic ocean basin).

АМАРЫН СУГАС

Leuciscus waleckii Dybowski, 1869

Amur ide



ЕРӨНХИЙ ШИНЖ

Амарын сугас нь улаан нүдэнтэй төстэй боловч хайрс нь жижиг, бие уртавтар. Нуруун тал бараавтар, биеийн хоёр хажуу мөнгөлөг цайвар, нурууны ба сүүлний сэлүүр бараан. Сүвийн, хэвлийн, цээжний сэлүүрүүд улбар шар өнгөтэй. Залигуур араа хоёр эгнээ буюу 3.5-5.3 цилиндр хэлбэрийн шүдтэй. Заламгайн өргөс 9-14. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7 (8), сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 9-11 (12) гуурстай. Хажуугийн шугам 47-56 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 15-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын загас. Биеийн урт 30 см, жин 500 гр хүрнэ. 3-4 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 5 сарын дундаас 7 сарын 10-д хүртэл үржинэ. Түрсээ ургамал, чулуун дээр шахна. Атуу 3,000-39,300 ширхэг түрс гаргана. Амарын сугас усны ёроолын шавьж болох хоовгон, өдөрч шавьжийн авгалдай, утаслаг замаг, хуурай газрын шавьж, усны дээд ургамлаар хооллоно. Буйр нуурын агнуурын загасны 3.0%-ийг эзэлдэг.




АМЬДРАХ ОРЧИН

Нуурын эрэг орчмын ургамал элбэгтэй хэсэг, голын намуун урсгалтай булан тохойд идээшилдэг. Хавар эрт усны гүнээс голын адаг болон ургамлын үлдэгдэл ихтэй нуурын эргийн гүехэн хэсэгт нүүдэллэн ирж үржинэ. Намар орой нуурын гүн рүү нүүдэллэдэг.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Балж, Адарга, Халх, Оршуун, Нөмрөг гол, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Amur ide is similar in appearance to roach, but with small scales and body elongate. Back darkish, sides silvery whitish, dorsal and caudal fins darkish. Anal, pectoral and pelvic fins yellowish. Pharyngeal teeth are cylindrical, in two rows, have formula 3.5-5.3. Gill rakers - 9-14. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 (8) branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 9-11 (12) branched soft rays. Lateral line with 47-56 scales.

CONSERVATION STATUS

Regionally Data Deficient. The Mongolian Law on Fauna commercial fishes of the Buir lake prohibits the catching from May 15th to August 1st.

BIOLOGY

Commercial species. Can reach up to 30 cm, and weight 500 g. They mature in 3-4 years old. Spawning from mid May to mid July. Lays eggs into vegetation and gravel. Females produce 3,000-39,300 eggs. Feeds on aquatic benthic insects larvae of caddis flies, may flies, algae, imago of terrestrial insects, and macrophytes. It is occupied about 3.0% of annual harvest of Buir lake.

HABITAT

It occurs near shore of lakes with high vegetation, in rivers with moderately current, and in bays. Early spring from deep water move to down reaches of rivers and littoral zone of lakes with high vegetation for spawning. In late autumn move to deep water of lakes.

DISTRIBUTION

Kherlen, Onon, Balj, Adarga, Khalkh, Orshuun, Numrug rivers, and Buir Lake (Pacific ocean basin).

БУЙРЫН МОНХОР ГҮРЦ

Microphysogobio tungtingensis Nichols, 1926 = *Rostrogobio amurensis*
Long-nosed gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие уртагтар, шаргал. Ам доод, хошуу урт. Уруул пэмбэгэр. Хоёр богино сахалтай. Биеийн хажуугаар үргэлжилсэн хар толботой. Сэлүүрүүд толбогүй, өнгөгүй. Хэвлий хайрсгүй. Сүүлний урт биеийн уртын 17.4-23.1%-тай тэнцүү. Заламгайн өргөс 37-39. Залигуур араа нэг эгнээ 5-5 эсвэл 5-4 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 5-6 гуурстай. Хажуугийн шугам 39-44 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бус нутагт мэдээлэл дутмаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 11.5 см-ээс хэтрэхгүй. 2 насандаа биеийн урт 4 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. 6 сарын дундаас 7 сарын дунд хүртэл усны температур 20°C болоход үржинэ. Түрсээ усны гадарга дээр хэсэгчилэн шахна. Түрсний диаметр 2.8-3.1 мм. Жарамгай 4 мм хүрэхэд усны ёроол руу доошилно. Жижиг хөвөгч амьтад, ёроолын шавьж, зарим үед замгаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Ёроолын амьдралын хэвшилтэй загас. Нуурт ховор тохиолдоно. Голын урсгал багагай хэсгийн элс, хайрга чулуун ёроолтой хэсгээр тархан амьдарна.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуур, Халх голын адаг орчмоор тархан амьдарна.



DESCRIPTION

Body elongate, yellowish. Mouth subterminal, snout long. Lip massive. Have 2 short barbels. Sides with black spots. Fins haven't spots, clear. Belly hasn't scales. Caudal fin length equal 17.4-23.1% of body length. Gill rakers - 37-39. Pharyngeal teeth are in on row, have formula 5-5 or 5-4. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II unbranched soft rays, and 5-6 branched soft rays. Lateral line with 39-44 scales.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



BIOLOGY

Non game species. Body length not exceeds 11.5 cm. Mature in 2 years old, when about in 4 cm long. Spawning from middle June to middle July, when water temperature around 20°C. Lays eggs in surface of water; spawn multiple times in a season. Eggs 2.8-3.1 mm in diameter. Fry when grow to length of 4 mm they drift to bottom. Feeds on zooplankton, benthic insect larvae, and sometimes on algae.



HABITAT

Bottom life style. In lakes occurs rare. Rivers with quiet waters with sand, gravel bottom.



DISTRIBUTION

Buir Lake, down reaches of the Khalkh River (Pacific ocean basin).

АЛТАЙН ДАВЖАА СУГАС - ГОЛЫН ХЭЛБЭР

Oreoleuciscus humilis Warpachowski, 1889

Altai's dwarf osman - Dwarf form



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу мөнгөлөг саарал, хажуу болон хэвлий мөнгөлөг цагаанаас шаравтар. Хайрс жижигхэн, бие биендээ гүн сууж ороогүй, бие хайрсаар бүрэн хучигдаагүй, ялангуяа хэвлийн хэсэг хайрсгүй. Өөхөн сэлүүр байхгүй. Ам тэгш, жижиг, дээд, доод эрүү тэнцүү. Залигуур араа нэг эгнээ, дэгээ мэт 6-5 эсвэл 5-5 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7-8, сүвийн сэлүүр (A) салаалаагүй (II ховор) III, салаалсан 7-8 гуурстай, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 14-17, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 7-8 гуурстай. Заламгайн өргөс богино, зүүн нумандаа 24-32 өргөстэй. Хажуугийн шугам 87-118 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт эмзэг, B2ab (ii,iii,iv,v). Монгол Улсын Амьтны тухай хуулинд Алтайн сугасыг 6 сарын 15-наас 8 сарын 31 хүртэл агнах, барихыг хориглосон байдаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Алтайн давжаа сугас нь гадаад төрх, пластик (тоологддог биш) морфологи шинж чанар, амьдрах орчны сонголт, амьдралын эргэлт буюу хөгжлийн мөчлөг болон идэш тэжээлээрээ эрс ялгаатай “голын” болон “нуурын” гэсэн морфо-экологийн хоёр хэлбэрийг үүсгэдэг. Эдгээр хэлбэр нь генетикийн ялгаа байхгүй. Голын давжаа сугасны биеийн урт 20 см хүрч 17 насална. Гол төлөв сүрэглэн амьдарна. Алтайн давжаа сугас нь 6-7 насандаа биеийн урт 7-8 см хүрэхэд бие гүйцэж үржилд орно. 6 сарын сүүлчээс 8 сарын эхэн хүртэл нуур, голын гүехэн хэсэгт үржинэ. Алтайн давжаа сугас нь түрсээ хэсэгчилэн шахна. Түрсний голч 1.2-1.3 мм. Түрс нь наалдамхай чанартай учир ургамал болон ёроолын хурдсанд бэхлэгдэнэ. Атуу 2,400-12,200 ширхэг түрс гаргана. Алтайн давжаа сугасны голын хэлбэр нь усны ёроолын шавьжийн авгалдай, хөвөгч амьтад болон замгаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Гол болон нуурт тархан амьдарна. Ихэвчлэн голын тогтуун урсгалтай хэсэг, эрэг доогуур, нуурын эрэг орчмын гүехэн хэсгээр амьдарна. “Хуурай” жилүүдэд зарим нуурууд хатаж ширгэхэд Алтайн давжаа сугас нь голыг хоргодох газраа болгон ашигладаг.



ТАРХАЛТ

Төв Азийн унаган зүйл загас. Орог, Таацын Цагаан, Бөөн Цагаан нуур, Онги, Түй, Байдраг, Таацын гол зэрэг Нууруудын хөндийн ай савд тархан амьдарна (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).



DESCRIPTION

Back silvery gray, side and abdomen silvery to yellowish. Scales small, not deeply set each other, body incomplete covered by scales, usually abdomen lack scales. Adipose fin absent. Mouth terminal, small, upper and lower jaws equal. Pharyngeal teeth like hook are in one row, have formula 6-5 or 5-5. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7-8 branched soft rays; the anal fin (A) has II (rare)-III unbranched soft rays, and 7-8 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft rays, and 14-17 branched soft rays; the pelvic (V) fins have II unbranched soft rays, and 7-8 branched soft rays. Gill rakers short, their number on left arch - 24-32. Lateral line with 87-118 scales.



CONSERVATION STATUS

Regionally Vulnerable, B2ab (ii,iii,iv,v). In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive of the Altai osmans from June 15th to August 31st of the following calendar year.



BIOLOGY

Altai's Dwarf osman produce two morpho-ecological forms: "dwarf form" and "lake form" which are discriminated on external, plastic (not meristic) morphological characters, habitat preferences, life history strategies and food diets. These form haven't essential genetical differences. Dwarf form's can reach 20 cm in length, and 17 years of age. Usually forms schools. Sexual maturity is attained in 6-7 years old, about in 7-8 cm long. Spawning continues from late June to early August, in shallow water of lakes and rivers. The dwarf form spawns a multiple times in a season. Eggs diameter - 1.2-1.3 mm. Eggs sticking to water weeds or bottom substrates. Females produce 2,400-12,200 eggs. Dwarf form feeds on insect larvae, zooplankton, and algae.



HABITAT

Inhabits rivers and lakes. Usually in sites of rivers with quiet waters, under shore, and in shallow water near shores of lakes. In some lakes which disappear during "dry period" dwarf form use rivers as refuge.



DISTRIBUTION

Endemic of Central Asia. Orog, Taatsiin Tsagaan, Buun Tsagaan lakes; Ongi, Tui, Baidrag and Taats rivers of the Lake Valley (Central Asian Internal Drainage basin).

АЛТАЙН ДАВЖАА СУГАС - НУУРЫН ХЭЛБЭР

Oreoleuciscus humilis Warpachowski, 1889

Altai's dwarf osman - Lake form



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуурын хэлбэрийг голын хэлбэртэй харьцуулахад толгой урт, ам том, доод эрүү дээд эрүүг бодвол бага зэрэг урт. Нуруу мөнгөлөг саарал, хажуу, хэвэл мөнгөлөг цагаанаас шаравтар. Толгойн урт биеийн уртын 24-28%-тай тэнцүү. Залигуур араа нэг эгнээ, 5-5 маш ховор 6-5 дэгээ мэт шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7-8, сүвийн сэлүүр (A) салаалаагүй (II ховор) III, салаалсан 7-8 гуурстай, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 14-17, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 7-8 гуурстай. Заламгайн өргөс богино, 24-32 өргөстэй. Хажуугийн шугам 87-118 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт эмзэг, B2ab (ii,iii,iv,v). Монгол Улсын Амьтны тухай хуулинд Алтайн сугасыг 6 сарын 15-наас 8 сарын 31 хүртэл агнах, барихыг хориглосон байдаг.



ТАРХАЛТ

Төв Азийн унаган зүйл. Нуурын хөндийн Орог, Бөөн Цагаан, Таацын Цагаан нуурт тархан амьдарна (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).




БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Нуурын хэлбэр нь зөвхөн нуурт амьдарна. Нуурын хөндийд усны түвшин хэлбэлзэх үзэгдэл үечилэн давтагддаг бөгөөд энэ нь “хуурай” болон “устай” жилээр ээлжлэн илэрдэг. Нуурын хөндийн зарим нуурууд “хуурай” жилүүдэд хатаж ширгэх бөгөөд энэ үед загасны бүх популяци үхэж хорогддог. Нуур усаар дүүрэхэд (“устай” жил эхлэх үед) *O. humilis*-ийн нуурын хэлбэр нь голоос шилжин ирсэн голын популяциар сэлбэгдэн шинээр үүсдэг. Нуур усаар сэлбэгдэхэд том биетэй голын хэлбэр нь өөрийн үр төлийг (каннибализм) идэн тэдний өсөлтийн явц эрчимтэй хурдасдаг. Нуурын хэлбэр нь биеийн урт 20 см хүрэхэд 5-6 насандаа бэлгэ боловсорч үржилд ордог. 6 сараас 8 сар дуустал нуурын эргийн гүехэн хэсэг, голын адаг хэсэгт үржинэ. Нуурын хэлбэр нь хэсэгчилэн түрсээ шахна. Түрсний голч 1.2-1.3 мм. Түрс нь наалдамхай чанартай учир ургамал болон ёроолын хурдсанд бэхлэгдэнэ. Нуурын хэлбэрийн төлжилт нь (түрс) 33,720-аас 105,300-ын хооронд хэлбэлзэнэ. Биеийн уртаас хамааран атуугийн түрсний тоо харилцан адилгүй байдаг. *O. humilis*-ийн нуурын хэлбэр нь 45 см хүрэх бөгөөд хөгжлийн мөчлөгийн эхний үед голын хэлбэртэй адилхан идэш тэжээлээр хооллоно. Нуурын хэлбэрийн ихэнх биеийн урт нь 18 см хүрэхэд загасаар хооллож эхэлнэ.



АМЬДРАХ ОРЧИН

Нуурын гадаргаас 3.5 м-ээс доош гүнтэй хэсэг ёроолоос дээш 2 м-т тархан амьдарна. Хавар нуурын эрэг орчмоор сүрэглэн идээшилнэ. Зундаа нуурын эргийн гүехэн хэсэг, голын адаг орчмоор сүрэглэнэ.



DESCRIPTION

Compared to the dwarf form the lake form has long head, large mouth, lower jaw slightly longer than upper jaw. Back silvery grayish, abdomen silvery white to yellowish. Head length equal 24-28% of body length. Pharyngeal teeth like hook are in one row; have formula 5-5 or very rare 6-5. The dorsal fin has III unbranched soft rays, and 7-8 branched soft rays; the anal fin (A) has II (rare)-III unbranched soft rays, and 7-8 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft rays, and 14-17 branched soft rays; the pelvic (V) fins have II unbranched soft rays, and 7-8 branched soft rays. Gill rakers short, their number - 24-32. Lateral line with 87-118 scales.



CONSERVATION STATUS

Regionally Vulnerable, B2ab (ii,iii,iv,v). In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive of the Altai osman from June 15th to August 31st of the following calendar year.



DISTRIBUTION

Endemic of Central Asia. Orog, Taatsiin Tsagaan, Buun Tsagaan lakes of the Lake Valley (Central Asian Internal Drainage basin).



BIOLOGY

The lake form occurs only in lakes. In Lake Wally periodically observed fluctuation in water supply expressed in alternation of “wet” and “dry” periods. Some lakes of Lake Wally are disappearing during the “dry” period and all populations of fish were died. After the restoration of the lake (in the beginning of the “wet” period) the lake populations of *O. humilis* are restored originating anew from the populations of dwarf form which came from the rivers. During the restoration of the lakes the biggest individuals of the dwarf form become cannibals and their rate of growth dramatically increases. Lake form becomes mature in 5-6 years old, about 20 cm length. Spawning continues from June to August, in shallow water of lakes and lower reaches of rivers. The lake form spawns a multiple times in a season. Eggs diameter - 1.2-1.3 mm. Eggs sticks to weeds or bottom substrates. The fecundity of the lake form varies from 33,720 to 105,300 eggs. Depending from body length of female produce different number of eggs. The individuals of the lake form of *O. humilis* reach 45 cm in length and during the early years of life use the same foods as the dwarf form. Most part of fish of the lake form after their length exceeds 18 cm become piscivorous.




HABITAT

Inhabits in water column of lakes 3.5 m of the surface water and 2 m above bottom. In spring observed near shore of the lakes in schools, in summer in shallow water of lakes, and lower reaches of the rivers.

ПОТАНИНЫ АЛТАЙН СУГАС - НОХОЙ СУГАС

Oreoleuciscus potanini Kessler, 1879

Potanin's Altai osman - Piscivorous form



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу хавиараа хар ногоон өнгөтэй, толгой, нуруу орчим хар нөсөөжилттэй, хэвлий мөнгөлөг ихэнхдээ шар ногоон туяатай. Хайрс жижигхэн, хэвлийн хэсэг хайрсгүй. Толгой урт. Ам хагас дээд. Доод эрүү дээд эрүүнээс урт. Өөхөн сэлүүргүй. Биений урттай харьцуулахад толгойн урт 28.5-33.5%, хошууны урт 6.6-8.6%, доод эрүүний урт 9.0-16.0%-ийг эзэлнэ. Заламгайн хавхлаг уртавтар, гурвалжин хэлбэртэй. Залигуур араа нэг эгнээ, гол төлөв 6-5, ховор 5-5 (5-6 маш ховор) шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 8(7); сүвийн сэлүүр (A) II (маш ховор) III салаалаагүй, 8 салаалсан; цээжний сэлүүр (P) салаалаагүй II, салаалсан 14-18; хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 8 гуурстай. Заламгайн өргөс 18-20, дунджаар 19.5. Хажуугийн шугам 100-106 хайрстай.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Их нууруудын хотгорын Хар, Хар-Ус, Дөргөн нуур, Чоно харайхын гол, Тээлийн гол, Завхан гол, Айраг, Хяргас нуур, Алтайн өндөрлөгийн Хотон, Хоргон, Даян нуур, Үүрэг нуур түүний цутгал голууд, Ачит нуур түүний цутгал голууд, Толбо нуур, Ховд голд тархан амьдарна.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Алтайн сугасыг 6 сарын 15-наас 8 сарын 31 хүртэл агнах, барихыг хориглосон байдаг.




БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Потанины Алтайн сугас загас нь морфо-экологийн гурван хэлбэр үүсгэдэг: “махан идэшт-нохой сугас”, “ургамал идэшт-шар сугас” болон “шөвгөр хоншоорт хэлбэр”. Эдгээр нь гадаад төрх, пластик (тоологддог биш) морфологи шинж чанар, амьдрах орчны сонголт, амьдралын эргэлт буюу хөгжлийн мөчлөг болон идэш тэжээлээрээ эрс ялгаатай. Бүх хэлбэрүүд хамт тархана. Бүх хэлбэрүүдийн дунд генетикийн онцгой ялгаа байхгүй. Нохой сугасны биений урт 100 см хүрэх ба 44 насална. Нохой сугас биений урт 20-24 см хүрэхэд 8-9 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 5 сарын эхээр нуурын мөс хайлахад үржиж эхлэх бөгөөд үржил 7 сар хүртэл үргэлжлэх ба усны температур 6-8°C-ээс дээшлэхэд голын адаг хэсэг, нууруудын хоорондох гол, нуурын эрэг орчмоор үржинэ. Атуу түрсээ субстрат харгалзахгүй: элс, чулуу, ургамалд шахна. Түрсээ хэсэгчилэн шахна. Нохой сугасны атуу 27,200-100,000 ширхэг алтлаг өнгөтэй түрс гаргана. Түрс нь үржлийн субстратад наалдана. Нохой сугас нь хара ногоон замаг (Charales), загас (гол төлөв өөрийн зүйлийн бодгаль), дээд ургамал, бие гүйцсэн шавьж тэдгээрийн авгалдайгаар хооллоно. Баруун Монголын нууруудаас баригдсан нохой сугасны идэш тэжээлийн бүрэлдэхүүнд 40-69%-ийг хара замаг, 25-30%-ийг загас, 6-8%-ийг дээд ургамал, хөвөгч амьтад үлдсэн хувийг усны ёроолын шавьж эзэлж байсан. Нохой сугас нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нуур, голын агнуурын үндсэн загас бөгөөд агнуурын загасны 40-80%-ийг эзэлдэг.



АМЬДРАХ ОРЧИН

Нохой сугас нь нуур (давстай нуурыг оролцуулан), голд тархан амьдарна. Нохой сугасны жараахай нь эхний 2 жилдээ нуурын эргийн усны ургамал бүхий хэсэгт сүрэлгэн идээшилнэ. Бие гүйцсэн нохой сугас нь нуурын бүх хэсгээр тархан идээшилнэ. Хавартаа нуурын эрэг орчим, цутгал голуудад тархан идээшилж байгаад нуурын гүн хэсэг рүү өвөлжихөөр нүүдэллэнэ. Нохой сугас нь алс хол нүүдэл хийдэггүй. Хар, Дөргөн нуурын системд (Их нууруудын хотгор) Потанины Алтайн сугас нь Хомын хоолойд үржинэ.



DESCRIPTION

Back black green, head and back with black pigment, abdomen silvery usually yellowish green color. Scales small, abdomen lack scales. Head long. Mouth subsuperior. Lower jaw longer than upper jaw. Adipose fin absent. The head length is 28.5-33.5%, snout length 6.6-8.6%, and lower jaw length 9.0-16.0% of body length. Operculum longer, has triangular shape. Pharyngeal teeth are in one row, have formula 6-5, or rare 5-5 (very rare 5-6). The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 8 (7) branched soft rays; the anal fin (A) has II (rare)-III unbranched soft rays, and 8 branched soft rays; the pectoral fins (P) have II unbranched soft rays, and 14-18 branched soft rays; the pelvic (V) fins have II unbranched soft rays, and 8 branched soft rays. Gill rakers number - 18-20, average 19.5. Lateral line with 100-106 scales.

DISTRIBUTION

Endemic of Central Asia. Khar, Khar-Uus, Durgen lakes, Teel and Zavkhan rivers, Airag and Khyargas lakes of the Great Lakes Holly; Khoton, Khorgon, Dayan, and Uureg lakes and its tributaries and Achit lake and its tributaries, Tolbo lake, Khovd river of the Altai mountain, and Bayan lake of the Khangai plateau (Central Asian Internal Drainage basin).

CONSERVATION STATUS

Regionally Least Concern. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive of the Altai osman from June 15th to August 31st of the following calendar year.

BIOLOGY

Potanin's Altai osman produce three morpho-ecological forms: "piscivorous form", "herbivorous form", and "sharp-snouted form" which are discriminated on external, plastic (not meristic) morphological characters, habitat preferences, life history strategies and food diets. All form occur sympatrically. There are not essential genetical differences between forms. Piscivorous form can reach up to 100 cm length and 44 years of age. They mature in 8-9 years old, when 20-24 cm long. Spawning starts early May, after ice melting, and continues to July, when temperature reaches 6-8°C, in down reaches of rivers, in streams between lakes and in off-shore of lakes. Females lay eggs on any kind of substratum: sand, stone, and vegetation. Spawning a multiple times in a season. Females produce 27,200-100,000 goldish colored eggs. Eggs sticking to spawning substratum. Piscivorous form feeds on chara green algae (Charales), fish (mainly individuals of own species), macrophytes, insects and their larvae. In lakes of the Western Mongolia, intestine of piscivorous form contain following mass ratio: 40-69% chara, 25-30% fish, and 6-8% macrophytes, zooplankton, and benthic insects. Piscivorous form is main commercial fish of the water bodies of Central Asian Internal Drainage basin, and has about 40-80% of annual catches.

HABITAT

Inhabits in lakes (including lakes with brackish water), and in rivers. Fry of piscivorous form first 2 years of life forms schools and inhabits littoral zone of lakes with dense aquatic vegetation. Adults occur in all parts of lakes. In spring inhabit near shore of lakes and its tributaries and in winter move to deep sites of lakes. Piscivorous form hasn't long migrations. In Khar and Durgen lakes systems (Grate Lakes Hollow) they are spawning in Khomiin kholooi stream.

ПОТАНИНЫ АЛТАЙН СУГАС - ШАР СУГАС

Oreoleuciscus potanini Kessler, 1879

Potanin's Altai Osman - Herbivorous form



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу хавиараа бүдэг ногоон эсвэл хар саарал өнгөтэй, биеийн хажуу хэсэг мөнгөлөг саарал, шаравтар, хэвлий цагаанаас шаргал эсвэл шар өнгөтэй. Бие дээрх нөсөөжилт бага. Хайрс жижигхэн, хэвлийн хэсэг хайрсгүй. Ам тэгш, доод эрүү дээд эрүүтэйгээ тэнцүү. Уруул махлаг. Өөхөн сэлүүргүй. Толгойн урт биеийн уртын 23.0-32.0%-ийг эзэлнэ. Заламгайн хавхлаг мохоо хэлбэртэй. Залигуур араа нэг эгнээ, гол төлөв 6-5, ховор 5-5 (5-6 маш ховор) шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 8 (7 маш ховор), сүвийн сэлүүр (A) салаалаагүй II (ховор)- III, салаалсан 8, цээжний сэлүүр (P) салаалаагүй II, салаалсан 14-18, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 8 гуурстай. Зүүн талын эхний нуманд заламгайн өргөс 16-32, дунджаар 21.1. Хажуугийн шугам 80-120 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өргөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Алтайн сугасыг 6 сарын 15-наас 8 сарын 31 хүртэл агнах, барихыг хориглосон байдаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Шар сугасны биеийн урт 60 см хүрнэ. Шар сугас 7-8 насандаа 17-19 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. Үржлийн хугацаа нохой сугасныхаас урт: 5 сарын эхээс 8 сар хүртэл үргэлжилнэ. 7 сард магадгүй жижиг бодгалиуд үржилд нэгдэнэ. Нохой сугасны агуутай адил ямар ч хамаагүй субстратад түрсээ шахна: элс, чулуу, усны ургамалд. Түрсээ хэсэгчилэн шахна. Потанины Алтайн сугасны гурван хэлбэрийн үржлийн хугацаа болон үржлийн талбай их хэмжээгээр давхцдаг. Шар сугасны түрс наалдамхай, бас алтлаг өнгөтэй. Агуу 5,200-52,600 ширхэг түрс гаргана. Шар сугас хара замаг, дээд ургамал, шавьж түүний авгалдай, мөн загасаар (маш бага хэмжээгээр) хооллоно. Баруун Монголын нууруудаас баригдсан шар сугасны идэш тэжээлийн бүрэлдэхүүнд: 55-80%-ийг хара замаг, 5-6%-ийг дээд ургамал, 6-15%-ийг ёроолын сээрнууруугүйтэн болон хөвөгч амьтад, 2-10%-ийг загас эзэлж байсан. Шар сугас нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нуур, голын агнуурын үндсэн загас бөгөөд зарим нууруудын агнуурын загасны 30-50%-ийг шар сугас эзэлдэг.




АМЬДРАХ ОРЧИН

Потанины Алтайн нохой сугастай адил нуур (давстай нуурыг оруулан) голд тархан амьдарна. Шар сугас нь алс хол нүүдэл хийдэггүй, хамгийн холдоо 5-7 км шилжинэ. Хар, Дөргөн нуурын системд (Их нууруудын хотгор) шар сугас Хомын хоолойд үржинэ.



ТАРХАЛТ

Төв Азийн унаган зүйл. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Их нууруудын хотгорын Хар, Хар-Ус, Дөргөн нуур, Чоно харайхын гол, Тээлийн гол, Завхан гол, Айраг, Хяргас нуур, Алтайн өндөрлөгийн Хотон, Хоргон, Даян нуур, Үүрэг нуур түүний цутгал голууд, Ачит нуур түүний цутгал голууд, Толбо нуур, Ховд гол, Хангайн тэгш өндөрлөгийн Баян нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Back darkly green or black grayish, sides silvery grayish or yellowish, abdomen from white to yellowish or yellow. In the body few pigment. Scales small, abdomen lack scales. Mouth terminal, lower and upper jaws equal. Lip massive. Adipose fin absent. Head length 23.0-32.0% of body length. Operculum is blunt shape. Pharyngeal teeth are in one row, have formula 6-5, or rarely 5-5 (very rare 5-6). The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 8 (7) branched soft rays; the anal fin(A) has II (rare) - III unbranched soft rays, and 8 branched soft rays; the pectoral fins (P) have II unbranched soft rays, and 14-18 branched soft rays; the pelvic (V) fins have II unbranched soft rays, and 8 branched soft rays. Number of gill rakers - 16-32, average 21.1. Lateral line with 80-120 scales.

CONSERVATION STATUS

Regionally Least Concern. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive of the Potanin's Altai osman from June 15th to August 31st of the following calendar year.

BIOLOGY

Herbivorous form can reach up to 60 cm length. This form matures in 7-8 years old, about in 17-19 cm long. Spawning period longer than for piscivorous form: starts early May and continues up to August. In July, mainly small individuals participate in spawning. As females of piscivorous form lay eggs on any kind of substratum: sand, stone, and vegetation and. spawning takes place a multiple times in a season. Time and places of spawning of all three forms of Potanin's Altai osman overlap to a large extent. Eggs of females of herbivorous form are sticky and goldish too. Females produce 5.200-52.600 eggs. Herbivorous form feeds on chara algae, macrophyts, insects and its larvae, and fish (in small number). In lakes of the Western Mongolia, intestine contents of herbivorous form contain following mass ratio: 55-80% chara algae, 5-6% macrophytes, and 6-15% benthic invertebrates, and zooplankton, and 2-10% fish. Herbivorous form is one of the main commercial fish of the water bodies of Central Asian Internal Drainage basin, and has about 30-50% of annual catches of some lakes.

HABITAT

As piscivorous form of Potanin's Altai osman inhabits lakes (including lakes with brackish water), and in rivers. The herbivorous form hasn't long migrations; maximum movement is 5-7 km. In Khar and Durgen lakes systems (Grate Lakes Hollow) they are spawning in Khomiin khooloi stream.

DISTRIBUTION

Endemic of Central Asia. Khar, Khar-Us, Durgen lakes, Teel and Zavkhan rivers, Airag and Khyargas lakes of the Great Lakes Holly; Khoton, Khorgon, Dayan, and Uureg lakes and its tributaries and Achit lake and its tributaries, Tolbo lake, Khovd river of the Altai mountain, and Bayan lake of the Khangai plateau (Central Asian Internal Drainage basin).

ПОТАНИНЫ АЛТАЙН СУГАС - ШӨВГӨР ХОНШООРТ

Oreoleuciscus potanini Kessler, 1879

Potanin's Altai Osman - Sharp-snouted form



ЕРӨНХИЙ ШИНЖ

Шөвгөр хоншоорт сугас нь шар сугастай төстэй. Ялгагдах гол онцлог нь толгойн хэлбэр болон нурууны сэлүүрийн хэмжээгээрээ ялгаатай. Шөвгөр хоншоорт сугасны хошуу урт шөвийсөн, хошуу биеийн уртын 6.0-8.2%-ийг, нурууны сэлүүрийн (D) өндөр 25.0-31.0 (дунджаар 28.0%), сүвийн сэлүүрийн (A) өндөр 14.5-20.0 (дунджаар 17.1%) эзэлнэ. Нуруу хавиараа шаравтар, хэвлий мөнгөлөг ихэнхдээ мөнгөлөг цагаан туяатай, бие нөсөөжөөгүй. Нурууны болон сүвийн сэлүүрийн урт нохой болон шар сугасыг бодвол харьцангуй өндөр. Заламгайн хавхлаг жижиг. Өөхөн сэлүүргүй. Хайрс жижигхэн. Залигуур араа нэг эгнээ 6-5 эсвэл 5-5 (маш ховор 5-6) шүдтэй. Нохой болон шар сугасыг бодвол заламгайн өргөс харьцангуй их: 18-36 (дунджаар 27.6).



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт эмзэг, Vlab(v). Монгол Улсын Амьтны тухай хуулинд зааснаар Алтайн сугасыг 6 сарын 15-наас 8 сарын 31 хүртэл агнах, барихыг хориглосон байдаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Шөвгөр хоншоорт сугасны биеийн урт 30 см хүрнэ. Энэ хэлбэр 4-5 насандаа, биеийн урт 11-12 см болоход бэлгэ боловсорч үржилд орно. Үржлийн хугацаа болон талбай шар сугасныхтай давхцана. Шөвгөр хоншоорт сугас нь гол төлөв хөвөгч амьтдаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Потанины Алтайн сугасны шөвгөр хоншоорт хэлбэр нь өдөртөө нуурын гүн хэсэгт шөнөдөө эргийн бүсийн ургамал шигүү ургасан хэсэгт тархан амьдарна. Гол төлөв шар сугасны сүрэгтэй хамт идээшилнэ.



ТАРХАЛТ

Төв Азийн унаган зүйл. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Их нууруудын хотгорын Хар нуур, Ногоон нуур түүнийг холбосон Хомын хоолойд тэмдэглэгдсэн.



DESCRIPTION

Sharp-snouted form is similar in appearance to herbivorous form, distinguished by shape of head and size of dorsal fin. Sharp snouted, length of snout is 6.0-8.2%, height of dorsal fin (D) is 25.0-31.0 (average 28.0%), and height of anal fin (A) is 14.5-20.0 (average 17.1%) of body length. Back yellowish, abdomen silvery, usually silvery white, body without pigment. Dorsal and anal fins are much long and high than in piscivorous and herbivorous forms. Scales small, abdomen without scales. Operculum is small. Adipose fin absent. Scales smaller. Pharyngeal teeth are in one row, have formula 6-5, or rarely 5-5 (very rare 5-6). Number of gill rakers more than in piscivorous and herbivorous forms: 18-36 (average 27.6).



CONSERVATION STATUS

Regionally Vulnerable, B1ab(v). Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive of the Altai osman from June 15th to August 31st of the following calendar year.



BIOLOGY

Sharp-snouted form can reach up to 30 cm. This form matures in 4-5 years old, when 11-12 cm long. Spawning time and places the same as for herbivorous form. Sharp-snouted form mainly feeds on plankton.



HABITAT

Sharp-snouted form in day time stays in water column of lakes, and in night near shore with dense aquatic vegetation. Often individuals of this form feeds in a school of herbivorous form.



DISTRIBUTION

Endemic of Central Asia. Where found in Khar, and Nagoon lakes and Khomiin khooloi stream of the Great Lakes Valley (Central Asian Internal Drainage basin).

СЭЛЭНГИЙН АЛТАЙН СУГАС

Oreoleuciscus sp.

Selenga's Altai Osman



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу бараавтар саарал, хажуу болон хэвлий мөнгөлөг цагаанаас шаргал. Хайрс жижиг, биед гүн сууж өгөөгүй. Хэвлий хайрсгүй. Ам тэгш, жижиг, дээд болон доод эрүү тэнцүү. Заламгайн хавхлаг жижиг. Залигуур араа нэг эгнээ 6-5 эсвэл 5-5 шүдтэй. Заламгайн өргөс урт, нягт, 25-30 өргөстэй. Нурууны болон сүвийн сэлүүрүүдийн дээд хэсэг бөөрөнхий. Сүүлний сэлүүрийн суурийн орчим хар толботой.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл хомс.




БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 45-48 см хүрнэ. Сангийн Далай нуурт биеийн урт 25-30 см, 15-16 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 5 сарын эхээс 8 сар хүртэл үргэлжилнэ. Атуу ямар ч хамаагүй субстрадад түрсээ шахна. Түрсээ хэсэгчилэн шахна.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Увс нуур түүний цутгал Нарийн, Тэсийн голд, Хойд мөсөн далайн ай савын Сангийн Далай нуур, Хүйтэний гол, Тарна, Шилүүт болон Хар Бухын голд тархан амьдарна.



DESCRIPTION

Back grayish gray, side and abdomen silvery whitish to yellowish. Scales small, not deeply set each other. Abdomen without scales. Mouth terminal, small, upper and lower jaws equal. Operculum is small. Pharyngeal teeth are in one row, have formula 6-5 and 5-5. Gill rakers long, crowded, its number -25-30. Dorsal and anal fin rounded above. A dark spot at the base of the caudal fin.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



BIOLOGY

Can reach up to 45-48 cm. In Sangiin Dalai Lake become mature when body length reaches 25-30 cm, in 15-16 years old. Spawning continues early May to August. Females lay eggs in any substrates. Spawning takes place multiple times in a season.



DISTRIBUTION

Uvs Lake and its tributaries Nariin, and Tes rivers of the Central Asian Internal Drainage basin. Sangiin Dalai Lake, Khuiten, Tarna, Shiluut and Khar Bukh rivers of the Arctic ocean basin.

НУУРЫН ВАРЛАН

Phoxinus phoxinus Pallas, 1814

Lake minnow



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие алтлаг өнгөтэй, нуруу ногоовтор хар, хэвлий цайвар. Бие жижиг хар толботой. Нуруу, хэвлий болон сүвийн сэлүүрүүд шаравтар заримдаа улаавтар. Ам жижиг, тэгш, дээд эрүү духны өргөнөөс богино. Ердийн варлантай харьцуулахад хайрс том, нарийн, хэвлий болон хоолойн хайрс жижиг. Сэлүүрүүд богино, нуруу, сүв болон хэвлийн сэлүүрүүд дугуйвтар. Залигуур араа хоёр эгнээ 2.5-4.2 шүдтэй. Заламгайн өргөс 7-11. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7 (8), сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6-7 (8) гуурстай. Хажуугийн шугам бүрэн бус.



ТАРХАЛТ

Сэлэнгэ мөрний сав газарт: Эг, Үүр, Туул, Орхон, Сэлбэ гол; Өгий болон Хөвсгөл нуур (Хойд мөсөн далайн ай сав); Буйр нуур, Хэрлэн, Онон, Улз, Халх голд тархана (Номхон далайн ай сав).



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 8.4-10 см хүрнэ. Нуурын варлан нь 2 насандаа бэлгэ боловсорно. 5 сараас 6 сар хүртэл нуурын эрэг, голын тогтуун урсгалтай хэсэгт үржинэ. Атуу 900-1,400 ширхэг түрсийг ургамалд шахна. Үржлийнхээ үед түрсээ хэсэгчилэн шахна. Түрс наалдамхай. Үржлийнхээ үед атуух хар өнгөтэй болох бөгөөд хоншоор болон сэлүүрүүдийн суурийн уг орчим улаавтар өнгөтэй болно. Гэхдээ ердийн варланг бодоход өнгө нь тод биш атуухын толгой дээр шовгор эпителиал товгор үүсдэггүй. Ялмаг, замаг, хөвөгч амьтад болон шавьжийн авгалдайгаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Нуурын гүнд ургамал ихтэй, элсэрхэг, шаварлаг ёроол бүхий хэсэгт сүрэлгэн амьдарна. Мөн голын элсэрхэг ёроол бүхий тогтуун урсгалтай хэсэгт тархан амьдарна. Зун ургамал ихтэй хэсэгт, өвөл элс, шаварлаг ёроолтой хэсэгт тархана.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй.



DESCRIPTION

Body color goldish, back is greenish dark, abdomen is light. Small dark spots on the body sides. Dorsal, pelvic and anal fins yellowish, sometimes reddish. Mouth small, terminal, upper jaw shorter than wide of frontal. Scales larger and narrow than in common minnow, abdomen and neck scales smaller. The fins short, dorsal, anal and pelvic fins with rounded tips. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-4.2. Number of gill rakers - 7-11. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 (8) branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 6-7 (8) branched soft rays. Lateral line incomplete.



DISTRIBUTION

The Selenga River and its tributaries: Eg, Uur, Tuul, Orkhon, Selbe rivers; Ugii and Khuvsugul Lake (Arctic ocean basin); Buir lake, Kherlen, Onon, Ulz and Khalkh rivers (Pacific ocean basin).



BIOLOGY

Non game species. Small fish, can reach up to 8.4-10 cm length. Lake minnow matures in 2 years old. Spawning from May to June near shore of the lakes, and in rivers with slow current. Females lay eggs on vegetation. Spawning a multiple times in a season. Females produce 900-1,400 eggs. Eggs sticky. Breeding males dark colored, and around the snout and base of the fins are reddish. But color is not bright than common minnow and males without conical epithelial outgrowths on the head. Feeds on detritus, algae, zooplankton, and larvae of insects.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



HABITAT

Habits in deep of lakes with vegetation with sand or mud bottom. Forms schools. Also occurs in rivers with quiet waters with sand bottom. In summer prefer habitats with vegetation, in winter sites with sand and silt bottoms.

ЕРДИЙН ВАРЛАН

Phoxinus phoxinus Linnaeus, 1758

Eurasian minnow



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие урт, ээрүүл хэлбэртэй. Биеийн хажуугаар 10-15 хөндлөн эгнээ үүсгэсэн том бараан зурвастай. Хайрс жижигхэн, хэвлийд хайрсгүй. Ам жижиг, бага зэрэг тэгш. Нүд дээр байрласан. Дух хавтгай. Нуруу, сүв, цээжний болон хэвлийн сэлүүрүүд урт, дугуйвтар. Залигуур араа хоёр эгнээ 2.5-4.2 (ховор 2.4-4.2) шүдтэй. Заламгайн өргөс 8-11. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7 (8), сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6-7, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 13-15, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 6-7 гуурстай. Хажуугийн шугам бүрэн бус.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Ердийн варлангийн биеийн урт 8-9 заримдаа 12.5 см хүрнэ. 2 насандаа биеийн урт 5 см болоход бэлгэ боловсорно. 4 сараас 7 сар хүртэл голын элс, хайрган ёроолтой хэсэгт үржинэ. Түрсээ хэсэгчилэн шахна. Атуу 700-3,000 ширхэг түрс гаргана. Түрсний голч 1.4-1.6 мм. Түрс наалдамхай чанартай. Үржлийн үед атуухын сэлүүрүүд шаравтар, заримдаа улаавтар ялангуяа биеийн хажуугийн хөндлөн эгнээ толбо улам тод болно. Хэвлий болон заламгайн хавхлагны зах хар, сүвийн сэлүүрийн суурийн уг тод ягаан эсвэл улаан өнгөтэй болно. Толгой хурц шовх төвгөрүүдээр хучигдана. Хөвөгч амьтад, ёроолын шавьжийн авгалдай болон замгаар хооллоно. Мөн агнуурын ач холбогдолтой загасны түрсийг идэж сүйтгэнэ. Ердийн варлан нь тул загасны үндсэн тэжээл болдог.




АМЬДРАХ ОРЧИН

Нуур, голын түргэн урсгалтай хэсгээр тархан амьдарна. Зуны улиралд голын эргийн гүехэн хэсгээр маш өтгөн сүрэг үүсгэн бэлчээрлэдэг.



ТАРХАЛТ

Ердийн варлан хамгийн өргөн тархалттай загас. Дархадын хотгорын нуурууд, Шишгэдийн голд, Сэлэнгийн сав газарт: Дэлгэрмөрөн, Идэр, Чулуут, Хануй, Орхон, Ерөө, Хараа, Цөх, Хүдэр, Туул, мөн Булган голд, Хөвсгөл, Тэрхийн цагаан, Өгий нуур зэрэг Хойд мөсөн далайн ай савд, Онон, Хэрлэн, Халх, Оршуун гол, Буйр нуур зэрэг Номхон далайн ай савын гол мөрөн, нуурт тархана.



DESCRIPTION

Body elongate, spindle-shaped. Body sides have 10-15 large darkish transversal bands. Small scales, abdomen without scales. Mouth small, slightly subterminal. Eyes set upper. Forehead flat. Dorsal, anal, pectoral and pelvic fins long and rounded. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-4.2 (rare 2.4-4.2). Number of gill rakers - 8-11. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 (8) branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 6-7 branched soft rays; pectoral fins (P) have I unbranched soft rays, and 13-15 branched soft rays; pelvic fins (V) have II unbranched soft rays, and 6-7 branched soft rays. Lateral line incomplete.

CONSERVATION STATUS

Regionally Least Concern

BIOLOGY

Non game species. The average size of the Eurasian minnow is around 8-9 cm, sometimes can reach up to 12.5 cm. Eurasian minnow mature in 2 years old, about in 5 cm long. Spawning from April to July in rivers with sand, gravel bottoms. Spawns multiple times in a season. Females produce 700-3,000 eggs, diameter in 1.4-1.6 mm. Eggs sticky. Fins of breeding males are yellowish, sometimes reddish. Darkish bands on body sides become more transparent. Abdomen, edge of operculum, back, and base of anal fin became bright pink and red. Head become covered with conical epithelial outgrowths. The Eurasian minnow feeds on zooplankton, larvae of insects and algae, and fish eggs of commercial species. Eurasian minnow is main food of taimen.

HABITAT

Inhabits lakes and rivers on sites with fast current. In summer minnow creates a dense schools in shallow water near shore of the rivers.

DISTRIBUTION

Eurasian minnow is wide distributed. The Shishkhed River and lakes of Darkhad Depression; the Selenga River basin: Delgermuren, Ider, Chuluut, Khanui, Orkhon, Eruu, Kharaa, Tsekh, Khuder, Tuul, Bulgan rivers and Khuvs gul, Terkhiin Tsagaan, and Ugii lakes of the Arctic ocean basin; and Onon Kherlen, Khalkh, Orshuun rivers, Buir Lake of the Pacific ocean basin.

ЧЕКАНОВЫН ВАРЛАН

Rhynchocypris czekanowskii Dybowski, 1869
Czekanowski's minnow



ЕРӨНХИЙ ШИНЖ

Чекановын варлан нь нуурын варлантай төсөөтэй боловч биеийн хэмжээ, өнгө зүсээрээ ялгаатай. Бие жижиг тод бараан толбоор бүрхэгдсэн, үл мэдэгдэм тууш бараан судалтай, Нуруу боровтор хар, хажуу тал алтлаг бор, хэвлий цайвар. Дух бага зэрэг хүнхэр. Нүдний голч нүд хоорондын зайн 72-77%-тай тэнцүү. Толгойн урт биеийн өндрөөс их. Ам жижиг, бага зэрэг тэгш. Хайрс жижигхэн. Нурууны сэлүүр цээжний сэлүүрийн эцсийн гуурсын харалдаа шугамаас эхэлдэг. Нурууны ба сүвийн сэлүүр богинохон, дугуйвтар. Сүүлний сэлүүрийн бариул богино өндөр. Залигуур араа хоёр эгнээ 2.5-4.2 (ховор 2.5-5.2) шүдтэй. Заламгайн өргөс 6-8. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6 (7), цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 12-13, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй II, салаалсан 6 (7) гуурстай. Хажуугийн шугам бүрэн бус, 82-90 хайрстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 10 см хүрнэ. Чекановын варлан 2 насандаа бэлгэ боловсордог. 6-р сарын дундуур үржинэ. Атуу хайрга чулуунд түрсээ шахна. Атуу 600-1,000 ширхэг түрс гаргана. Түрс наалдамхай чанартай. Үржлийн үед атуухын толгой дээгүүр төвгөр үүсэхгүй. Замаг, хөвөгч амьтад, ёроолын шавьжийн авгалдайгаар хооллоно. Чекановын варлан нь агнуурын загасны үндсэн тэжээл болдог.



АМЬДРАХ ОРЧИН

Голын урсгал ихтэй хэсгээр тархан амьдарна. Сэрүүн, өндөрлөг газрын голуудаар тархана. Урсгалгүй цөөрөм, тогтоол усанд ховор тохиолдоно.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Балж, Улз, Халх гол, Буйр нуурт тархана.



DESCRIPTION

Czekanowski's minnow is similar in appearance to lake minnow, distinguished by body length and color. Body covered with bright little dark spots and dark presence of longitudinal stripes. Back brownish dark, body sides golden brown, abdomen light. Forehead slightly convex. Eye diameter equal to 72-77% of the distance between the eyes. Head length longer than body depth. Mouth small, slightly subterminal. Scales small. Dorsal fin initiated slightly behind the vertical from the posterior end of the ventral fins bases. Dorsal and anal fins short, rounded. Caudal peduncle short and high. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-4.2 (rarely 2.5-5.2). Gill rakers number 6-8. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 6 (7) branched soft rays; pectoral fins (P) have I unbranched soft rays, and 12-13 branched soft rays; pelvic fins (V) have II unbranched soft rays, and 6 (7) branched soft rays. Lateral line incomplete, with 82-90 scales.

BIOLOGY

Non game species. Small fish. Can reach up to 10 cm length. Czekanowski's minnow are mature in 2 years old. Spawning in mid June. Females lay eggs on gravel and stone. Females produce 600-1,000 eggs. Eggs sticky. Breeding males without conical epithelial outgrowths on the head. Feeds on algae, zooplankton, and insect larvae. Czekanowski's minnow is one of the main foods of commercial species.

HABITAT

Inhabits rivers with fast flowing current. Occurs in cool and high land rivers. Rare in ponds and still waters.

CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.

DISTRIBUTION

Kherlen, Onon, Balj, Ulz, Khalkh rivers, and Buir Lake of the Pacific ocean basin.

ЛАГОВЫН ВАРЛАН

Rhynchocypris lagowskii Pallas, 1814

Lagowski's minnow



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу шаравтар-бор, хэвлий ба биеийн хажуу мөнгөлөг шар. Нуруу, биеийн хажуугаар жижигхэн бараан толботой. Биеийн хажуугаар дагууд нь тууш бараан бүслүүртэй. Ам том, хагас доод. Том нүдтэй. Биеийн өндөр биеийн уртын 18-22%-тай тэнцүү. Нурууны сэлүүрийн урт, сүв болон хэвлийн сэлүүрийн суурийн хоорондын зайнаас урт. Хэвлий нягт хайрсаар бүрхэгдсэн. Залигуур араа 2 эгнээ 2.5-4.2 (ховор 2.5-5.2) шүдтэй. Заламгайн өргөс 8-10. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II, салаалсан 6-8, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 7 гуурстай. Хажуугийн шугам бүрэн, 62-89 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Бусад зүйлийн варлангаас биеэр том, биеийн урт 17-20 см хүрнэ. Лаговын варлан нь 3 насандаа биеийн урт 6-7 см болоход бэлгэ боловсорно. 6-7 сард усны хэм 19.9°C болоход үржинэ. Атуу түргэн урсгалтай голын хайрга, чулуун хэсэгт түрсээ хэсэгчилэн шагна. Атуу 700-1,700 ширхэг түрс гаргах ба түрсний голч 1.6-2.0 мм. Усны ургамал, хөвөгч амьтад, ёроолын шавьжийн авгалдай болон бие гүйцсэн шавьж, мөн агнуурын ач холбогдолтой загасны түрсээр хооллоно. Лаговскийн варлан нь махчин загасны үндсэн тэжээл болдог. Сүрэглэнэ.




АМЬДРАХ ОРЧИН

Хүйтэн усны загас. Нуур болон голд тархан амьдарна. Жарамгай нь зун голын урсгал багатай тогтуун хэсгээр идээшилнэ.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн Сэлэнгэ мөрний сав газар, Туул голын сав газар; Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Улз, Халх, Оршуун, Буйр нуурт тархана.



DESCRIPTION

Back yellowish-brown, abdomen and sides silvery yellow. Back and body sides have small dark spots. Body sides with black mid lateral stripes. Mouth large, subterminal. Eyes big. Body depth equal to 18-22% of body length. Dorsal fin length longer than distance between pelvic and anal fins base. Abdomen densely covered by scales. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-4.2 (rare 2.5-5.2). Gill rakers number - 8-10. The dorsal fin (D) has II unbranched soft rays, and 6-8 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 7 branched soft rays. Lateral line complete, with 62-89 scales.

CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.

BIOLOGY

Non game species. Bigger than other minnows, body length can reach up to 17-20 cm. Lagowski's minnow mature in 3 years with 6-7 cm long. Spawning from June to July when water temperature increase up to 19.9°C. Females lay eggs in rivers with fast current on gravel and stones. Spawning a multiple times in a season. Females produce 700-1,700 eggs, diameter eggs - 1.6-2.0 mm. Feeds on aquatic vegetation, zooplankton, larvae of insects and insect's imago, eggs of commercial fish. Lagowski's minnow is one of the main foods of predators. Forms schools.

HABITAT

Cold water species. Inhabits rivers and lakes. In summer fry occurs in rivers with slow current.

DISTRIBUTION

The Selenga River basin, the Tuul River basin of the Arctic ocean basin; Kherlen, Onon, Ulz, and Khalkh rivers, and Buir Lake (Pacific ocean basin).

УЛААН ЖИВЭРТ

Pseudaspius leptocephalus Pallas, 1776

Redfin



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие урт, хавчиг. Нуруу ногоовтор бор, хажуу мөнгөлөг, хэвлий цайвар. Нурууны сэлүүр ягаавтар, бусад сэлүүрүүд улаан. Толгой урт, хоншоор урт, биеийн уртын 21-34%-ийг эзлэнэ. Ам тэгш, өргөн. Доод эрүү жижигхэн товгортой, дээд эрүүг давсан. Дух нарийн. Эрүүнд шүд байхгүй. Хэвлий бөөрөнхийдүү, хэвлийн сэлүүрийн өмнөхөн бага зэрэг хавчиг, хэвлийд хянга байхгүй, хайрсгүй. Заламгайн өргөс богино, зайтай, 8-11. Залигуурын араа хоёр эгнээ цилиндр хэлбэртэй, гөлгөр, сулхан дэгээ шиг матийсан 2.4-4.2 ховор 2.5-4.2 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 6-7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 8-9 гуурстай. Хажуугийн шугам 91-102 хайрстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын загас. Биеийн урт 60 см, жин 1.9 кг хүрнэ. Улаан живэрт 5-6 насандаа бэлгэ боловсорно. Үржил 5 сарын сүүлч 6 сарын эхээр. Голоо өгсөн усны ёроолын элс, хайрган дээр түрээ шахна. Атуу 25,200-64,300 ширхэг түрс гаргана. Түрсний голч 1.3-1.5 мм. Жижиг загасаар гол төлөв гүрц болон варлангаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Улаанживэрт нь голд тархан амьдарна. Жилийн ихэнхи хугацаанд голын эхээс адаг хүртэлх тархана. Нуурт өвөлжинө.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг. Монгол Улсын Амьтны тухай хуулинд Буйр нуурын загасыг 5 дугаар сарын 15-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Оршуун, Халх гол, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Body elongate, compressed. Back grayish brown, side's silvery; abdomen lighter. Dorsal fin reddish, other fins red. Head long, snout long, 21-34% of body length. Mouth is terminal, wide; lower jaw with a small tubercle, projecting beyond the upper jaw. Forehead slim. No teeth in the jaws. Abdomen rounded or slightly compressed before pelvic fins, no abdominal keel, without scales. Gill rakers short, wide spaced, their number - 8-11. Pharyngeal teeth are in two rows, cylindrical, a smooth, elongated as a weak hook, have formula 2.4-4.2 rarely 2.5-4.2. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 6-7 branched soft rays, the anal fin (A) has III unbranched soft rays, and 8-9 branched soft rays. Lateral line with 91-102 scales.



BIOLOGY

Commercial species. Can reach 60 cm length, and weight 1.9 kg. Redfin mature in 5-6 years old. Spawning from late May to early June. Migrates to upper reaches of rivers for spawning. Females lay eggs on sand and gravel. Females produce 25,200-64,300 eggs. Diameter eggs - 1.3-1.5 mm. Feeds on small fish such as gudgeons and minnows.



HABITAT

Inhabits rivers. Around a year occurs from upper reaches to lower reaches of rivers. Wintering in lakes.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient. Mongolian Law on Fauna fishes of Buir lake hunting and trapping prohibitive from May 15th to August 01st of the following calendar year.



DISTRIBUTION

Kherlen, Onon, Orshuun and Khalkh rivers, Buir Lake (Pacific ocean basin).

АМАРЫН ХӨӨЛӨНХЭЙ

Pseudorasbora parva Temmink et Schlegel, 1846

Stone moroko



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу шаравтар-бор, хажуу цайвар. Биеийн өндөр толгойн уртаас бага зэрэг их. Өсвөр насны загас нь биеийнхээ хажуугаар нарийн хар судалтай байх ба бие гүйцсэн загасанд судал байхгүй. Бие гүйцсэн загасны хайрс захаараа бараан ирмэгтэй. Ам дээд, хөндлөн, маш жижиг. Сахалгүй, хэвлийд хянга байхгүй. Хэвлийн сэлүүр, нурууны сэлүүрийн 1 болон 2 дахь салаалсан гуурсны харалдаа эхлэнэ. Заламгайн өргөс дутуу. Доод уруул нарийн. Хайрс том. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6 гуурстай. Хажуугийн шугам 35-38 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Биеэр жижиг, биеийн урт 8 см хүрнэ. Амарын хөөлөнхэй 2 насандаа бэлгэ боловсорно. Сүрэглэн амьдардаг. Үржил 6 сарын сүүлээс 7 сарын эхэн хүрнэ. Үржлийн атуухын бие бараантан бараг хар өнгөтэй болох ба нүднийх нь доор хурц эвэрлэг товгор үүснэ. Атуу 300-3,000 ширхэг түрс гаргана. Түрс нь уртассан хэлбэртэй, түүний урт ойролцоогоор 1.7-2.0 мм. Атуух нь түрсээ хамгаалдаг. Гол төлөв ёроолын шавьжийн авгалдай, хөвөгч амьтдаар хооллох ба агнуурын загасны түрсийг иднэ. Өөрөө Амарын цурхай, улаан живэрт, цулбуурт загасны үндсэн тэжээл болдог.




АМЬДРАХ ОРЧИН

Тогтуун урсгалтай голын элс, шаварлаг ёроол, ургамал бүхий хэсэг, нуурын гүехэн хэсгээр тархан амьдарна.



ТАРХАЛТ

Харь зүйл. Евроазид өргөн тархсан харь зүйл. Монголын уугуул зүйл. Монголд Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Оршуун, Халх гол, Буйр нуурт тархана.



DESCRIPTION

Back yellowish-brown, sides light. Body depth slightly exceeding head length. Body sides of juveniles with black thin stripes, and adults without stripes. In adults scales edged grayish. Mouth superior transverse, very small. Barbels and abdomen keel are absent. Pelvic fins origin under the 1st or the 2nd branched rays of dorsal fin. Gill rakers rudimentary. Lower lip thin. Scales large. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 6 branched soft rays. Lateral line with 35-38 scales.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



BIOLOGY

Non game species. Small fish, can reach up to 8 cm length. Stone moroko mature in 2 years old. Forms schools. Spawning in late June - early July. Mature males become almost black; under the eyes they have sharp horny tubercles. Females produce 300-3,000 eggs. Eggs are ellipsoid shape, its length approximately 1.7-2.0 mm. Male guards the eggs. Feeds on benthic insect larvae, zooplankton and eggs of commercial species of fish. It self is main food of some commercial species such as Amur pike, redfin, and catfish.



HABITAT

Inhabits slow-flowing rivers with sand and mud bottom, and aquatic vegetation, and shallow water of lakes.



DISTRIBUTION

Invasive species, wide spreading in Eurasia. Native for Mongolia. Range in Mongolia: Kherlen, Onon, Orshuun, Khalkh rivers, and Buir Lake (Pacific ocean basin).

ХАЛБАГАН ЖАРАА

Rhodeus sericeus Pallas, 1776

Bitterling



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие өндөр. Нуруу ногоовтор бор, хажуу мөнгөлөг, биеийн хойд хэсэгт биеийн хажуугаар ногоон-хөх солонгорсон нарийн тууш зураастай. Ам жижиг, хагас доод, бага зэрэг ташуу. Сахалгүй. Хайрс том. Нурууны сэлүүрийн урт сүвийн сэлүүрийн урттай тэнцүү. Нурууны сэлүүр уртавтар, хэвлийн сэлүүрийн сууриас бага зэрэг хойш эхэлсэн. Сүвийн сэлүүр нурууны сэлүүрийн төгсгөлийн харалдаагаас эхэлнэ. Сүүлний сэлүүрийн бариал богино, биеийн уртын 22-26%, дунджаар 23.8% эзэлнэ. Заламгайн өргөс 11-15. Залигуур араа хажуугаасаа бага зэрэг хавчгар, бахим, нэг эгнээ 5-5 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 8-11, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 8-10 гуурстай. Хажуугийн шугам бүрэн бус, 5-11 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Бие жижиг, биеийн урт 10.5-12.6 см, жин 20-83 грамм хүрнэ. 2 насандаа биеийн урт 3 см болоход бие гүйцэж үржилд орно. Үржил 5 сарын сүүлээс 7 сарын эхэн хүрнэ. Түрсээ хэсэгчилэн шахна. Үржлийн үед атуух улам тод өнгөтэй болж биеийн хажуу нил-мөнгөлөг өнгөтэй болдог. Харин атуугийн хагны уут уртасч хоёр хавтаст дунгийн хясаан завсар түрсээ орхино. Түрс нь тэндээ үр тогтон хөврөлийн хөгжил нь явагддаг байна. Атуу 224-290 ширхэг түрс гаргана. Хөвөгч амьтад, ургамлаар хооллож өөрөө бусад загасны хоол болдог.




АМЬДРАХ ОРЧИН

Гол төлөв голын зөөлөн урсгалтай, тогтуун хэсэгт тархан амьдарна.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Халх, Оршуун гол, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Body is deep. Back is grayish brown; sides of body are silvery with narrow green-blue rainbow longitudinal stripe posteriorly. Mouth small, subterminal, and slightly oblique. Barbells are absent. Scales large. Dorsal fin length equal to length of anal fin. Dorsal fin elongate, commencing slightly behind the base of pelvic fins. Anal fin commencing before the vertical through the end of dorsal fin. Caudal peduncle is short, 22-26%, average 23.8% of body length. Number of gill rakers - 11-15. Pharyngeal teeth slightly compressed, and massive, have one row, with formula 5-5. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 8-11 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 8-10 branched soft rays. Lateral line incomplete, with 5-11 scales.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



BIOLOGY

Non game species. Small fish, can reach up to 10.5-12.6 cm length, and weight 20-83 g. Maturity in 2 years old, about 3 cm long. Spawning since late May till early July. Spawning a multiple in a season. Breeding males becomes bright with violet-silvery coloration on the body sides. Breeding females have the ovipositor becomes longer and its lay eggs in the mantle cavity of the bivalve mollusks. Embryonic development of fertilized eggs takes place inside of mollusks. Female produce 224-290 eggs. Feeds on zooplanktons, and aquatic vegetation. It self is main food of other fishes.



HABITAT

Inhabits usually rivers with slow current, lakes and other standing waters.




DISTRIBUTION

Kherlen, Onon, Khalkh, Orshuun rivers, and Buir Lake (Pacific ocean basin).

УЛААН НҮДЭН

Rutilus rutilus Linnaeus, 1758

Roach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нүдний солонгон бүрхүүл улаан өнгөтэй байдаг нь улаан нүдэн загасны гол ялгарах шинж болдог. Сэлүүрүүд нь улаан. Биеийн өндөр уртын 29-30%-тай тэнцүү. Нурууны сэлүүр хэвлийн сэлүүрийн бараг харалдаа эхэлнэ. Хайрс том эсвэл дунд зэрэг. Хажуугийн шугам хэвлий тийш бага зэрэг муруйсан ба биеийн төгсгөл хүртэл үргэлжилнэ. Ам бараг тэгш, дээд эрүү доод эрүүг бага зэрэг давсан. Бие гүйцсэн том загасны биеийн хэлбэр нь харьцангуй өндөр, өргөн. Бие мөнгөлөг хөх, хэвлий цагаан. Заламгайн өргөс богино, 11-15. Залигуур араа нэг эгнээ 6-5 эсвэл 5-5 (ховор 6-6) шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалсан II-III, салаалаагүй 9-11, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 9-12, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 13-17, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 8-9 гуурстай. Хажуугийн шугам 50-иас доош хайрстай, гол төлөв 42-46 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 49 см, жин 2.1 кг хүрнэ. 3-4 насандаа бие гүйцэж үржилд орно. 5 сарын сүүлч 6 сарын эхээр нуурын гүехэн устай булан тохойн усны ургамал бүхий хэсэг, голын адаг орчмын гүехэн хэсгийн ургамалд түрсээ шахна. Атуу 65,00-31,400 дунджаар 19,900 ширхэг түрс гаргана. Түрсний голч 1.0 мм. Түрс нь наалдамхай чанартай. Замаг, усны ургамал, хөвөгч амьтад, усны ёроолын шавьжийн авгалдайгаар хооллоно. Өөрөө махан идэшт цурхай, алгана загасны үндсэн гэжээл болдог. Агнуурын ач холбогдолтой. Өгий нуурын загас агнуурт 40-80%-ийг эзэлдэг.




АМЬДРАХ ОРЧИН

Улаан нүдэн загас нь дасан зохицох чадвар сайтай, ямар ч төрлийн цэнгэг ус тэр дундаа жижиг цөөрөм, томоохон гол, нууруудад тархан амьдарна. Ихэвчлэн усны ургамал элбэгтэй гүехэн хэсгээр тархана.



ТАРХАЛТ

Сэлэнгэ мөрний сав газарт: Орхон, Туул, Хараа, Ерөө, Цөх, Хүдэр, Идэр, Чулуут, Дэлгэрмөрөн, Эг голуудад, мөн Өгий, Тэрхийн цагаан, Хөвсгөл нуурт тархсан (Хойд мөсөн далайн ай сав).



DESCRIPTION

Colors of the eyes red and it's one of the main distinguish character for roach. The fins are red. Body depth equal 29-30% of body length. Dorsal fin origin above the pelvic fins base. Scales large or moderate. Lateral line with slight bend towards belly. Mouth is terminal, upper jaw slightly beyond the lower jaw. Older specimens acquire a higher and broader body shape. Body a bluish silvery color and becomes white at the belly. Gill raker short, their number -11-15. Pharyngeal teeth are in on row, have formula 6-5 or 5-5 (rarely 6-6). The dorsal fin (D) has II-III unbranched soft rays, and 9-11 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 9-12 branched soft rays; pectoral fins (P) have I unbranched soft rays, and 13-17 branched soft rays; pelvic fins (V) have I unbranched soft rays, and 8-9 branched soft rays. Lateral line has less than 50 scales, usually 42-46 scales.



CONSERVATION STATUS

Regionally Least Concern. Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from April 01st to June 15th of the following calendar year.



BIOLOGY

Can reach up to 49 cm in length, 2.1 kg in weight. Maturity in 3-4 years old. Spawning late May early June, lay eggs on aquatic vegetation in shallow water of lakes, and in down reaches of rivers. Females produce in 6,500-31,400 eggs, average 19,900 eggs. Diameter of eggs 1.0 mm. Eggs sticky. Feeds algae, macrophytes, zooplankton, and insect larvae. Roach is a main food of piscivorous species such as pike and perch. Commercial species. Roach has 40-80% of annual catches of Ugii Lake.



HABITAT

Roach is very adaptable and can be found in any freshwaters since small ponds, to the largest rivers and lakes. Inhabits usually shallow waters with dense aquatic vegetation.



DISTRIBUTION

The Selenga River basin: Orkhon, Tuul, Kharaa, Eruu, Tsek, Khyder, Ider, Chuluut, Delgermurun, Eg rivers; and Ugii, Terkhiin Tsagaan, and Khuvsgul lakes (Arctic ocean basin).

СОЛДАТОВЫН УРУУЛТ ГҮРЦ

Sarcocheilichthys soldatovi Berg, 1914
Soldatov's thicklip gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу хар ногоон, хоёр хажуу мөнгөлөг алтлаг туяатай. Бие энд тэнд тархсан хар толботой. Хайрс хар ирмэгтэй. Ам жижиг, хагас доод. Сахалгүй. Залигуур араа хоёр эгнээ 1.5-5.1. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 6 гуурстай. Хажуугийн шугам 38-43 хайрстай.



АМЬДРАХ ОРЧИН

Голын үндсэн гулдрил, нуурт тархан амьдарна. Авгалдай нь сүрэглэдэггүй нэг нэгээрээ усны гадаргууд тархаж байгаад усны ёроол руу нүүдэллэн дараа нь эргийн бүсэд идэш тэжээлээ хайхаар шилжилт хийнэ.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 11 см хүрнэ. 6 хүртэл насална. Үржил 6 сарын дундаас 7 сарын сүүл хүртэл үргэлжилнэ. Түрсээ хэсэгчилэн шахна. Түрсний голч 2.0 мм. Үржлийнхээ үед атуухын өнгө өөрчлөгддөг: толгойн дээд хэсэг, заламгайн хавхагны ар тал, цээжний сэлүүрийн уг, хэвлийн болон сүвийн сэлүүр улбар, хэвлий мөнгөлөг өнгөтэй болох ба нүдний доод хэсэг, заламгайн хэсэгт товруу үүснэ. Гол төлөв ёроолын сээрнууруугүйтэнээр хооллоно: жингэнүүр ялааны авгалдай, өдөрч, хар ялаа, хоовгоны авгалдай орно.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуурт тархана.



DESCRIPTION

Coloration of the back is dark green; the sides are silvery with a golden hue. On the body are scattered dark spots. Scales with a dark rim. Mouth is small, semi-inferior. Barbels are absent. Pharyngeal teeth have formula 1.5-5.1. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II unbranched soft rays, and 6 branched rays. Lateral line with 38-43 scales.



HABITAT

Inhabits main channel of rivers, and lakes. The fry not form schools, inhabits along by along in surface of water than move to bottom and after that move to inshore for the feeding.



BIOLOGY

Non game species. Small fish. Can reach up to 11 cm length, and 6 years of age. Spawning continues from middle of June till end of July. Spawning a multiple in a season. Eggs diameter is in 2.0 mm. Breeding males change coloration: top of head, back part of operculum, base of pectoral fins, pelvic and anal fins become reddish, belly silvery, and below eye, and operculum covered with outgrowths. Feeds mainly on benthic invertebrates: chironomids, mayfly, black fly, and caddisfly larvae.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.




DISTRIBUTION

Buir Lake (Pacific ocean basin).

ХАДААСАН ГҮРЦ

Saurogobio dabryi Bleeker, 1871

Chinese lizard gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие уртавтар, хайрс дунд зэрэг. Нуруу шаравтар хүрэн, хайрсны захаар бараан эмжээртэй. Сэлүүрүүд толбогүй. Хажуугийн шугамын дээгүүр нарийхан хар зураас үргэлжлэх бөгөөд өсвөр насны загасны биеийн хажуугаар 5-6 уртавтар бараан толботой. Хошуу монхор. Сахал нүдний урд захын харалдаа хүрнэ. Сахлын урт нүдний диаметртэй тэнцүү. Ам доод. Дух ялимгүй хүнхэр. Дээд уруул махлаг пэмбэгэр. Залигуур араа нэг эгнээ 5-5 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 8, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6 гуурстай. Хажуугийн шугам 47-52 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Биеийн урт 25 см хүрнэ. 2 насандаа биеийн урт 11.5-12.5 см болоход бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 5-р сарын сүүлчээс 7-р сарын эхэн хүртэл усны температур 12.0-22.5°C хооронд үргэлжилнэ. Түрсээ хэсэгчилэн шахна. Атуу түрсээ усны гүнд шахах ба түрс чөлөөтэй хөвдөг. Түрсний голч 2.3-3.0 мм. Атуу 15,100-31,200 ширхэг түрс гаргана. Бие гүйцээгүй хадаасан гүрц хөвөгч амьтдаар хооллох ба бие гүйцсэн үедээ жингэнүүр ялааны авгалдай, усны сээрнууругүйтэн амьтдаар хооллодог.




АМЬДРАХ ОРЧИН

Голын үндсэн гулдрилд тархан амьдарна. Нуурт ховор тохиолддог.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуурт тархана.



DESCRIPTION

Body elongate, scales moderate. Back yellowish brown, with dark edged scales. Fins without spots. A narrow dark streak running above the lateral line, consisting of 5-6 separate elongate spots in the young. Snout is blunt. Barbels extending to the vertical from the anterior margin of eye. Length of barbels equal to the diameter of eye. Mouth inferior. Forehead slightly concave. Upper lip fleshy. Pharyngeal teeth are in one row, have formula 5-5. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 8 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 6 branched rays. Lateral line with 47-52 scales.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.



BIOLOGY

Non game species. Can reach up to 25 cm length. Mature in 2 years old, when 11.5-12.5 cm long. Spawning from late May to early June when water temperature ranged from 12.0 to 22.5°C. Spawning multiple times in a season. Females lay eggs in deep water and eggs drifting free. Eggs diameter - 2.3-3.0 mm. Females produce 15,100-31,200 eggs. Juveniles feed on zooplankton, and adults feed mainly on larvae of chironomids, and other invertebrates.



HABITAT

Inhabits main channel of the rivers. Rarely occurs in the lakes.




DISTRIBUTION

Buir Lake (Pacific ocean basin).

ХАНХЫН ГҮРЦ

Squalidus chankaensis Dybowski, 1872

Khanka gudgeon



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нурууцайвар шаргал, нуруундээрх хайрсны захаар бор эмжээртэй. Хажуу ба хэвэл цайвар, биеийн хажуугаар мөнгөлөг тууш бүслүүр үргэлжилнэ. Заримдаа мөнгөлөг бүслүүрийн дээгүүр бараан тууш бүслүүр үргэлжилсэн байдаг. Сэлүүрүүд цайвар, толбогүй. Ам бараг тэгш эсвэл хагас доод. Сахал богино. Биеийн өндөр биеийн уртын 15.6-26.6%-ийг эзлэнэ. Залигуур араа хоёр эгнээ 2.5-5.3 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 6 гуурстай. Хажуугийн шугам 36-41 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Бие жижиг, биеийн урт 10 см хүрнэ. 2 насандаа биеийн урт 4-5 см болоход бэлгэ боловсорч үржилд орно. 6-р сараас 7-р сарын дунд хүртлэх хугацаанд усны температур 18°C-аас доошгүй байхад үрждэг. Атуу усны ёроолын ургамал, бусад субстрат түрсээ дээр орхино. Түрсээ хэсэгчилэн шахна. Атуу 2,300-4,400 ширхэг түрс гаргана. Жингэнүүр ялааны авгалдай, усны сээрнууругүйтэн амьтад, тэдгээрийн авгалдайгаар хооллодог. Ёроолын идэшт агнуурын ач холбогдолтой загас тэр дотроо булуу цагаан загастай идэш тэжээлийн өрсөлдөөнд ордог. Монголын улаан далбаат, цулбуурт, улаанживэртийн үндсэн хоол тэжээл болдог.




АМЬДРАХ ОРЧИН

Голын тогтуун хэсэг, нуурт амьдардаг. Ёроолын амьдралын хэвшилтэй загас.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуур.



DESCRIPTION

Back is light yellowish, scales on back with brown edged. Sides and belly are light, on sides running silvery stripe. Sometimes above silvery stripe is darkish stripe. Fins are light and spotless. Mouth is terminal or subterminal. Barbells are short. Body depth 15.6-26.6% of body length. Pharyngeal teeth are in two rows, have formula 2.5-5.3. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II unbranched soft rays, and 6 branched rays. Lateral line with 36-41 scales.



DISTRIBUTION

Buir Lake of the Pacific Ocean basin.



BIOLOGY

Non game species. Small fish, can reach up to 10 cm length. Mature in 2 years old, when 4-5 cm long. Spawning from June to middle July when water temperature less than 18°C. Females lay eggs over bottom vegetation, and any substrates. Spawning multiple in a season. Females produce 2,300-4,400 eggs. Feeds on larvae of chironomids, and other invertebrates. Food competitor with bottom-dwelling commercial species such as Amur carp. It self is a main food of the Mongolian culter, Amur pike and redfin.



HABITAT

Inhabits rivers with slow water, and lakes. Bottom-dwelling.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.

ШАРГАЛ ҮХЭРДЭЭ

Tinca tinca Linnaeus, 1758

Tench



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие бүдүүн бахим, өндөр, биеийн өндөр биеийн уртын 2.9-3.1-тэй тэнцэнэ. Хайрс жижиг, урт, арьсанд гүн сууж өгсөн. Нуруу хар-ногоон, хажуу тал хар-бор эсвэл ногоон бор, алтлаг туяатай ногоовтор шар. Бүх сэлүүрүүд хар бараан. Нурууны сэлүүр цээжний сэлүүрийн суурийн хойт захын дээрээс, сүвийн сэлүүр нь нурууны сэлүүрийн хойт захаас эхлэнэ. Бүх сэлүүрүүдийн үзүүр дугуйвтар. Сүүлний бариул богино, өндөр. Ам тэгш, жижиг, хоёр завьжиндаа богино хос сахалтай. Нүд жижигхэн, улаавтар өнгөтэй. Заламгайн өргөс уртавтар, заламгайн нэгдүгээр нуманд 12-13 өргөстэй. Залигуур араа нэг эгнээ 4-5 эсвэл 5-5, эсвэл 4-4 шүдтэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 8, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 6-8 гуурстай. Атуух хажуугийн шугамандаа 87-120 хайрстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт 60 см, жин 7.2 кг хүрнэ. Сүрэглэдэггүй. Үхэрдээ 3-4 насандаа биеийн урт 20 см хүрэхэд бэлгэ боловсорч үржилд орно. Үржил 6 сараас 7 сард усны температур 19-20 хэмд үргэлжилнэ. Атуу түрсээ ургамалд орхино. Түрсээ хэсэгчилэн шахна. Түрс жижигхэн. Атуу 300,000-400,000 ширхэг түрс гаргана. Гол төлөв ёроолын шавьжийн авгалдай, зөөлөн биетэнээр хооллох ба зарим тохиолдолд ургамлаар хооллосон байдаг.



АМЬДРАХ ОРЧИН

Гол төлөв нуурт амьдарна. Тогтуун урсгалтай шаварлаг ёроолтой, ургамлаар баялаг хэсэгт тохиолдоно. Хүчилтөрөгчөөр дутмаг усанд дасан зохицох чадвартай.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон. Монгол улсын Амьтны тухай хуулинд нэн ховор гэсэн ангилалд бүртгэгдсэн (2012).



ТАРХАЛТ

Булган голд ховор тохиолдоно (Хойд мөсөн далайн ай сав).



DESCRIPTION

Body massive and deep, depth of body is 2.9-3.1% of its length. Scales small, elongate, deep immerse to skin. Back is dark green, body side's dark brown or greenish-brown, or greenish-yellow with golden sheen. All fins are dark brownish. Dorsal fin origin above the posterior end of the ventral fins base, anal fin behind the dorsal fin base. All fins are rounded. Caudal peduncle short and deep. Mouth is terminal, small, with short barbels at its corners. Eyes small, reddish color. Gill rakers longish, its number on the 1st arch - 12-13. Pharyngeal teeth are in one row, have formula 4-5, or 5-5 or 4-4. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 8 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 6-8 branched soft rays. Lateral line for male with 87-120 scales.

BIOLOGY

Can reach up to 60 cm length, and 7.2 kg weight. Not forms schools. Tench mature in 3-4 years old, about 20 cm long. Spawning from June till July when water temperature between 19-20°C. Females lay eggs into aquatic vegetation. Spawning multiple times in a season. Eggs small. Female produce 300,000-400,000 eggs. Feeds on insect larvae, snails, sometimes on aquatic plants.

HABITAT

Inhabits predominately lakes, and sometimes rivers. Occurs in still waters with muddy substrate and with abundant vegetation. It tolerates water with a low oxygen concentration.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable. Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from April 1st to June 15th of the following calendar year. Listed as very rare under the Mongolian Law on Fauna (2012).

DISTRIBUTION

Rare in the Bulgan River (Arctic ocean basin).

ШИВЭР САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula (=Orthrias) toni Dybowski, 1869
Siberian stone loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Өнгө хар толботой саарал-бор, хэвлий нуруугаа бодвол цайвардуу. Нуруу, сүүл болон цээжний сэлүүрүүд хар толботой. Хэвлийн болон сүвийн сэлүүрүүд маш бүдэг толботой эсвэл толбогүй. Бие уртавтарт. Ам 3 хос сахлаар хүрээлэгдсэн. Толгой хавтгайдуу. Биеийн урд хэсэг хайрстай. Уруул махлаг пэмбэгэр. Нурууны сэлүүр дунд зэрэг, хэвлийн сэлүүрийн сууриас ялимгүй арагш байрласан. Сүүлний сэлүүр толгойн уртаас үргэлж бага үл ялиг ухлаадастай. Цээж болон хэвлийн сэлүүрийн хоёр буюу гурав дахь гуурс хамгийн урт. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II-IV, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5-6, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 10-15, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I-II, салаалсан 7-8 гуурстай. Нурууны нугаламын тоо 41-47. Заламгайн өргөс 10-12.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 16-18 см хүрнэ. Шивэр сахалт эрээлж нь 2 насандаа, биеийн урт 7 см болоход бэлгэ боловсорч үржилд орно. 5 сард голд үржинэ. Агуу түрсээ хайрга чулуун хурдсанд шахна. Усны ёроолын сээрнуруугүйтэн голчлон шавьжийн авгалдайгаар хооллоно. Ёроолын амьдралтай махчин загасны идэш тэжээлд зонхилох үүрэг гүйцэтгэнэ.



АМЬДРАХ ОРЧИН

Хүйтэн усны загас. Голын урсгал ихтэй, хайрга чулуун ёроолтой хэсэгт амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй.



ТАРХАЛТ

Монгол орны Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савын гол мөрөн, нуураар түгээмэл тархсан.



DESCRIPTION

Coloration gray-brown with dark spots, belly lighter than back. On the dorsal, caudal and pectoral fins, dark spots. On the ventral and anal fins, the spots are weak or absent. Body elongate. Mouth surround by 3 pairs of barbels. Head depressed. Scales cover the anterior part of the body. Lip massive. Dorsal fin moderate, slightly behind the origin of pelvic fins. The caudal fin is always shorter than the length of the head and emarginate. In dorsal and pelvic fins 2nd and 3rd rays longer. The dorsal fin (D) has II-IV unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5-6 branched soft rays; pectoral fins (P) have I unbranched soft ray, and 10-15 branched soft rays; pelvic (V) fins have I-II unbranched soft rays, and 7-8 branched soft rays. Number of vertebrates - 41-47. Number of gill rakers is 10-12.

BIOLOGY

Non game small fish. Body length can reach up to 16-18 cm. Siberian stone loach are mature in 2 years old, when 7 cm length. Spawning in May, in rivers. Females lay eggs on gravel. Feeds on benthic invertebrates, mainly insect larvae. Play a major role as prey of bottom piscivorous fish.

HABITAT

Cold water species. Inhabits rivers with high current velocity and gravel bottom.

CONSERVATION STATUS

Regionally Least Concern.

DISTRIBUTION

Wide distributed in the rivers and lakes of all three Mongolian water basins: the Arctic ocean basin, Pacific ocean basin, and Central Asian Internal Drainage basin.

ГОВИЙН ЭРЭЭЛЖ

Barbatula (=Orthrias) dgebuadzei Ptokofiev, 2003

Dgebuadzei's stone loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие махлаг, толгойн ар хэсэг бага зэрэг бөгтөр, сүүлний сэлүүр богино, хавчгар. Шаргал-саарал, шаргал-бор өнгийн дэвсгэр дээр хажуугаараа бие биентэйгээ нийлсэн хөндлөн хар толбууд нь зурвас мэт харагддаг. Толгойн доод хэсэг болон хэвлий цайвардуу өнгөтэй. Хошуу монхор, толгой өргөн, хавчгар биш. Ам харьцангуй урт 3 хос сахлаар хүрээлэгдсэн (толгойн уртын 26.3%). Нүд жижиг. Ам доод. Хайрсгүй, гэхдээ сүүлний сэлүүр орчмын арьсанд цөөн хэдэн хайрстай. Хайрс нь бөөрөнхий, төвдөө том нүхтэй. Нуруу, сүүл болон цээжний сэлүүрүүд тод толботой, сүвийн болон хэвлийн сэлүүр толбогүй. Сүүлний сэлүүр сулхан ухлаадастай, толгойн уртаас бага. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5-6, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 10-13, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 6-8 гуурстай. Хажуугийн шугам бүтэн. Нурууны нугаламын тоо 44-45.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Говийн эрээлжийн биеийн урт 14 см хүрнэ. Говийн эрээлжийн экологи судлагдаагүй, магадгүй шивэр сахалт эрээлжийн экологитой ойролцоо.



АМЬДРАХ ОРЧИН

Голын хүчилтөрөгчөөр баялаг урсгал бүхий хэсгийн хайрга, чулуун ёроолд тархан амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт устаж болзошгүй, B2ab(iii).



ТАРХАЛТ

Заг гол (Байдраг голын сав) болон Говийн Хөндийн нууруудын Онгийн гол (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).



Эх сурвалж: Монгол орны загасны улаан данс (2006)-ны тархацын зургийн өгөгдлийг сайжруулан боловсруулав. Source: Modified from Mongolian Red List of Fishes (2006).

DESCRIPTION

Body massive, behind of head slightly stooped, caudal fin short, and compressed. Body yellowish-gray and yellowish-brown coloration merged with each other in the lateral transverse black spots looks like a strip. Lower head and belly are light. Blunt-snouted, head wide, no compressed. Mouth surround by 3 pairs of relatively long barbells (26.3% of head length). Eyes small. Mouth inferior. Scales usually absent, but around the caudal fin few scales. Scales rounded, with a big hole in center. Dorsal, caudal, and pectoral fins with bright spots, and anal, pelvic fins without spots. Caudal fin emarginated, smaller than head length. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, 5-6 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 10-13 branched soft rays; the pelvic (V) fins have I unbranched soft ray, and 6-8 branched soft rays. Lateral line completed. Number of vertebrates usually - 44-45.

BIOLOGY

Body length reaches up to 14 cm. The ecology of the Dgebuadzei's stone loach has not been studied; its may be close to the ecology of the Siberian stone loach.

HABITAT

Inhabits rivers with high oxygen running waters with gravel and cobble bottom.

CONSERVATION STATUS

Regionally Endangered, B2ab(iii).


DISTRIBUTION

Zag (the Baidrag River Basin) and Ongi rivers of Lake Valley (Central Asian Internal Drainage Basin).

ГОЛУБЦОВЫН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula (=Orthrias) golubtsovi Prokofiev, 2003

Golubtsovi's stone loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие хажуугаасаа бага зэрэг хавчигдуу, цилиндр хэлбэртэй, нуруу бага зэрэг бөгтөр. Өнгө сааралдуу эсвэл сааралдуу шаравтар, толгой болон биеийн доод хэсэг цагаандуу болж ирнэ. Биеийн хажуугаар 10-14 хөндлөн хар зураастай бөгөөд босоо урт толбо нь «барынх» мэт хээ үүсгэнэ. Бүх сэлүүрүүд хар зураастай. Толгой болон бие дээр том төвгөртэй. Ам тойрсон 3 хос сахалтай; 2 дахь хос сахал нь хойд хамрын нүх, 3 дахь хос сахал нь нүдний дунд хүрэхгүй. Ам доод, уруул бага зэрэг хуниастай. Сүүлний бариул толгойн уртаас богино, хавчиг. Толгойг дээрээс нь харвал гурвалжин, хошуу хажуугаасаа хавчиг. Хоншоорын урт нүдний арын зайн урттай бараг тэнцүү. Нүд биеийн хажуугаас дээр сууж өгсөн. Нурууны сэлүүр сүүлний сэлүүрийн суурьтай ойрхон. Сүүлний сэлүүрийн үзүүр тэгш эсвэл сулхан ухлаадастай, дугуйвтар далбантай. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 7 (8), сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5-6, цээжний сэлүүр (P) салаалаагүй I-II, салаалсан 12-14, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 7-8 гуурстай. Хажуугийн шугам бүтэн, 65-88 хайрстай. Нурууны нугаламын тоо 45-47.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 133 мм хүрнэ. Усны ёроолын шавьжаар хооллоно. Голубцовын сахалт эрээлжийн экологи судлагдаагүй. Магадгүй шивэр сахалт эрээлжийн экологитой ойролцоо.



АМЬДРАХ ОРЧИН

Хүйтэн усны загас. Голын урсгал ихтэй, чулуу хайрган ёроолтой хэсэгт амьдарна.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Ховд голд тархан амьдарна.



DESCRIPTION

Body weakly compressed laterally, cylindrical, back is slightly convex. Coloration grayish or grayish yellowish, becoming almost whitish in the underside surface of the head and body. Sides with 10-14 black bands and vertically elongated spots, which forming “tigroid” pattern. Dark speckles are present on all fins. Have big epidermal tubercles on the head and body. Mouth surrounds 3 pairs of barbels; barbels of the second pair do not reach back part of nostril, barbels of the third pair do not reach middle of orbit. Mouth inferior, lips with moderately developed folds. Caudal peduncle shorter than head, and compressed. Head, if viewed from above, is triangular; snout laterally compressed. Snout length approximately equals postorbital distance. Eyes dorsolateral. The origin of dorsal fin is somewhat closer to the base of caudal fin. Caudal fin truncated or weakly forked, with rounded lobes. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 7 (8) branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5-6 branched soft rays; the pectoral fins (P) have I-II unbranched soft rays, and 12-14 branched soft rays; the pelvic (V) fins have I unbranched soft ray, and 7-8 branched soft rays. Lateral line completed, with 65-88 scales. Number of vertebrates - 45-47.



BIOLOGY

Non game small fish. Body length can reach up to 133 mm. Feeds on benthic insect larvae. The ecology of the Golubtsovi's stone loach has not been studied; its may be close to the ecology of the Siberian stone loach.



HABITAT

Cold water species. Inhabits rivers with high water current velocity and gravel bottom.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.



DISTRIBUTION

The Khovd River of the Central Asian Internal Drainage Basin.

ЗАВХАНЫ САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula (=Orthrias) dsapchynensis Prokofiev, 2016

Dsapchynensis stone loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие цилиндр хэлбэртэй, толгойн араас нурууны сэлүүр хүртэл жигд өндөр, сүүлний бариул хажуугаасаа хавчиг, толгойн уртаас богино. Бие жижиг толботой. Хоншоор өргөн. Ам 3 хос сахлаар хүрээлэгдсэн. 3 дахь хос сахал нүдний дунд хэсгийн хөндлөн огтлол хүрнэ. Ам хагас доод, хагас саран, дээд эрүүнд сул хөгжсөн шүд хэлбэрийн ургацтай. Дээд уруул дундуураа бага зэрэг ухлаадастай, эсвэл байхгүй. Хайрстай, үгүйдээ хэвлийгээс нурууны сэлүүр хүртэл үргэлжилсэн. Сүүлний сэлүүр ухлаадаггүй тэгш. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 11-13, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан (6)7-8 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 18 см хүрнэ. Усны ёроолын шавьжаар хооллоно. Завханы сахалт эрээлжийн экологи судлагдаагүй. Магадгүй шивэр сахалт эрээлжийн экологитой ойролцоо.



АМЬДРАХ ОРЧИН

Хүйтэн усны загас. Голын урсгал ихтэй, чулуу хайрган ёроолтой хэсэгт амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Завхан голын цутгал Богдын гол.



DESCRIPTION

Body cylindrical, evenly deep from occiput to dorsal fin origin, caudal peduncle compressed from sides, shorter than lateral head length. Body with small spots. Snout wide. Mouth surrounds 3 pairs of barbels. Barbels of the third pair reached of a vertical through the middle of the eye. Mouth subinferior, semilunar, dentated protrusion of upper jaw moderately developed. Upper lip with a weak medial cutting or without it. Well developed scales, at least from a vertical through dorsal fin origin. Caudal fin truncate. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 11-13 branched soft rays; the pelvic (V) fin have I unbranched soft ray, and (6)7-8 branched soft rays.



BIOLOGY

Non game small fish. Body length can reach up to 18 cm. Feeds on benthic insect larvae. The ecology of the *Dsapchynensis* stone loach has not been studied; it may be close to the ecology of the Siberian stone loach.



HABITAT

Cold water species. Inhabits rivers with high water current velocity and gravel bottom.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.



DISTRIBUTION

The Bogd River, a tributary of the Zavkhan River of the Central Asian Internal Drainage basin.

КОНИЛОБУСЫН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Barbatula (=Orthrias) conilobus Prokofiev, 2016

Conilobus's stone loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие цилиндр хэлбэртэй, толгойн араас нурууны сэлүүр хүртэл жигд өндөр, сүүлний бариул хажуугаасаа хавчиг, толгойн уртаас богино. Бие цайвар эсвэл шаргал, гол төлөв биеийн хажуугаар хөндлөн зураастай, заримдаа зураас нь сул харагддаг. Хоншоор урт, уртактар, хажуугаасаа хавчиг. Ам 3 хос сахлаар хүрээлэгдсэн. 3 дахь хос сахал нүдний дунд хэсгийн хөндлөн огтлол хүрдэггүй. Ам хагас доод, хагас саран, дээд эрүүнд сул хөгжсөн шүд хэлбэрийн ургацтай. Дээд уруул дундуураа гүн ухладастай, эсвэл бүрэн тусгаарлагдсан. Хайрсгүй, маш ховор сүүлний сэлүүрийн бариул орчим хайрстай. Сүүлний сэлүүр үл ялиг ухладастай. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III-IV, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 12-13, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 8 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 18 см хүрнэ. Усны ёроолын шавьжаар хооллоно. Конилобусын сахалт эрээлжийн экологи судлагдаагүй, магадгүй шивэр сахалт эрээлжийнхтэй ойролцоо.



АМЬДРАХ ОРЧИН

Хүйтэн усны загас. Голын урсгал ихтэй, чулуу хайрган ёроолтой хэсэгт амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Завхан голын цутгал Богдын гол.



DESCRIPTION

Body cylindrical, evenly deep from occipital to dorsal fin origin, caudal peduncle compressed from sides, shorter than lateral head length. Body light and yellowish, transversal bands on the sides, most often, present or the picture weak. Snout long, elongated, compressed from sides. Mouth surround by 3 pairs of barbells. Barbels of the third pair not reached of vertical through the middle of the eye. Mouth sub inferior, semi lunar, dentated protrusion of upper jaw moderately developed. Upper lip with a deep medial cutting or fully separated. Scales absent, rarely scales remain on the caudal peduncle. Caudal fin emarginated. The dorsal fin (D) has III-IV unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 12-13 branched soft rays; the pelvic (V) fins have I unbranched soft ray, and 8 branched soft rays.

BIOLOGY

Non game small fish. Body length can reach up to 18 cm. Feeds on benthic insect larvae. The ecology of the Conilobus's stone loach has not been studied; its may be close to the ecology of the Siberian stone loach.

HABITAT

Cold water species. Inhabits rivers with running water over gravel bottom.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.

DISTRIBUTION

The Bogd River a tributary of the Zavkhan River of the Central Asian Internal Drainage basin.

НАЙМАН САХАЛТ ЭРЭЭЛЖ

Lefua costata Kessler, 1876

Lefua, Eightbarbel loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу бор саарал, биеийн хажуу, хэвлий шаргал. Биеийн хажуугаар тод хар зурвастай. Бие нүцгэн, эсвэл маш жижиг хайрсаар хучигдсан. Хажуугийн шугам маш сул хөгжсөн. 8 сахалтай; нэг хос нь эхний хамрын нүхний ойролцоо, 4 нь хоншоорын урд, 2 нь завьжинд. Толгой хавтгай. Ам доод. Нүдний доод хэсэгт хатгуур байхгүй. Нурууны сэлүүр богино эсвэл дунд зэрэг, хэвлийн сэлүүрийн харалдаагаас бага зэрэг хойно. Нурууны болон сүвийн сэлүүрийн үзүүр дугуйвтар, жижиг толботой. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II, салаалсан 6-7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 10-12, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 5-6 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус. Жижиг загас, биеийн урт 4-7 см, маш ховор 10 см хүрнэ. Агуу голын элсэрхэг ёроолд түрсээ шахна. Түрсний голч 1 мм. Наймас эрээлж нь ялзмаг, шавраар хооллодог.



АМЬДРАХ ОРЧИН

Наймас эрээлж нь тогтмол ус, голын тогтуун урсгалтай ургамал ихтэй хэсгээр амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Азаргын гол, Тамсагийн булаг болон Буйр нуурын савд багтах бусад голуудад тархан амьдарна.



DESCRIPTION

Back is brown-gray, sides and abdomen yellowish. On sides bright black stripe. Body naked or covered with minute scales. Lateral line not well developed. Has 8 barbels; one pair near the first nostrils, four at the anterior of the snout and two in the corners of the mouth. Head flat. Mouth inferior. Folding spine below eyes is absent. Dorsal fin short or moderate, slightly behind the pelvic fins origin. Caudal and anal fins rounded, with small spots. The dorsal fin (D) has II unbranched soft rays, and 6-7 branched soft rays; the anal fin (A) has II unbranched soft rays, and 5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 10-12 branched soft rays; the pelvic (V) fins have I unbranched soft ray, and 5-6 branched soft rays.



BIOLOGY

Non game species. Small fish, body length rarely can reach up to 10 cm, usually 4-7 cm. Females lay eggs in rivers on sand bottom. Egg diameter - 1 mm. Feeds on detritus and silt.



HABITAT

Inhabits standing water, occurs slow-flowing rivers with abundant vegetation.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.



DISTRIBUTION

The Azarga River, Tamsag Spring and in rivers of Buir Lake Basin (Pacific ocean basin).

ТЭСИЙН ЭРЭЭЛЖ

Triplophysa gundriseri Prokofiev, 2002 (= *Nemacheilus dorsalis numilis* Gundr., *N. strauchi* (non Kessler))

Gundriseri's spotted thicklip loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу элгэн хүрэн бор, нуруу болон биеийн хажуу бөөрөнхий хар толбонуудтай. Хажуугийн үндсэн эгнээ 9-15 толботой. Нурууны сэлүүр болон сүүлний сэлүүр эгнээ хар толботой. Толгой цилиндр хэлбэртэй. Хошууны урт нүдний арын зайн урттай тэнцүү. Сүүлний бариулын өндөр биеийн уртад 2.5-3.9 дахин орно. Уруул атираатсан, эрүү гол төлөв жижигхэн гурвалжин арьсан ургацтай. Ам 3 хос сахлаар хүрээлэгдсэн ба голдуу нүдний хойд зах хүрнэ. Хошууны урт сүүлний уртаас богино. Бие нүцгэн. Хамрын сүвүүд хоорондоо ойрхон. Сүүлний сэлүүрийн ухлаадас бага. Хийт цуухны чөлөөт хэсэг толгойн уртаас мэдэгдэхүйц богино, дундуураа хязгаарлалтгүй. Заламгайн анхдагч нуманд 10-11 (гол төлөв 10) богино гурвалжин заламгайн өргөстэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II-III, салаалсан 7-7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй I-II, салаалсан 5-5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 10-11, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 6-7 гуурстай. Нурууны нугаламын тоо 41-43.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Биеийн урт нь 25 см, жин нь 100 гр хүрнэ. Үржлийнх нь үед агуу, агуухын бие дээгүүр эпителийн гаралтай төвгөрүүд үүснэ. Үржил 4 сараас 6 сар хүртэл үргэлжилж түрсээ хэсэг хэсгээр хайрга чулуу болон усны ургамалд шахна. Ерөнхийдөө агуу дунджаар 18,000-60,000 түрс гаргана. Усны ёроолын шавьжийн авгалдай, хөвөгч амьтад, загасны түрсээр хооллодог. Сүрэглэн амьдарна.



АМЬДРАХ ОРЧИН

Зундаа нуур, голын гүехэн хэсгийн ургамал бүхий хэсгээр идээшилнэ. Ерөнхийдөө нуурт амьдарна. Өвөлдөө нуурын гүн хэсэг рүү шилжинэ.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Тэсийн гол, Сангийн далай нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Back is chestnut brown, with rounded black spots on the back and sides of the body. The number of spots of the main lateral row - 9-15. Dorsal and caudal fins with rows of dark speckles. Head is cylindrical. Snout length equal to postorbital head length. Caudal peduncle depth 2.5-3.9 times in its length. Lips furrowed, small triangular skin lobes usually present on chin. Mouth surround by 3 pairs of barbells, usually reach posterior margin of orbit. Snout length shorter than length of caudal fin. Body naked. Nostrils closely adjacent to each other. Caudal fin emarginated. Free portion of air-bladder noticeably shorter than head length, without medial constriction. Have 10–11 (usually 10) short triangular gill-rakers on the first gill arch. The dorsal fin (D) has II-III unbranched soft rays, and 7-7 branched soft rays; the anal fin (A) has I-II unbranched soft rays, and 5-5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 10-11 branched soft rays; the pelvic (V) fins have I unbranched soft ray, and 6-7 branched soft rays. Number of vertebrates usually is 41-43.

BIOLOGY

Body length can reach up to 25 cm length, in weight 100 g. Breeding males and females have on the body epithelial outgrowths. Spawning continues from April till June. Females lay eggs on gravel and aquatic vegetation. Spawning multiple times in a season. Females produce 18,000-60,000 eggs. Feeds on insect larvae, zooplankton, and eggs of fish. Forms schools.

HABITAT

In summer occurs in shallow water of lakes and rivers with vegetations. Usually inhabits lakes. In winter move to deep water of the lake.

CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.


DISTRIBUTION

The Tes River and Sangiin Dalai Lake of the Central Asian Internal Drainage Basin.

ГУНДРИЗЕРИЙН ЭРЭЭЛЖ

Triplophysa gundriseri chandagaitensis Prokofiev, 2002

Chandagaity's spotted thicklip loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

T. g. chandagaitensis буюу Гундризерийн эрээлж нь номинотипийн дэд зүйлээсээ харьцангуй богино, шовгор (цилиндртэй харьцуулахад) толгой, хамрын сүвийн өмнө товгоргүй, хоншоор хажуугаасаа хавчгар биш, бие харьцангуй өндөр (түүний хамгийн их өндөр 6.7-7.7-той харьцуулахад биеийн стандарт уртад 5.9-6.9 дахин орно), сүүлний бариул (12-16-тай харьцуулахад стандарт уртад 11-13 дахин), нүдний диаметр харьцангуй бага (17.2%-той харьцуулахад дунджаар 14.8%), нүдний урд болон цээжний сэлүүрийн суурийн хэсгийн холбогч эд сайн хөгжсөн, хошуунаас нурууны сэлүүр (51.2%-тай харьцуулахад биеийн стандарт уртад дунджаар 53.2%), хошуунаас хэвлийн сэлүүрийн уг хүртэлх (27.4%-тай харьцуулахад стандарт уртад 31.8%) зай маш их, цээжний сэлүүрийнх богино (1.3-1.8-тай харьцуулахад 1.7-2.0 дахин хошуунаас хэвлийн сэлүүрийн уг хүртэлх зайд) мөн сүүлчийн гуурсны захын хэсэг хөрөө мэт, сүүлний сэлүүр ухлаадасгүй, доод эрүүний дунд ховилгүй, биеийн ерөнхий өнгө харьцангуй тод, бие болон сэлүүрүүд харьцангуй их толботой. Хажуугийн үндсэн эгнээ 14-18 толботой. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II-III, салаалсан 7-7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 5-5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 10-12, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 6-7 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Гундризерийн эрээлж загасны экологи судлагдаагүй. Экологи нь бусад эрээлжтэй ойролцоо байх магадлалтай.



АМЬДРАХ ОРЧИН

Нуур, голын эргийн дагуу тархан амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

ОХУ-ын хилтэй ойролцоох Увс нуурын сав газарт тэмдэглэгдсэн (Төв Азийн гадагш урсгалгүй ай сав).



DESCRIPTION

T. g. chandagaitensis is distinguished from the nominotypical subspecies by its shorter, conical (vs. cylindrical) head, in the absence of a hump before the nostrils, in the snout not being compressed laterally, in a relatively deeper body (its greatest depth usually contains 5.9–6.9 vs. 6.7–7.7 times in SL) and caudal peduncle (11–13 vs. 12–16 times in SL), in a relatively smaller eye diameter (mean 14.8% vs. 17.2% of head length) and greater interorbital width (mean 25.8% vs. 23.6% of head length), in much more developed connective tissue in the preorbital region and in the pectoral fin bases, in greater predorsal (mean 53.2% vs. 51.2% of SL) and pecto-ventral (31.8% vs. 27.4% of SL) distances, in shorter pectoral fins (1.7–2.0 times vs. 1.3–1.8 times in the pecto-ventral distance) and in a serrated free margin of the latter, in a less emarginated caudal fin, in the absence of the medial notch on the lower jaw, in a more sated overall coloration and in a more spotted body and fins. The number of spots of the main lateral row -14–18. The dorsal fin (D) has II-III unbranched soft rays, and 7-7 branched soft rays; the anal fin (A) has II unbranched soft rays, and 5-5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 10-12 branched soft rays; the pelvic (V) fins have I unbranched soft ray, and 6-7 branched soft rays.



BIOLOGY

The ecology of the Chandagaity's spotted thacklip loach has not been studied; its may be close to the ecology of other spotted thacklip loaches.



HABITAT

Inhabits sites near shore of lakes and rivers.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



DISTRIBUTION

Uvs Lake basin at the boundary with Russia (Central Asian Internal Drainage basin).

АРНОЛДЫН ТРИФЛОПИЗА

Triplophysa arnoldii Prokofiev, 2002
Arnoldi's spotted thicklip loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие зузаан, цилиндр хэлбэртэй. Биеийн үндсэн өнгө сааралдуу цагаан, толгой болон биеийн доод хэсэг цайвар, биеийн хажуугаар хоёр тууш эгнээ жигд бус хар толботой. Толгойн дээд болон хажуу тал маш шигүү бөөрөнхийдүү хар цоохор толботой. Нурууны, сүүлний болон цээжний сэлүүрүүд тод эгнээ бүхий хар толботой. Бие хайрсгүй, гэхдээ толгой болон хэвлий харьцангуй том үү мэт арьсан товгороор шигүү бүрхэгдсэн. Сүүлний бариул хажуугаасаа хавчиг, толгойн уртаас богино. Хоншоорын урт толгойн арын уртаас богино. Ам доод. Дээд уруул үргэлжилсэн, доод уруул тасархай. Доод эрүү хүрз хэлбэртэй. Хамрын нүх бие биентэйгээ ойр байрласан. Нурууны болон сүвийн сэлүүрийн үзүүр бараг шулуун. Хэвлийн сэлүүр нурууны сэлүүрийн суурийн харалдаа эсвэл бага зэрэг ард эсвэл сүвний амсарын архан талаас эхлэнэ. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 11(10), хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 7 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Маш жижиг агнуурын бус загас. Биеийн урт нь 70 мм хүрнэ. Үржлийн үед атуухын цээжний сэлүүрийн 5 салаалсан гуурс маш жижигхэн будаалга, нягт суурьшсан дэвүүр хэлбэрийн товгороор, мөн толгойн нүдний өмнө хэсэгт нүдний доод суваг орчим хоёр талаараа хучигдсан байдаг. Усны ёроолын шавьж, түүний авгалдай, ёроолын хөвөгч амьтадаар хооллодог.



АМЬДРАХ ОРЧИН

Голын эргийн хайрга чулуун ёроолтой хэсгээр тархан амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



ТАРХАЛТ

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын Ховд голын доод хэсгээр тархан амьдарна.



DESCRIPTION

Body is thick and cylindrical. The background coloration is grayish-white, lighter on the undersides of the head and the body, sides with two longitudinal rows of irregular dark blotches. The dorsal and lateral surfaces of the head are densely mottled with roundish dark spots. The distinct rows of the dark spots are evident on the dorsal, caudal and pectoral fin rays. The body is scaleless but densely covered with rather large wart-like epidermal tubercles distributed over the head and body including the ventral surface. The caudal peduncle is laterally compressed, shorter than the head. The snout length is shorter than the postorbital length of the head. Mouth inferior. The upper lip is continuous, the lower lip is interrupted. The lower jaw is shovel-shaped. The nostrils are closely spaced. The dorsal and anal fins show nearly straight distal edged. The pelvic fins are inserted on the same vertical with the dorsal fin origin or slightly behind it, and extend to or just behind the anus. The dorsal fin (D) has III unbranched soft rays, 7 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 11 (10) branched soft rays; the pelvic (V) fins have I unbranched soft ray, and 7 branched soft rays.



BIOLOGY

Very small non game species. Body length can reach up to 70 mm. Breeding males have 5 outer branched pectoral fin rays covered with extensive pads of minute, densely arranged, brush-like tubercles, also males possess a weakly delimited pad of minute granular tubercles on each sides of the preorbital region of the head above the infraorbital canal. Feeds on insect larvae, zooplankton, and eggs of fish.



HABITAT

Inhabits sites near shore of the rivers with gravel bottom.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



DISTRIBUTION

Lower reaches of the Khovd River of the Central Asian Internal Drainage basin.

ШИВЭР ЧИМХҮҮР ЗАГАС

Cobitis melanoleuca Nicols, 1925 = *C. taenia* & *C. taenia sibirica*
Siberian spiny loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие уртавтар, хавчиг, жижиг хайрсаар хучигдсан. Толгой хажуугаасаа хавчиг, нүцгэн. Бие цайвар шаргал, алтлаг. Биеийн хажуугаар 10-19 эгнээ том хар бор толботой бөгөөд заримдаа тод, эсвэл бүдэг өргөн зурвас үүсгэнэ. Сүүлний сэлүүрийн суурь хавьд хоёр бараан зууван толботой. 6 богино сахалтай; дөрөв нь хоншоорын үзүүрт, хоёр нь амны төгсгөлд. Нүдний доор хатгууртай. Нурууны сэлүүр ба сүүлний сэлүүр бараан толбон эгнээтэй. Ам доод, жижигхэн. Нурууны сэлүүр (D) салаалаагүй III, салаалсан 6-7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5-6 гуурстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 18 см хүрнэ. 2 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 6 сард усны температур 18°C болоход үржилд орж элсэнд түрсээ хэсэгчилэн шахна. Түрс том, түрсний голч 1.9-3.0 мм, шаравтар ногоон өнгөтэй. Усны ёроолын шавьж, хөвөгч амьтдаар хооллоно. Бусад махчин загасны хоол тэжээл болно.




АМЬДРАХ ОРЧИН

Гол мөрөн, горхи, нуурын гүехэн устай булан тохой, голын адаг, дөлгөөн урсгалт хэсгийн элсэн хурдсанд амьдарна.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрний сав, Орхон, Туул гол, Хөвсгөл нуур, Дархадын хотгорын нуур, голууд, Өгий нуурт, Номхон далайн ай савын Онон, Хэрлэн голын сав газар, Булган голд тархана.



DESCRIPTION

Body elongate, compressed, covered with minute scales. Head laterally compressed, naked. Body light yellowish, goldish. Has a row of 10-19 large, rounded dark brown spots, sometimes more or less conjugating into a wide streak. Have two dark brown ellipse spots on the base of the caudal fin. Barbels is short, its number is 6; four at the snout tip and two at the corners of the mouth. A collapsible spine under the eye. Dorsal fin short, its origin above the pelvic fins base. Caudal fin rounded. Dorsal and caudal fins with rows of dark speckles. Mouth inferior, small. The dorsal fin (D) has III unbranched soft rays, and 6-7 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5-6 branched soft rays.



CONSERVATION STATUS

Regionally Least Concern.



BIOLOGY

Small fish, non game species. Body length can reach up to 18 cm length. There are mature in 2 years old. Spawning in June when water temperature 18°C. Females lay eggs on sand. Eggs large, diameter - 1.9-3.0 mm, egg color is yellowish green. Feeds on insect larvae and zooplankton. It self is main food of piscivorous species.



HABITAT

Inhabits streams, and lower reaches of the rivers with slow-flowing water and sand bottom, and lakes with shallow bays.



DISTRIBUTION

The Selenga River Basin: Orkhon, Tuul rivers, and Ugi and Khuvsgul lakes; lakes and rivers of the Darkhad Depression; the Bulgan River (Arctic Ocean basin); and Onon and Kherlen rivers (Pacific Ocean basin).

ОЛИВЫН ЧИМХҮҮР ЗАГАС

Cobitis olivai Nalbant, Holcik & Pivnicka 1970

Olivai's spiny loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие шаргал-цагаан эсвэл цайвар шар. Толгой болон бие харьцангуй хавчиг, уртавтар. Нуруу болон биеийн хажуугийн дунд шугамын дагуух толбо нь элгэн хүрэн бор, бусад нь цайвар бор саарал. Нуруу 12-22 (гол төлөв 14-18) хэмжээгээрээ адилхан, маш тод тусгуурлагдсан толботой. Сүүлний сэлүүрийн урд хэсэгт нэг бөөрөнхий эсвэл гурвалжин хар толботой. Сүүлний сэлүүрийн суурийн дээд хэсгийн хар толбо нь хагас дугуй эсвэл судал мэт хэлбэртэй. Толгойн дээд болон хажуугийн хэсэг нь жижиг бор толбоор бүрхэгдсэн. Сүүлний бариул биеийн өндрөөсөө харьцангуй урт. Хошуу шөвгөр. Нүд жижиг, арьсаар хучигдсан. Ам доод, дээд уруул үргэлжилсэн, доод уруул тасархай. 6 сахалтай. Хэвлийн сэлүүр нурууны сэлүүрийн харалдаа байрлана. Сүвийн сэлүүрийн суурь богино хажуугийн зах нь гүдгэр. Сүүлний сэлүүр бөөрөнхий эсвэл огтолсон мэт. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II-III, салаалсан 6-7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 8-9, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 6 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 98 мм хүрнэ. Усны ёроолын шавьжийн авгалдай, хөвөгч амьтдаар хооллоно. Бусад махчин загасны хоол тэжээл болно.



АМЬДРАХ ОРЧИН

Жижиг гол, горхийн гүехэн устай булан тохой, томоохон голын адаг хэсгийн дөлгөөн урсгалт хэсгийн элсэн хурдсанд амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн ай савын Туул, Ерөө голд тархана.



DESCRIPTION

Body yellowish-white or light yellow. Head and body considerably compressed and elongated. The spots along dorsal and lateral mid-lines are chestnut brown, while the other mottles are light brownish gray. Back has 12-22 (usually 14-18) clearly delimited spots of approximately equal size. Single rounded or triangular darkish precaudal spot. The black spot at the upper part of the caudal fin base is present, usually semicircular or streak like in shape. The dorsal and lateral surfaces of head are marked by small brownish spots. Caudal peduncle much longer than deep of the body. Snout pointed. Eyes small covered with skin. Mouth inferior, upper lip continuous, lower lip interrupted. Have 6 barbels. Pelvic fins inserted below the dorsal fin origin. Anal fin with short base and convex distal margin. Caudal fin rounded or subtruncated. The dorsal fin (D) has II-III unbranched soft rays, and 6-7 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 8-9 branched soft rays; the pelvic fins (V) have I unbranched soft ray, and 6 branched soft rays.



BIOLOGY

Small fish, non game species. Body length can reach up to 98 mm. Feeds on benthic insect larvae and zooplankton. It self is main food of some piscivorous species.



HABITAT

Inhabits small rivers, and streams with shallow bays and lower reaches of big rivers with slow-flowing water and sand bottom.



CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.



DISTRIBUTION

Tuul and Orkhon rivers of the Arctic ocean basin

ЛЕБЕДОВЫН ЧИМХҮҮР ЗАГАС

Cobitis lebedevi Vasiljeva E.et Vasiljev V
Lebedevi's spiny loach



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие шаргал бор өнгөтэй. Толгой болон нүдний доод хэсгээр маш жижиг толботой. Нурууны сэлүүрийн өмнө 8 толботой бөгөөд адил хэмжээний толбо нурууны ар хэсэгт байрлана. Биеийн хажуу дунд хэсгээр 17 толботой. Нурууны болон хажуугийн толбонуудын хооронд хэлбэр дүрсгүй толбонууд байх бөгөөд энэ нь зурвас мэт харагдана. Толгой жижиг, биеийн уртын 20.8 хувийг эзэлнэ. Нурууны сэлүүр хэвлийн сэлүүрийн урдхан талаас эхэлнэ. Цээжний сэлүүр урт, шөвгөр. Сахал урт; хошууны сахлын урт толгойн уртын 13.5%, доод эрүүний сахлын урт толгойн уртын 19.1%-ийг, хамгийн арын сахал нүдний хөндлөн огтлолын зах хүрнэ. Сүүлний сэлүүрийн суурийн орчим 2 толботой бөгөөд дээд толбо нь хар, доод толбо нь цайвар өнгөтэй. Хайрс маш жижиг, зуйван. Хос сэлүүрүүд болон сүвийн сэлүүр цайвар, сүүлний сэлүүр 4, нурууны сэлүүр 3 зурвас нөсөөжилттэй. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй II, салаалсан 5, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 7, хэвлийн сэлүүр (V) салаалаагүй I, салаалсан 5 гуурстай.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус жижиг загас. Биеийн урт 68 мм хүрнэ. Усны ёроолын шавьжийн авгалдай, хөвөгч амьтдаар хооллоно. Бусад махчин загасны хоол тэжээл болно.



АМЬДРАХ ОРЧИН

Жижиг гол, горхийн гүехэн устай булан тохой, томоохон голын адаг хэсгийн дөлгөөн урсгалт хэсгийн элсэн хурдсанд амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

Онон голд тархана (Номхон далайн ай сав).



DESCRIPTION

Body yellowish brown. On head and under eyes very small spots. 8 spots before dorsal fin and in the same spots located behind it in the back. 17 spots along lateral mid-lines. Between the spots of the back and the mid-lines are scattered irregular spots detecting the tendency to form stripe. Head small, 20.8% of body length. Dorsal fin origin above the anterior base of the pelvic fins. The pectoral fins longer, tapering. Barbels are long; rostral barbels are 13.5% and mandibular barbels are 19.1% of head length; the last ones extend farther anterior edge of the eye. At the base of the caudal fin 2 spots, of which the upper is dark, and the lower is light. Scales very small, oval. Paired fins and anal fin light, the caudal fin has 4 and the dorsal fin 3 bands of pigment. The dorsal fin (D) has II unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has II unbranched soft rays, and 5 branched soft rays; the pectoral fins (P) have I unbranched soft ray, and 7 branched soft rays; the pelvic fins (V) have I unbranched soft ray, and 5 branched soft rays.

BIOLOGY

Small fish, non game species. Body length can reach up to 68 mm. Feeds on benthic insect larvae and zooplankton. It self is main food of some piscivorous species of fish.

HABITAT

Inhabits small rivers, and streams with shallow bays and lower reaches of big rivers with slow-flowing water and sand bottom.

CONSERVATION STATUS

Regionally Data Deficient.

DISTRIBUTION

The Onon River (Pacific ocean basin).

АМАРЫН МОГОЛЗОЙ

Misgurnus mohoity Dybowski, 1869

Amur weatherfish



ЕРӨНХИЙ ШИНЖ

Нуруу ногоовтор-хар, хоёр хажуу цайвар. Биеийн хажуугаар замбараагүй байрласан бараан толботой. Бие уртавтар, жижиг хайрсаар хучигдсэн. 10 сахалтай, 2 хос нь дээд, 2 хос нь доод эрүүнд, хос сахал завьжинд байрласан. Нүд жижиг. Нүдний доор хатгуур байхгүй. Нурууны сэлүүр богино, хэвлийн сэлүүрийн харалдаа байрласан. Сүүлний сэлүүр бөөрөнхий. Сүүлний сэлүүрийн суурийн дээд хэсэгт тод хар толботой. Нурууны сэлүүр (D) салаалаагүй II, салаалсан 7, сүвийн сэлүүр (A) салаалаагүй III, салаалсан 5 гуурстай. Хажуугийн шугам 105-180 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус загас. Биеийн урт 16 см хүрнэ. 2 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 5 сараас 6 сард үржилд орж түрсээ ургамалд шахна. Түрс боровтор шаргал өнгөтэй. Усны ёроолын шавьж, хөвөгч амьтдаар хооллоно. Бусад махчин загасны хоол тэжээл болно.




АМЬДРАХ ОРЧИН

Тогтмол намгархуу усанд амьдарна. Гол мөрний тогтуун урсгалт булан тохойн ургамал шавартай хэсэгт амьдарна.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Онон, Хэрлэн, Улз, Халх гол, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Back is grayish-black, sides are light. Dark speckles irregularly scattered on the sides of the body. Body elongate covered with small scales. Has 10 barbels: 2 pairs on the upper jaw, 2 pairs on the lower jaw and 1 pair at the corners of the mouth. Eyes small. No collapsible spine under the eye. Dorsal fin short, origin above the pelvic fins. Caudal fin rounded. Well distinct dark spot presents above the base of caudal fin. The dorsal fin (D) has II unbranched soft rays, and 7 branched soft rays; the anal fin (A) has III unbranched soft rays, and 5 branched soft rays. Lateral line with 105-180 scales.



CONSERVATION STATUS

Regionally Least Concern.



BIOLOGY

Non game species. Body length can reach up to 16 cm. They are mature in 2 years old. Spawning from May to June. Females lay eggs on vegetation. Eggs brownish yellow. Feeds on benthos insect larvae and zooplankton. It self is main food of some piscivorous species of fish.



HABITAT

Inhabits standing muddy water. Occurs in rivers with slow-flowing bays with vegetation and mud.



DISTRIBUTION

Onon, Kherlen, Ulz, and Khalkh rivers, and Buir Lake of the Pacific ocean basin.

АМАРЫН ЦУЛБУУРТ

Parasilurus asotus Linnaeus, 1758

Amur catfish



ЕРӨНХИЙ ШИНЖ

Толгой том, хавчгар, хошуу дугуй хэлбэртэй. Арьс хайрсгүй, нүцгэн. Ам том, эрүү, самалдагтаа шүдтэй. 2 хос сахалтай: 1 хос урт сахал дээд эрүүнд байдгаас цулбуурт гэдэг нэртэй болсон. 1 хос сахал доод эрүүнд байна. Нуруу, хажуу тал бор ногоон зүстэй, хэвэл цайвар. Нуруу, сүүл, сүв, хэвлийн сэлүүрүүд нурууны зүстэй ижил өнгөтэй. Нурууны сэлүүр маш бага, салаалаагүй гуурсгүй, хэвлийн сэлүүрийн суурийн урд харалдаа байрлана. Сүвийн сэлүүр урт, сүүлний сэлүүртэй нийлсэн. Сүүлний сэлүүр дугуй. Өөхөн сэлүүр байхгүй. Заламгайн өргөс 8-14. Нурууны сэлүүр (D) салаалсан 4-5, сүвийн сэлүүр (A) салаалсан 79-81, цээжний сэлүүр (P) салаалаагүй I, салаалсан 12-13, хэвлийн сэлүүр (V) салаалсан 10-12 гуурстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Ердийн цулбуурт нь 1 м, жин 8 кг хүрнэ. Биеийн урт 35.0-37.0 см хүрэхэд 4-5 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. 5-р сарын сүүлчээс 7-р сарын дунд хүртэл үржлийн үргэлжилнэ. Үржлийн үеийн усны температур 16-18°C. Түрсээ ургамал элбэгтэй хэсэгт дунджаар 0.5 м гүнтэй хэсэгт шахна. Атуу 22200-92700 дунджаар 54900 түрстэй. Ихэвчлэн агнуурын ач холбогдол багатай жижиг загас, усны шавьжийн авгалдай, хавчаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Тогтуун урсгалтай гол, нуурт тархан амьдарна. Нуур, голын эрэг орчмын ургамал элбэгтэй, лаг шаварлаг хурдастай ёроолын хэсгээр идээшлэнэ. Ёроолын амьдралын хэвшилтэй загас. Шөнийн цагаар идэвхитэй хооллодог махан идэшт загас.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуур, Оршуун, Халх, Онон, Хэрлэн гол тэдгээрийн цутгал голууд, жижиг нуураар тархан амьдарна. Оросын Холбооны Улсын Галуут нуурт 1940 онд нутагшуулсаны дүнд Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрнийг өгсөж Орхон, Хараа, Туул, Ерөө гол, Өгий нуурт тархах болсон.



DESCRIPTION

Head large, depressed, snout has rounded shape. Body without scales, naked. Mouth large, teeth on the jaws and on the palate. Have 2 pairs of barbels: pair on maxilla long and other pair on mandibula. Back and sides brown grayish, belly is light. Dorsal, caudal, anal and pelvic fins the same color with back. Dorsal fin very small, without a spiny ray, inserted before the pelvic fin base. Anal fin long, confluent with the caudal fin. Caudal fin rounded. No adipose fin. Number of gill rakers -8-14. The dorsal fin (D) has 4-5 branched soft rays; the anal fin (A) has 79-81 branched soft rays; the pectoral fins (P) have 1 unbranched soft ray, and 12-13 branched soft rays; pelvic fins (V) have 10-12 branched soft rays.



CONSERVATION STATUS

Regionally Least Concern. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from April 1st to June 15th of the following calendar year.



BIOLOGY

Can reach up to 1 m length, and weight 8 kg. Mature in 4-5 years old, when body length is 35.0-37.0 cm long. Spawning continues from May to July, with water temperature 16-18°C. Females lay eggs at 0.5 m deep water with high vegetation. Females produce 22,200-92,700, average 54,900 green eggs. Feeds mainly on small fish and larvae of insect.



HABITAT

It prefers slow-flowing rivers, and lakes. Lakes and rivers near shore with abundant aquatic vegetation and mud bottom. Prefers bottom style of life. It is active at night.



DISTRIBUTION

Buir Lake, Orshuun, Khalkh, Onon, and Kherlen rivers, its tributaries, and small lakes of the Pacific ocean basin. In 1940 introduced to Gucinoe Lake of Russia and self spread to Selenga, Orkhon, Kharaa, and Eruu rivers and Ugii Lake of the Arctic ocean basin in limits of Mongolia.

ГУТААРЬ

Lota lota Linnaeus, 1758

Burbot



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие уртавтар, хүчирхэг, арагшаагаа хавчгар. Биеийн дээд хэсэг шаргал бороос оливын хар, биеийн хажуу хар болон цайвар толботой, хэвлийн сэлүүр цайвар, бусад сэлүүрүүд хар толботой. Эрүүн дороо ганц сахалтай. Хайрс жижигхэн, циклойд хэлбэртэй. Толгой хавтгар өргөн. Эрүү, тагнайд өргөслөг шүдтэй. Нурууны болон сүвийн сэлүүр урт, нурууны сэлүүр цувраа 2 байх ба эхнийх богино, удаах уртассан. Сүүлний сэлүүр дугуй. Дээд эрүү доод эрүүн дээгүүр бага зэрэг давсан. Хажуугийн шугам бараг сүүлний сэлүүр хүртэл үргэлжилсэн. Заламгайн өргөс 5-15. Сэлүүрүүд салаалсан гуурстай. Нурууны эхний сэлүүр (D1) салаалсан 10-15 гуурс, 2 дахь (D2) сэлүүр 67-88 (93), сүвийн сэлүүр (A) 69-84, цээжний сэлүүр (P) 15-21, хэвлийн сэлүүр (V) 6-8 гуурстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг. Монгол Улсын Амьтны тухай хуулинд 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Гутаарь нь Саамхайтаны багийн цэнгэг усны ганц төлөөлөгч. Биеийн урт 1 м, жин 24 кг хүрнэ. 3 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Өвөл мөсөн дор үржинэ. Үржил 12-р сарын сүүлчийн хагасаас 2-р сар хүртэл үргэлжилнэ. Шөнө гүехэн устай хэсгийн цэвэр элс, хайрга, чулуун дээр түрсээ шахаад хараа хяналтгүйгээр орхидог. Атуу 20570-97840 ширхэг, дунджаар 63785 ш түрстэй. Шөнийн идэвхитэй махчин загас.




АМЬДРАХ ОРЧИН

Цэнгэг хүйтэн усны загас. Түргэн урсгалт гол мөрөн, өндөр газрын цэвэр жихүүн устай нуурт амьдарна. Зундаа гол төлөв голын эх хэсгээр идээшилнэ. Намартаа усны хэм багасахад голоо уруудан үндсэн голдоо амьдарна.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрний сав газрын нуур голууд, Тэрхийн цагаан, Өгий, Хөвсгөл нуур, Дархадын Доод Цагаан нуурт, Номхон далайн ай савын Хэрлэн, Онон, Оршуун, Халх гол, Буйр нуурт тархан амьдарна.



DESCRIPTION

Body elongate, rounded in anterior part and strongly compressed in posterior part. Coloration is yellowish brown to dark olive above, sides and unpaired fins with light and dark spots. Coloration very variable. Has single barbel on the chin. The scales are small and cycloid. Head broad and flat. On the jaws and on the palate have small setaceous teeth. Has two dorsal fins, first dorsal fin short, and second dorsal fin long and anal fin too. Caudal fin rounded. Upper jaw reaches posterior edge of the eye. Lateral line continuous until to the caudal fin. Gill rakers number - 5-15. The first dorsal fin (D1) has 10-15 rays, and second dorsal fin (D2) has 67-88 (93) rays; the anal fin (A) has 69-84 rays; the pectoral fins (P) have 15-21 rays; pelvic fins (V) have 6-8 rays.



CONSERVATION STATUS

Data Deficient. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from April 1st to June 15th of the following calendar year.



BIOLOGY

Burbot is only exclusively freshwater species in the cods order. Can reach up to 1 m length, and weight 24 kg. There are mature in 3 years old. Spawning in winter under ice, from late December to February. It spawns at night in shallow water on clean sand, gravel, or rocks. Females produce 20,570-97,840 eggs, average 63,785. Piscivorous. Burbot active at night.



HABITAT

Fresh cold water species. Inhabits rivers and streams with riffles, and cool clear waters in lakes of high land. In summer occurs at the upper reaches of the rivers. In autumn when water temperature decreases burbot moves to down habitats in main course of the river.



DISTRIBUTION

Lakes and rivers of the Selenga River basin, Terkhiin Tsagaan, Ugii, Khuvsgul lakes, and lakes of the Drakhad Depression (Arctic ocean basin); Kherlen, Onon, Khalkh rivers and Buir Lake (Pacific ocean basin).

ГОЛЫН АЛГАНА

Perca fluviatilis Linnaeus, 1758

European perch



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие хажуугаасаа бага зэрэг хавчгардуу. Нуруун тал хар ногоон, хоёр хажуу шаргал өнгөтэй. Биеийн хоёр хажуугаар 5-9 хөндлөн хар ногоон судалтай. Өргөслөг самлаг хатуу (ктеноид) хайрстай. Хайрс арьсанд маш бөх суусан. Толгой том. Эрүү, тагнайд олон эгнээ өргөслөг шүдтэй. Заламгайн хавхлаганы хойт зах шулуун хурц шөвгөр. Эхний нурууны сэлүүрийн төгсгөлд зууван хар толботой, хоёр дахь нурууны сэлүүр ногоон-шар өнгөтэй, хэвлий, сүв, сүүлний сэлүүрүүд улбар шар өнгөтэй. Заламгайн өргөс 16-29. Эхний нурууны сэлүүр хоёр дахь нурууны сэлүүрээсээ өндөр. Эхний нурууны сэлүүр (D1) салаалаагүй XIV-XVI хатгууртай, хоёр дахь нурууны сэлүүр (D2) салаалаагүй I-IV, салаалсан 12-17 гуурстай. Сүвийн сэлүүр (A) салаалаагүй II-III, салаалсан 7-11 гуурстай. Хажуугийн шугам бүтэн 53-74 хайрстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт анхааралд өртөхөөргүй. Монгол Улсын Амьтны тухай хуулинд зааснаар 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл агнах, барихыг хориглосон.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Голын алгана 42 см, 2 кг хүрнэ. Голын алгана 2 насандаа бэлгэ боловсорно. Үржил гол төлөв 4-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн хүртэл үргэлжилнэ. Түрсээ усны ургамал болон бусад субстратад шахна. Шахсан түрс нь туузархуу мэт харагдах ба яг л цэлцэгнүүр шиг. Түрсний тоо хэмжээ нь атуугийн биеийн хэмжээ, наснаас хамаарна. Атуу 9,500-67,700 мянган түрс гаргана. Түрсний голч 2-2.5 мм. Алгана хол нүүдэл хийдэггүй. Өсвөр насны алгана хөвөгч амьтад болон шавьжийн авгалдайгаар хооллоно. Бие гүйцсэн алгана жижиг загас, агнуурын болон агнуурын бус загасны жараахайгаар хооллоно. Алгана бүхий л жилийн турш идэвхитэй хооллодог. Зарим нуур, голд голын алгана нь идэш тэжээл болон өсөлтийн хурдаараа ялгаатай зүйл доторх хэлбэрийг (форм) үүсгэдэг.




АМЬДРАХ ОРЧИН

Тогтуун урсгалтай гол мөрөн болон нуурын ургамал элбэгтэй хэсэгт тархан амьдарна. Хурдан урсгалтай голоос зугтдаг. Өсвөр насны алгана ихэвчлэн сүрэглэн гүехэн, тогтуун урсгалтай хэсгээр тархан амьдарна. Бие гүйцсэн алгана гол төлөв усны гүн, задгай газарт ганц ганцаараа амьдардаг. Хавар, зуны улиралд эрэг бараадасхийж байгаад намар гүн тийш шилжинэ.



ТАРХАЛТ

Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ мөрний сав газрын нуур, голууд, Тэрхийн цагаан, Өгий, Хөвсгөл нуур, Булган голд тархан амьдарна.



DESCRIPTION

Body moderately compressed in sides. Back is black green; sides are yellowish, on side's 5-9 broad dark green vertical stripes. Body and cheeks covered by small ctenoid scales. Scales set very deeply. Head large. On jaws and on the palate have many rows setaceous teeth. Posterior edge of operculum has one straight spine. Preoperculum crenated on the back edge. End of the first dorsal fin has oval dark spot, and the second dorsal fin green yellow, and pelvic, anal, and caudal fins reddish orange. Gill rakers number is 16-29. The first dorsal fin high than second one. The first dorsal fin (D1) has XIV-XVI spines; second dorsal fin has (D2) I-IV unbranched soft rays, and 12-17 branched soft rays; the anal fin (A) has II-III unbranched soft rays, and 7-11 branched soft rays. Lateral line complete, with 53-74 scales.



CONSERVATION STATUS

Regionally Least Concern. In the Mongolian Law on Fauna hunting and trapping prohibitive from April 1st to June 15th of the following calendar year.



BIOLOGY

Can reach up to 42 cm length, and in weight 2 kg. European perch mature in 2 years old. Spawning usually occurs from April to early June. Spawning takes place on vegetation and possible on any other substrate. Laid eggs look as ribbon like gelatinous mass. The number of eggs produced is directly related to the size and age of the females. Females produce 9,500-67,700 eggs, diameter of eggs 2.0-2.5 mm. Perch not make far migrations. Young perch eat zooplankton and insect larvae. Adults feed on small fish, and fry of commercial and non game fish. It is active feed around the year. In some water bodies European perch generate intraspecific forms differing in diets and rate of growth.



HABITAT

Inhabits slow-moving rivers and lakes with abundant vegetation. European perch avoids to live in rivers with fast current. Young perch usually forms schools and occurs in shallow standing water. Adult perch generally live solitary in open and deep water along. In spring and summer it move shoreward and in fall they move into deep water.



DISTRIBUTION

Lakes and rivers of the Selenga River basin, Terkhiin Tsagaan, Ugii and Khuvsgul lakes, and the Bulgan River (Arctic ocean basin).

АМАРЫН ЗАНТГАР

Rhinogobius lindbergi Berg, 1933

Amur goby



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие уртавтар, хажуугаасаа бага зэрэг хавчигдуу. Бие шар, хажуугаараа 6-8 бараан том хар толботой, нуруу адилхан бараавтар толботой. Хошуу богино. Нүд том. Ам тэгш. Нурууны сэлүүр салангид. Нурууны болон сүвийн сэлүүр богиновтор, сүүлний сэлүүр дугуй. Хэвлийн сэлүүр цээжний сэлүүрээс богино. Нурууны эхний сэлүүр (D1) салаалаагүй VI, хоёр дахь сэлүүр (D2) салаалаагүй I, салаалсан 8-9, сүвийн сэлүүр (A) салаалаагүй I, салаалсан 8-9 гуурстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Агнуурын бус. Ёроолын жижиг загас, биеийн урт гол төлөв 4-5 см. 2 насандаа биеийн урт 20-22 мм хүрэхэд үржинэ. Салаа сахалт, сэлүүр хөлт хавч, жингэнүүр ялааны авгалдайгаар хооллоно.




АМЬДРАХ ОРЧИН

Нуур, голд тархан амьдарна. Голын эрэг орчмоор тархана.



ТАРХАЛТ

Халх голын доод хэсэг, Буйр нуурын харь зүйл.



DESCRIPTION

Body elongate, slightly compressed in sides. Body color is yellow, sides with 6-8 big dark spots, back same with darkish spots. Snout short. Eyes big. Mouth terminal. Dorsal fins separated. Dorsal and anal fins shorter, caudal fin rounded. Pelvic fins shorter than pectoral fins. The first dorsal fin (D1) has VI unbranched soft rays, and the second dorsal (D2) fin has I unbranched soft ray, and 8-9 branched soft rays, the anal fin (A) has I unbranched soft rays, and 8-9 branched soft rays.

CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.

BIOLOGY

Non game species. Bottom small fish. Body length usually 4-5 cm. They mature in 2 years old, about in 20-22 mm long. Feed on cladocers and copepods and on larvae of chironomids.

HABITAT

Inhabit lakes and rivers. Occurs in shore of rivers.

DISTRIBUTION

Recorded lower reaches of the Khalkh River and invasive species of the Buir Lake.

ТОГТМОЛЫН ЦООХЛОЙ

Percottus glenii Dybowski, 1877
Amur sleeper



ЕРӨНХИЙ ШИНЖ

Биеийн ерөнхий өнгө бараандуу, хэвлий цайвардуу шаргал буюу хажуу шаргал, бие бараан судал эсвэл хар зурвасуудтай. Заламгайн хавхлаг цэнхэр ногоон өнгөтэй, толгой дээр нүдний ард 2 эгнээ бараан судалтай. Биеийн урд хэсгээрээ зузаан бөөрөнхийдүү төгсгөл хэсэгтээ нарийссан. Нүд толгойн дээр байрласан, хоншоор бөөрөнхий, доод эрүү уртсаж дээд эрүүг давсан. Толгой нь дээрээсээ хавтгайвтар. Ам том. Сахал байхгүй. Доод эрүүн дээр 3 эгнээ шүдтэй. Бие циклоид хэлбэрийн хайрсаар бүрхэгдсэн. Заламгайн хавхлаг дээр өргөс хатгуургүй. Хэвлийн сэлүүр хоорондоо нийлээгүй байх бөгөөд үүгээрээ зантгар загаснаас ялгагдана. Хоёр дахь нурууны сэлүүр, сүвийн сэлүүрүүд дугуйрч төгссөн, зантгар загасныхаас богино, сүүлний сэлүүр бас дугуй. Нурууны 2 сэлүүрүүдийн хооронд багахан зайтай эсвэл зай байхгүй, эхний нурууны сэлүүрт (D) VI-VIII салаалаагүй, арын сэлүүр нь том 8-11 салаалсан гуурстай. Сүвийн сэлүүр I-III салаалаагүй, 7-10 салаалсан гуурстай.



ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт үнэлэх боломжгүй.



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Тогтмолын цоохлойн биеийн урт 25 см, хамгийн том нь 250 гр хүрнэ. 2 насандаа бэлгэ боловсорно. 6-р сараас 7 сар хүртэл ус 15-20°C хэмийн дулаантай болоход усны гүехэн хэсэгт ургамал дунд түрсээ шахна. Атуу 1000 ширхэг түрс гаргана. Атуух нь түрсээ хамгаална. 1950-иад оны үед Европод нутагшуулсаны дунд хаа сайгүй тархах болсон. Элдэв идэшт. Шавьж, тэдгээрийн авгалдай болон жижиг хэвч хэлбэртэн, загасны жараахай, ялангуяа агнуурын ач холбогдолтой загасны түрсийг их хэмжээгээр иддэг. Энэхүү загасны популяци нь байгалаасаа ховдог, юу ч хамаагүй иддэг тул нутгийн уугуул загасанд хохирол учруулдаг учраас анхаарал татаж байдаг.




АМЬДРАХ ОРЧИН

Нуур, цөөрөм, тогтуун урсгалтай гол, горхийн ургамал элбэгтэй, гүехэн хэсгээр зонхилон амьдарна. Тогтмолын цоохлой нь янз бүрийн нөхцөлд тэсвэртэй, амархан дасан зохицох чадвартай загас юм.



ТАРХАЛТ

Номхон далайн ай савын Буйр нуурын сав, Оршуун, Халх голд тархан амьдарна. Орос-Монголын хилийн ойролцоо Сэлэнгэ мөрнөөс баригдсан.



DESCRIPTION

The general color is brownish, belly light yellowish, sides yellowish and body with a darker marks or dark stripes. Operculum blue green, there are dark lines on the head radiating from the eye. Anterior part of the body thick rounder, compressed posteriorly. The eyes are placed high on the head which has a rounded snout and projecting lower jaw. Depressed head is plane on dorsal side. Mouth large. No barbels. On the lower jaw have 3 rows teeth. Body covered cycloid scales. No spine on the operculum. The pelvic fins are not fused together which helps to distinguish this fish from the gobies. The second dorsal and the anal fins are both more rounded and shorter than in gobies and the caudal fin is also more rounded. There is little or no gap between the two dorsal fins (D), the first one of which has VI-VIII spines and the large posterior with 8-11 soft rays. The anal fin (A) has I-III spines, and 7-10 soft rays.



CONSERVATION STATUS

Regionally Not Applicable.



BIOLOGY

This species can reach a length of 25 cm and the greatest recorded weight is 250 g. Amur sleeper matures in 2 years old. Spawning from June to July when water temperature 15-20°C. Females lay eggs among vegetation, and produce 1,000 eggs. Male guards the eggs. Amur sleeper occasionally introduced in the 1950's in Europe and wide spreading everywhere until now. Omnivorous. It feeds on insects and their larvae, small crustaceans and fish fry and eggs. Expansion of Amur sleeper are of concern as it could become detrimental to the local fauna due to its predatory nature and voracious appetite.



HABITAT

Its typical habitat is lakes and ponds, slow-moving rivers and streams. The Amur sleeper is an adaptable species and tolerant of widely different conditions, including water bodies with low oxygen concentration.




DISTRIBUTION

Buir Lake basin, the Khalkh River of the Pacific ocean basin. The Selenga River near the Russian-Mongolian boundary as invasive range (Arctic ocean basin).

ШИВЭР ЭРЭЭН ЖИВЭРТ

Cottus sibiricus Kessler, 1889
Siberian sculpin



ЕРӨНХИЙ ШИНЖ

Бие уртавтар, толгой, нуруу болон хажуугийн шугамын дээр ясархаг өргөсөөр битүү хучигдсан. Бие саарал, жижиг хар толботой. Толгой том, өргөн, хоёр хажуугаар хамрын 2 хос сүвтэй. Ам том, дээд доод тэнцүү, эрүүний урт нүдний дунд хүрнэ. Эрүүндээ жижиг шүдтэй. Нүд жижиг, толгойн дээд хэсэгт байрлана. Хэвлийн сэлүүр сүвийн сэлүүр хүрнэ. Бүх сэлүүрүүд хөндлөн хар зураастай. Нурууны сэлүүр 2, үргэлжилсэн. 2 дахь нурууны сэлүүр сүвийн сэлүүрээс урт. Нурууны сэлүүрийн (D1) эхнийх салаалаагүй VII-IX, 2 дахь нь (D2) салаалсан 16-19, сүвийн сэлүүр салаалаагүй 12-14(16) гуурстай. Сэлүүр хатгуургүй. Цээжний сэлүүр (P) 15-16 салаалаагүй гуурстай. Сүүлний (C) сэлүүр дугуй. Заламгайн өргөс 6. Хажуугийн шугам бүрэн



БИОЛОГИЙН ОНЦЛОГ

Шивэр эрэн живэртийн биеийн урт 20 см хүрнэ. 10 наслана. 4-6 насандаа бэлгэ боловсорч үржилд орно. Атуу 126-664 түрсийг хайрга чулуунд шахна. Атуух түрсээ хамгаална. Өсвөр насны загас нь гол төлөв усны ёроолын шавьж, шаамий хавч, хаварч, өдөрч, хоовгоноор хооллоно. Бие гүйцсэн загас нь ёроолын шавьж, загасаар хооллоно.



АМЬДРАХ ОРЧИН

Уулын ширүүн урсгалт голын эргийн хайрга, чулуун дор амьдарна.




ХАМГААЛЛЫН СТАТУС

Бүс нутагт мэдээлэл дутмаг.



ТАРХАЛТ

Тодорхойгүй. Магадгүй Хойд мөсөн далайн ай савын Сэлэнгэ, Орхон голд тархан амьдрах магадлалтай.



DESCRIPTION

